

ЖИНХЭНЭ ДАГАЛДАГЧ

Гарчиг

Өмнөх Үг

Удиртгал

Жинхэнэ дагалдагч

1. Дагалдагч байхын утга учир
2. Байгаа бүхнээсээ татгалз
3. Дагалдагч болоход учирдаг саад бэрхшээлүүд
4. Дагалдагч бол итгэмжит нярав юм
5. Хичээл зүтгэл
6. Итгэл
7. Залбирал
8. Сүнслэг тулаан
9. Дэлхийг эзэгнэх эрх мэдэл
10. Дагалдагч ба гэрлэлт
11. Төлөх үнийг тооц
12. Тарчлал зовлонгийн хар сүүдэр
13. Дагалдагч байхын хариу шагнал

Таны эд баялаг хаана байдаг вэ?

14. Таны эд баялаг хаана байдаг вэ?
15. Ажил хэрэгт хичээнгүй бай
16. Олж болно харин бүү зуур
17. Ямар хор хохиролтой вэ?
18. Үл хөдлөх эд хөрөнгө
19. Энэ талаар Библид юу гэж заадаг вэ?

ЭЗЭН МИНЬ, НАМАЙГ НОМХОРОУУЛААЧ!

20. Эзэн номхорсон зүрхийг илүү үнэлдэг
21. Бурхан биднийг номхорсон зүрхтэй байхыг хүсдэг

ӨМНӨХ ҮГ

Энэхүү номоор бид дагалдагчийн тухай Шинэ Гэрээний зарим зарчмыг онцлон гаргаж ирэхийг хичээв. Эдгээр зарчмуудыг бид Бурханы Үг болох Библиээс олон жилийн турш харсаар ирсэн ч манай өнөөгийн энэ ярвигтай эрин үед тохирохооргүй хэт туйлширсан, амьдралаас хол зүйл гэж дүгнэсээр ирсэн. Тиймээс ч энэ эрин үеийнхээ хүйтэн жихүүн сүнслэг байдалтай эвлэрч бууж өгсөн аж.

Гэтэл бид хэсэг залуустай танилцсан юм. Тэд Аврагч Есүсийн тодорхойлсон дагалдагч гэдэг нь маш бодит төдийгүй дэлхий ертөнцөд авралын зар тараахад тустай цорын ганц зүйл гэдгийг өөрсдийн биеэр үлгэрлэн үзүүлсэн билээ.

Энэхүү номонд онцлон дурдагдах олон үнэний амьд үлгэр жишээ болсон тэр залууст бид өртэй гэдгээ хүлээн зөвшөөрөх ёстой.

Эдгээр үнэнүүдийг бид өөрсдийн амьдралын туршлагаар баталж чадахгүй ч зүрх сэтгэлийн маань чин хүсэл эрмэлзлэл болгон танд өргөн барьж байна.

- Вильям Макдональд

УДИРТГАЛ

Аливаа хүн сүнсээр дахин төрөх үед жинхэнэ дагалдагч болох аян зам эхэлдэг. Хүн

- өөрийгөө Бурханы өмнө гэм нүгэлтэй, алдагдсан, сохор, нүцгэн гэдгээ ухаарах үед
- сайн зан чанар буюу сайн үйлсээр өөрийгөө аварч чадахгүй гэдгийг ойлгон хүлээн зөвшөөрөх үед
- Эзэн Есүс өөрийнх нь төлөө амиа өгч загалмай дээр өмнөөс нь нас барсан гэдэгт итгэх үед
- Есүс Христийг өөрийнх нь цорын ганц Аврагч мөн гэдгийг итгэлээрээ хүлээн зөвшөөрөх үед дагалдагч болох их аян зам эхэлдэг.

Хүн ингэж Есүст итгэгч болдог. Үүнийг хамгийн түрүүнд онцлон тэмдэглэх нь чухал. Итгэгч хүний амьдралаар амьдарвал итгэгч болж болно гэж боддог хүн их олон бий. Гэвч тийм биш ээ! Итгэгч хүний амьдралаар амьдрахаас өмнө эхлээд Есүст итгэгч болох ёстой.

Энэ номын дараа дараагийн хуудаснуудад дүрслэгдэн өгүүлэгдэх дагалдагч хүний амьдрал бол ер бусын амьдрал юм. Бид дагалдагч хүний энэ амьдралыг өөрсдийн хүч чадлаар амьдарч чадахгүй. Бидэнд тэнгэрлэг хүч хэрэгтэй бөгөөд бид сүнсээр дахин төрөх үедээ Есүсийн зааж сургасан амьдралаар амьдрах энэ хүчийг олж авдаг.

Та энэ номыг цааш нь үргэлжлүүлэн уншихаасаа өмнө “Би ер нь дахин төрсөн үү? Эзэн Есүст итгэх итгэлээр дамжуулан Бурханы хүүхэд болсон уу?” гэж нэг асуугаарай.

Хэрэв үгүй бол Есүсийг өөрийн Аврагч Эзэн болгон хүлээн авна уу. Тэгээд Түүний тушаасан бүхнийг ямар ч үнээр хамаагүй даган биелүүлнэ гэж зүрх сэтгэлдээ шийдэгтүн.

ДАГАЛДАГЧ БАЙХЫН УТГА УЧИР

Жинхэнэ Христэд итгэл гэдэг Эзэн Есүс Христэд өөрийгөө бүхэлд нь зориулах итгэл юм.

Чөлөөт цагаа эсвэл хагас бүтэн сайн өдрүүдээ эсвэл тэтгэвэрт суух он жилүүдээ өөрт нь зориулах эрэгтэй эмэгтэй хүмүүсийг Аврагч Эзэн хайдаггүй. Харин Түүнийг амьдралынхаа эн тэргүүнд тавих тийм хүмүүсийг эрж хайдаг.

Эзэн Есүс өнөөдөр мөн урьд өмнөх шигээ өөрийнх нь зам харгуй дээр бөөгнөрсөн ямар ч зорилгогүй хүмүүсийг биш харин зүрх сэтгэлээс нь шавхагдашгүй их үнэнч шударга байдал ундрэн гардаг, Эзэнийг дагахад бэлэн хүмүүсийг эрж хайсаар байгаа. Ийм хүмүүс өөрийн биеийг огоорон Эзэнийг дагах тэр замаар эхлээд Эзэн Өөрөө явж мөр гаргасан гэдгийг ухааран ойлгосон байдаг. (Г. А. Гопкинс)

Галготын толгой дээр Эзэн Есүсийн өргөсөн золиосны хариуд Түүнд үг дуугүй захирагдахаас өөр зохистой зүйл гэж үгүй. Тийм гайхалтай, тийм тэнгэрлэг агуу их хайрыг бид зөвхөн зүрх сэтгэл, аж амьдрал, байгаа бүхнээ Түүнд зориулж байж л хангаж чадна.

Эзэн Есүс Өөрийнх нь дагалдагч болох хүмүүст чанга хатуу шаардлага тавьдаг. Энэ бол байгаа бүхнээсээ татгалзах шаардлага бөгөөд энэ нь тансаг амьдралын энэ эрин үед байж боломгүй зүйл юм. Ихэнх тохиолдолд бид Христэд итгэлийг тамаас зайлж диваажинд очих баталгаа гэж үздэг. Түүгээр ч үл барам өөрсдийгөө энэ насны амьдралын сайн сайхан бүхнийг эдлэх эрхтэй гэж боддог. Дагалдагч байх тухай өгүүлсэн чанга хатуу ишлэлүүд Библид байдгийг бид мэддэг ч тэдгээр нь Христэд итгэлийн тухай бидний санаа бодолтой зөрчилдөх нь бий.

Цэрэг эрс эх орныхоо төлөө амь насаа өргөх нь байдаг л зүйл. Коммунистууд эсвэл лалын шашинтнууд амь насаа улс төрийн буюу шашны үзэл баримтлалын төлөө өргөх нь бидний хувьд хачин сонин зүйл огт биш ээ. Гэтэл Есүсийн дагалдагч хүний амьдрал “цус, хөлс, нулимс”-аар тодорхойлогдох ёстой гэдэг санаа нэг л хол, ойлгоход бэрх санагддаг..

Гэвч Эзэн Есүсийн хэлсэн үг тов тодорхой аж. Хэрэв бид түүний хэлсэн үгсийг шууд утгаар нь хүлээж авбал буруу зөрүү ойлгох зүйл огт гарахгүй. Хорвоо дэлхийн Аврагч Эзэн дагалдагч байхын утга учрыг хэрхэн гаргаж тавьсныг харцгаая.

ЕСҮС ХРИСТИЙГ ХАЙРЛАХ АГУУ ДЭЭД ХАЙР

“Хэрэв хэн нэг нь Над уруу ирж, өөрийн эцэг эх, эхнэр хүүхэд, ах эгч дүүсээ төдийгүй өөрийн амийг хүртэл үзэн ядахгүй бол тэр хүн Миний шавь байж чадахгүй” (Лук 14:26). Энэ бол садан төрлийнхөө хүмүүстэй

дайсагналцах буюу тэдэнд муу санах ёстой гэсэн үг биш харин Христийг хайрлах агуу их хайрын дэргэд бусад бүх хайр үзэн ядалт мэт байх ёстой гэсэн үг юм. Дээрх ишлэлийн хамгийн хэцүү хэсэг бол “*өөрийн амийг хүртэл*” гэсэн хэсэг ажээ. Дагалдагч хүнд хамгийн их саад болдог зүйл бол өөрийгөө хайрлах хайр юм. Бид өөрсдийн амийг Түүний төлөө өргөхөд бэлэн болохоос нааш Түүний хүссэн газар байж чадахгүй.

ӨӨРИЙГӨӨ ҮГҮЙСГЭ

“*Хэрэв хэн нэг нь Миний араас явахыг хүсвэл, тэр нь өөрийгөө үгүйсгээ. Загалмайгаа үүрч,.....*” (Матай 16:24). Өөрийгөө үгүйсгэх нь өөрөөсөө татгалзахтай адил биш ээ. Өөрөөсөө татгалзана гэж зарим нэг хоол хүнс, таашаал ба эд хөрөнгөөс татгалзахыг хэлдэг. Харин өөрийгөө үгүйсгэнэ гэдэг эдлэх эрх, мэдэл бүхнээсээ татгалзаж Христийн захиргаанд бүрэн орохыг хэлдэг. Энэ бол хаан ширээгээ шилжүүлж өгөхийн нэр юм. Үүнийг Хенри Мартин ийн илэрхийлж байжээ: “Эзэн минь, надад өөрийн гэсэн хүсэл зориг байхгүй болгооч. Эсвэл аз жаргалыг өөрт тохиолдох өчүүхэн зүйлтэй холбохгүй харин Таны хүсэл зоригтой нийцэх бүхэнтэй холбодог болгож өгөөч.”

Ялгуулсан Ялан дийлэгч, тэнгэрлэг Хаан минь
Үнэнч энэ гарыг минь Та атган аваач
Арай гэж бүх хүсэл зориг минь Таных боллоо
Аврагч Таны сэнтийн өмнө би баяртайгаар очно – Х. Г. К. Молл

ЗАГАЛМАЙГ ЗОРИУД СОНГО

“*Хэрэв хэн нэг нь Миний араас явахыг хүсвэл, тэр нь өөрийгөө үгүйсгээ. Загалмайгаа үүрч,.....*” (Матай 16:24). Загалмай бол бие эрхтний буюу оюун санааны ямар нэгэн хязгаарлагдмал байдал, зовлон зүдгүүр биш юм. Энэ бол бүх хүнд тохиолдож болох нийтлэг зүйл. Загалмай гэдэг зориудаар сонгосон харгуй зам юм. Энэ талаар К. А. Каутс ийн өгүүлжээ: “энэ зам дэлхий ертөнц оршин байгаа цагт гутамшиг, шившгийн зам байсаар байх болно.” Загалмай бол Бурханы Хүү дээр дэлхий ертөнцийн овоолсон мөн урсгал сөрөн сэлэхээр шийдсэн хүн бүрийн дээр овоолох ичгүүр, хавчлага, доромжлолын бэлэг тэмдэг юм. Дэлхий хийгээд дэлхийн замуудад өөрийгөө нийцүүлсэн итгэгч хүн л энэ замаар явахгүй байж чадна.

ХРИСТИЙГ ДАГАСАН АМЬДРАЛ

“*Хэрэв хэн нэг нь Миний араас явахыг хүсвэл, тэр нь өөрийгөө үгүйсгээ. Загалмайгаа үүрч, Намайг дагаг.*” (Матай 16:24). Энэ ямар учиртай болохыг ойлгохын тулд “Эзэн Есүсийн амьдрал юугаар тодорхойлогдож байсан бэ?” гэсэн асуултыг өөрөөсөө асуугаад үзээрэй. Түүний амьдрал Бурханы хүсэл зоригт захирагдсан дуулгавартай амьдрал байсан. Ариун Сүнсний хүчээр амьдарсан амьдрал байсан. Өөрийгөө умартан бусдад үйлчлэх амьдрал байсан. Хатуу ширүүн сорилтын өмнө тэсвэр, тэвчээрийг харуулсан

амьдрал байсан. Хичээл зүтгэл, өгөөмөр зан, өөрийгөө захирах, дөлгөөн байдал, энэрэл хайр, итгэлтэй байдал, үнэнч сэтгэлийг харуулсан амьдрал байсан (Галат 5:22-23). Итгэгч бид Есүсийн дагалдагч байхын тулд Түүнтэй адил амьдарч Христтэй адил зан чанарын үр жимсийг харуулах ёстой (Иохан 15:8).

ХРИСТТЭЙ ХОЛБООТОЙ БҮХНИЙГ ГАЛ ХАЛУУН ХАЙРААР ХАЙРЛА

“Хэрэв та нар бие биеэ хайрлах юм бол үүгээр чинь бүх хүн та нарыг Миний шавь нар мөн гэдгийг мэдэх болно” (Иохан 13:35). Энэ бол бусдыг өөрөөсөө өндөрт үнэлэх хайр. Үй олон гэм нүглийг далдлах хайр. “Хайр бол тэвчээртэй, энэрэнгүй юм. Хайр атаархдаггүй, бардам зан гаргадаггүй, ихэрхдэггүй, зохисгүй авирладаггүй, өөрийнхийг эрдэггүй, уурладаггүй, муутай тооцоо хийдэггүй, бүгдэд итгэдэг, бүгдэд найддаг, бүгдийг тэсвэрлэдэг” (1 Коринт 13:4-7). Энэ бол дагалдагч хүнд байвал зохих хайр бөгөөд ийм хайргүй бол дагалдагч гэдэг хүйтэн хөндий, ёс төдий, даяанч байх болно.

ҮРГЭЛЖ ТҮҮНИЙ ҮГЭН ДОТОР БАЙ

“Хэрэв та нар Миний үгэн дотор байвал үнэхээр Миний дагалдагчид байна” (Иохан 8:31). Жинхэнэ дагалдагч байхын тулд байнгын оролдлоготой байх ёстой. Дүрэлзэн асах их суу алдрын нөлөөгөөр гараагаа сайн эхлэх амархан. Гэвч жинхэнэ шалгуур бол эцсээ хүртэл тэвчих тэвчээр юм. *“Анжсан дээр гар тавьсан атлаа арагшаа харагч хэн боловч Бурханы хаанчлалд үл тэнцэнэ”* (Лук 9:62). Ариун Бичээсийн үгийг алдан онон дагана гэдэг тийм ч сайн зүйл биш. Христ өөрийг нь тогтмол, үг дуугүй дагах хүмүүсийг араасаа дагуулахыг хүсдэг.

Намайг буцаж явахаас хамгаалаач

Нулимс шингээсэн анжисны минь гар норжээ.

Зэвэнд идээдсэн хайчны маань ир мууджээ, гэсэн ч, бас гэсэн ч .

Бурхан минь, Бурхан минь, буцаж явахаас намайг хамгаалаач

– Нэр нь үл мэдэгдэх зохиолч

ЕСҮСИЙГ ДАГАХЫН ТУЛД БАЙГАА БҮХНЭЭСЭЭ ТАТГАЛЗ

“Иймээс та нарын хэн нь ч байгаа бүхнээсээ эс татгалзваас Миний шавь байж чадахгүй” (Лук 14:33). Дагалдагчийг тодорхойлсон Есүсийн тодорхойлолтуудаас мөн Библийн ишлэлүүдээс хамгийн бага яригддаг ишлэлүүдийн нэг бол магадгүй энэ ишлэл юм. Энэ ишлэл яагаад өгүүлж байгаагаасаа өөр утгатай болохыг ухаант мэргэн шашин судлаачид олон арга замаар тайлбарлаж чадна. Жирийн итгэгч хүмүүс Эзэн Есүс юун тухай ярьснаа өөрөө мэдэж байгаа гэж бодоод энэ ишлэлийг төвөггүй залгиж орхих биз. Байгаа бүхнээсээ татгалзана гэдэг юу ямар утгатай вэ? Энэ бол

үнэндээ сайн мэдээг тараахад хэрэглэж болох огтхон ч чухал биш материаллаг эд зүйлсээс татгалзана гэсэн үг. Байгаа бүхнээсээ татгалзсан хүн ямар ч чадваргүй гар хумхин суугч биш харин гэр бүлийнхээ болон өөрийн өнөөгийн хэрэгцээг хангахын тулд уйгагүй хөдөлмөрлөгч юм. Гэвч түүний амьдралын их хүсэл Христийн үйл хэргийг гүнзгийрүүлэхэд орших тул өнөөгийн хэрэгцээнээс илүү гарсан бүхнээ Эзэний ажил үйлсэд зориулж ирээдүйгээ Бурханд даатган өгдөг. Юуны өмнө Бурханы хаанчлал болон Түүний зөвт байдлыг хайдаг тийм хүн идэх хоол, өмсөх хувцсаар хэзээ ч дутахгүй гэдгээ мэднэ. Тийм хүн Сайн мэдээгээр цангасан хүмүүс мөхөж байхад илүүдэл зүйлсээс зуураад байж чаддаггүй аж. Ийм хүн ариун хүмүүсээ авахаар Христийг буцаж ирэх үед хорон муу хүмүүсийн гарт үлдэхэд баялаг хуримтлуулахад амьдралаа үрэхийг хүсэхгүй. Тэрээр газар дэлхий дээр эд баялаг хураахгүй байхыг тушаасан Эзэний тушаалыг даган биелүүлэхийг хүснэ. Байгаа бүхнээсээ татгалзсан хүн Давид Ливингстоунтай адилаар “Дахиад өгөх юм надад байхгүй нь харамсалтай” гэж хэлж чаддаг. .

Энэ бол Есүсийн дагалдагч байхын долоон утга учир юм. Эдгээр нь нэн ойлгомжтой агаад тодорхой аж. Зохиогч миний бие эдгээрийг гарган тавьж байхдаа ямар ч ашиг тусгүй зарц мөн гэдгээ ухаарч өөрийн биеийг яллан буруутгаж байсан. Гэвч Бурханы хүмүүсийн алдаанаас болж Бурханы үнэн үүрд мөнх дарагдах ёстой гэж үү? Үг нь үгийг дамжуулж буй хүнээс илүү хүчтэй биш гэж үү? Бурхан бол үнэн харин хүн бид худалч биш гэж үү? “Надад тустай биш байсан ч Таны хүсэл биелэгдэх болтугай” гэсэн үг байдаг. Үүнтэй бид санал нийлэхгүй гэж үү?

Одоо бүгдээрээ өнгөрсөн алдаагаа гэмшин хүлээж бидний талаар хэлсэн Есүсийн үгтэй зоригтойгоор нүүр тулан энэ мөчөөс эхлэн алдарт их Эзэний жинхэнэ дагалдагч байхыг хичээцгээе.

Хоёрдугаар бүлэг

БАЙГАА БҮХНЭЭСЭЭ ТАТГАЛЗ

“Иймээс та нарын хэн нь ч байгаа бүхнээсээ эс татгалзваас Миний шавь байж чадахгүй.” (Лук 14:33)

Эзэн Есүсийн дагалдагч байхыг хүссэн хэн боловч байгаа бүхнээсээ татгалзах ёстой. Энэ бол Аврагч Эзэний хэлсэн үгний андуурч ойлгохын аргагүй гол утга юм. Дэндүү “туйлширсан” гэмээр энэ шаардлагыг бид хичнээн эсэргүүцсэн ч, “боломжгүй” мэт эсвэл “шударга бус” гэмээр ийм бодлогыг хичнээн сөрсөн ч энэ бол Эзэний үг мөн. Эзэн чухам энэ үгээрээ хэлэх гэсэн санаагаа бүрэн илэрхийлсэн юм.

Эхлээд, энэ үгэнд илэрхийлэгдсэн нугаршгүй бат үнэнүүдийг үзэцгээе:

Есүс үүнийг Христэч итгэлтэй үнэнч хэдэн ажилтнуудаас шаардаагүй ээ. Тэрээр *“та нарын хэн ч...”* гэж хэлсэн.

Есүс бас биднийг байгаа бүхнээсээ татгалзахад бэлэн байх хэрэгтэй гээгүй. Харин *“та нарын хэн нь чэс татгалзваас...”* гэсэн.

Есүс бас биднийг эд баялгийнхаа нэг хэсгээс татгалзах ёстой гээгүй. Харин *“та нарын хэн нь ч байгаа бүхнээсээ эс татгалзваас....”* гэсэн.

Есүс хэлэхдээ эд баялгаасаа салахгүй зуурдаг хүн дагалдагч нэртэй байж болох тухай хэлээгүй. Харин *“Миний шавь байж чадахгүй.”* гэсэн.

Гэвч бид Библид үүнээс өөр ийм хатуу шаардлага огт байхгүй мэт үзэж гайхах хэрэггүй.

Есүс ингэж хэлээгүй гэж үү: *“Газар дээр өөрсдөдөө эд баялаг бүү хураа. Тэнд хивэн хорхой болоод зэв идэж сүйтгэдэг, хулгайч эвдэж ороод хулгайлан авдаг аж. Харин тэнгэрт эд баялгийг өөрсдөдөө хураа. Учир нь тэнд хивэн хорхой болоод зэв идэж сүйтгэдэггүй, хулгайч ч эвдэж ордоггүй, хулгайлдаггүй”* (Матай .6:19-20).

Энэ талаар Жон Уислигийн онож хэлсэн нэг үг бий: *“Эзэн маань газар дээр эд баялаг хураахыг завхайрах, хүний амь хөнөөхтэй адил хоригложээ”*

Есүс бас *“Өмч хөрөнгөө худалдаад өглөг үйлд”* (Лук 12:33) гэж хэлээгүй гэж үү? Чинээлэг залуу захирагчид хандан: *“Эзэмшиж байгаа бүхнээ худалдаж, ядууст тарааж өг. Тэгвэл чи тэнгэрт баялагтай болно. Тэгээд ирж, Намайг дага”* (Лук 18:22) гэж бас хэлсэн биш үү? Тэрээр үүнийг үнэхээр чухал гэж үзсэн учир тийнхүү хэлсэн хэрэг.

Эртний чуулганы итгэгчид *“эзэмшил, өмч хөрөнгөө худалдаж, түүнийгээ хүн бүрийн хэрэгцээг харгалзан бүгдэд түгээдэг”* (Үйлс 2:45) байгаагүй гэж үү? Олон зууны турш Бурханы олон арван ариун хүмүүс Есүсийг дагахын тулд байгаа бүхнээсээ жинхэнэ ёсоор татгалзаж байгаагүй гэж үү?

Эрт үед Багдадад эхнэрийнхээ хамт сайн мэдээ дэлгэрүүлдэг байсан Антони Норрис Гроув *“газар дээр эд баялаг хураахгүй байж, үндсэн орлогоо бүхлээр нь Эзэний үйлчлэлд зориулах ёстойг”* ойлгож ухаарсан гэдэг. Тэрээр энэ тухайгаа *Христэд итгэгчийн үнэнч зориулалт (Christian Devotedness)* номондоо бичсэн байдаг.

Ч. Т. Стадд бүх эд хөрөнгөө Христэд өгч Библид гардаг чинээлэг залуу захирагчийн хийж чадаагүй зүйлийг хийх алтан боломжийг ашиглахаар шийдэж байжээ. Энэ бол Бурханы Үгэнд өгүүлсэн хар цагаан ямар ч тушаалд захирагдах дуулгавартай байдал юм.

Тэрээр Эзэний ажилд хөрөнгөөсөө олон мянгыг тараан өгснийхөө дараа сүйт бүсгүйдээ зориулж 9588 доллартой тэнцэх хэмжээний мөнгө хадгалж үлдсэн байлаа. Гэвч эхнэр нь нөхрөөрөө ингэж харж үзүүлэхийг хүссэнгүй. Тиймээс “Чарли, Эзэн чинээлэг залууд юу гэж хэлсэн билээ?” гэж асуухад нөхөр нь

“Байгаа бүхнээ худалд” гэсэн хэмээн хариулжээ. Гэтэл эхнэр нь:

“За тэгвэл хоёулаа хуримаа Эзэн дээрээс тэгээс эхэлье” гэсэн гэдэг. Ингээд нөгөө мөнгө Христэд итгэлийн сайн мэдээ дэлгэрүүлэх үйлсэд зориулагдсан юм.

Жим Эллиот ч бас үүнтэй адил үнэнч зориулалтаар хөглөгдөн ажиллаж байсан. Тэрээр өдрийнхөө тэмдэглэлд ийн бичсэн байжээ:

Эцэг минь, түр зуурын аливаа зүйл бүрээс зуурч чадахааргүй болтол намайг сул дорой болгооч. Амь амьдрал, нэр хүнд, эд хөрөнгө энэ бүхнээсээ зуурах гарын минь хүчийг сулруулаач Аливааг хайрлан энхрийлэх дур хүслийг минь бууруулаач. Ямар ч “гэм зэмгүй” мэт санагдах зүйлийг өөртөө хадгалж үлдэхийн тулд зарим нэг зүйлийг чанга атгаж байсан гараа сулруулж байсан удаа надад олон бий. Энэ бүхний оронд Голготын толгод дээрх загалмайн хадаасыг Христийн гар хэрхэн хүлээн авсны адил тэр хадаасыг тосон авахаар алгаа дэлгэхэд минь туслаач. Намайг зууран барьж байгаа бүхнээс өөрийгөө салгахын тулд өөрийнхөө зууран барьж байгаа бүхнээ тавихад минь туслаач. Есүсийн бодол санаа бүхэн бидний зууралддаг эд зүйлд биш харин Эцэг Бурхан Та болон Таны мөнхийн улс руу чиглэгдэж байсан. Үүнтэй адилаар миний атгыг суллаач.

Аливаад үл итгэгч зүрх сэтгэл маань бидэнд Эзэн Есүсийн үгийг шууд утгаар нь ойлгох аргагүй гэж ойлгуулдаг. Хэрвээ байгаа бүхнээсээ татгалзах аваас өлсөж үхэх болно. Ер нь ч тэгээд бид өөрсдийнхөө бас хайртай хүмүүсийнхээ ирээдүйг бодох ёстой. Хэрэв итгэгч хүн бүр байгаа бүхнээсээ татгалзах юм бол Эзэний ажлыг хэн санхүүжүүлэх билээ? Итгэгч хүмүүсийн дунд зарим нэг чинээлэг итгэгч хүн байхгүй бол дээд зиндааны хүмүүст сайн мэдээг яаж хүргэх вэ? гэх мэтээр Эзэн Есүсийн хэлсэн үг үнэн хэрэгтээ тийм утгатай байгаагүй гэдгийг батлах гэсэн маргаанууд хойно хойноосоо цувран гардаг.

Гэвч баримт бол баримт. Эзэний тушаалуудад дуулгавартай захирагдан амьдрах амьдрал бол хамгийн эрүүл саруул, утга учиртай бөгөөд хамгийн их баяр хөөрийг авчирдаг амьдрал. Христийн төлөө амь амьдралаа зориулсан ямар ч хүн аливаа зүйлээр дутагдан гачигдаж байгаагүйг Библи болон өөр олон хүний амьдралын туршлага нотолно. Бурханд дуулгавартай захирагдан амьдарч буй хүний хэрэгцээг Эзэн ивээлдээ авч бүрэн хангаж өгдөг.

Христийг дагахын төлөө байгаа бүхнээсээ татгалзсан хүн бол итгэгч ах дүүгийнхээ тусламж дэмжлэгт найдан амьдардаг арчаагүй ядуу хүн огт биш юм. Харин:

Тэр бол ажилч хичээнгүй хүн. Тэрээр өөрийн болон ар гэрийнхээ хүмүүсийн өнөөгийн хэрэгцээг хангахын тулд хичээнгүй хөдөлмөрлөдөг.

Тэр бол арвигч хямгаач хүн. Тэрээр наад захын хэрэгцээнээс давж гарсан бүхнийг Эзэний үйлсэд зориулахын тулд аль болох хямгатай амьдардаг.

Тэр бол алсын хараатай хүн. Тэрээр газар дээр эд хөрөнгө цуглуулахын оронд тэнгэрт эд баялаг хураадаг.

Тэрээр ирээдүйгээ Бурханд найдан даатгадаг. Нас өндөр болсон хойноо хэрэглэх эд зүйл цуглуулахад амьдралынхаа хамгийн сайхан үеийг зориулахын оронд Христийн үйлчлэлд хамгийн сайн сайхан зүйлээ өгч ирээдүйгээ Түүнд даатгадаг. Ийм хүн эхлээд Бурханы хаанчлал ба Түүний зөвт байдлыг хайвал идэж уух, өмсөж зүүхээр хэзээ ч дутахгүй гэдгээ мэддэг (Матай 6:33).

Гачигдах үедээ хэрэглэнэ хэмээн эд хөрөнгө хураана гэдэг ийм хүнд огт ойлгомжгүй зүйл. Түүний хувьд:

олон хүний амийг аврахад хэрэглэж болох мөнгийг сэтгэл амар хурааж цуглуулна гэдэг байж боломгүй хэрэг. *“Дэлхийн эд хөрөнгөтэй хэн нэгэн нь өөрийн ах дүүгийн хэрэгцээ, гачигдлыг хараад түүнд туслах сэтгэл үл гаргавал, түүний дотор Бурханы хайр хэрхэн байх билээ?”* (1 Иохан 3:17).

“Харин хөршөө өөрийн адил хайрла” (Левит 19:18) гэсэн нэгэн чухал тушаалыг дахин нэг удаа тунгаан бодно уу. Айлынхаа хүнийг өлөн зэлмэн явахыг харах атлаа өөрөө идэж уухаар элбэг дэлбэг, хурааж цуглуулсан зүйл ихтэй хүн хөршөө өөрийн адил хайрладаг гэж сэтгэл амар хэлж чадна гэж үү? Үгээр илэрхийлшгүй Бурханы их ивээлийг мэдэж авахын агуу их баяр хөөрийг өөрийн биеэр амссан хүнээс *“Энэ мэдлэгээ мянган дэлхийгээр ч солихгүй биз дээ”* хэмээн асуух ч хэрэггүй биз ээ. Тэгэхээр, бусад хүмүүс тэнгэрийн орны агуу тайтгарал болон сэтгэлийг бүрэн хангагч энэхүү гайхамшигт мэдлэгийг олж авахад тусалж болох эд зүйлсийг харамлахгүй байцгаая!

Хэрэв бид Эзэн Есүс энэ дэлхий дээр тун удахгүй ирэх гэж байгааг мэдвэл хурааж цуглуулсан мөнгө төгрөгөө даруй хэрэглэж эхлэх биз ээ. Эс бөгөөс өнө мөнхийн ивээлд хэрэглэж болох байсан мөнгийг бузар муугийн гарт алдах болно.

Бидэнд Христийн үйлсэд зориулах мөнгө байсаар атал түүнд зориулах хүсэлгүй мөртлөө Эзэнээс энэ үйлсийг мөнгө санхүүгээр хангаж өгөөч хэмээн ичих ч үгүй гуйн залбирч чадна гэж үү? Христийн төлөө байгаа бүхнээсээ татгалзах нь хоёр нүүр гарган залбирахаас биднийг аврах болно.

Бид Бурханы бүхэл зөвлөгөөг өөрсдөө дуулгавартай дагаж чаддаггүй атал энэ тал дээр дуулгавартай байхыг бусдад заан сургаж чадна гэж үү? Ийм тохиолдолд өөрсдийн маань үйлс амыг маань таглах болно.

Энэ дэлхийн ухаантай хүн ирээдүйгээ баталгаажуулахын тулд их хэмжээний зүйл хураан цуглуулдаг. Энэ бол итгэлээр биш харин харж байгаа зүйлээрээ амьдарч буй хэрэг юм. Итгэгч хүн Бурханд бүрэн түшиглэн амьдрахаар дуудагдсан байдаг. Гэсэн атал газар дэлхий дээр эд хөрөнгө хураавал энэ дэлхий болон дэлхийн арга замуудаас юугаараа ялгарах билээ?

Бид ар гэрийнхээ ирээдүйн хэрэгцээг хангах ёстой, эс бөгөөс итгэл

бишрэлгүй хүмүүсээс долоон дор болох болно гэж маргах хүн олон бий. Тэд энэ санаагаа дэмжихэд доорх хоёр ишлэлийг ашигладаг:

“Учир нь хүүхдүүд эцэг эхийнхээ төлөө биш, харин эцэг эх нь хүүхдүүдийнхээ төлөө баялгийг хураах ёстой” (2 Коринт 12:14)

“хэрэв хэн нэгэн нь өөрийнхнийгөө, ялангуяа төрсөн гэр бүлийнхээ хүмүүсийг тэтгэхгүй байвал тэр хүн итгэлийг үгүйсгэсэн хэрэг болох бөгөөд итгээг бус хүнээс ч бүр дор юм” (1 Тимот 5:8).

Энэ хоёр ишлэлийг сайн судалж үзвэл *ирээдүйн байдлыг* биш харин *өнөөгийн буюу одоогийн байдлыг* өгүүлсэн болохыг харж болно.

Эхний ишлэлд Паул Коринт хотын итгэгчдийг хүүхдүүд, өөрийгөө тэдний эцэг хэмээн егөөдөн бичжээ. Тэрээр Эзэн Есүсийн зарц үйлчлэгчийн хувьд мөнгө санхүүгээр тэтгүүлэх бүрэн эрхтэй байсан ч тэдэнд энэ ачааг үүрүүлээгүй. Үнэндээ бол Паул тэдний итгэлийн эцэг байсан ба ер нь хүүхдүүд нь эцэг эхээ биш харин эцэг эх нь үр хүүхдүүдийнхээ хэрэгцээг хангадаг жамтай. Эцэг эх нь үр хүүхдүүдийнхээ ирээдүйг бодох талаар энд яриагүй. Энэ ишлэл бүхэлдээ Паулын ирээдүйн хэрэгцээг хангах талаар биш харин түүний тухайн үеийнх нь хэрэгцээг хангах талаар өгүүлж байгаа ажээ.

1 Тимот 5:8-д элч Паул тарчиг амьдралтай бэлэвсэн эхнэрийн тохиолдлын тухай өгүүлжээ. Ийм эхнэрүүдийг садан төрлийнх нь хүмүүс хариуцах ёстой аж. Хэрэв тухайн бэлэвсэн эхнэрт садан төрлийн хүмүүс байхгүй бол эсвэл байсан ч тэд хариуцлагаа биелүүлдэггүй бол тэр бэлэвсэн итгэгч эхнэрийг нутгийн чуулган харж хандах ёстой. Энд бас л түүний ирээдүйн биш тухайн үеийнх нь хэрэгцээ яригдаж байна.

Христийн биеийн гишүүд нэг нэгнийнхээ өнөөгийнх нь хэрэгцээнд анхаарал тавих нь Бурханы туйлын зорилго юм.

Энэ бол “би чамд, чи надад” гэсэн утгатай. Өнөөдөр чи өөрт байгаа их зүйлээрээ бусдад тусалбал ирээдүйд тэд өөрсдөдөө байгаа их зүйлээр чамд туслах болно. Библид: *“Ихийг хураасан хүнд нь илүүдсэнгүй, багыг хураасан хүнд нь дутсангүй”* (2 Коринт 8:15) гэсэн байдаг. Түүнчлэн бид өөрт байгаа зүйлээ нэг нэгэнтэйгээ хуваалцах аж.

Уг сэдвээр бид энэхүү номын арван наймдугаар бүлэгт илүү дэлгэрэнгүй ярилцах болно.

Ирээдүйн хэрэгцээгээ хангах ёстой гэж боддог итгэгч хүн хэр ихийг хураахад хүрэлцэх бол гэсэн өөр нэг асуудалтай тулгардаг. Тиймээс тодорхой бус хэмжээний эд хөрөнгө олж цуглуулахад бүх амьдралаа үрэхийн зэрэгцээ хамгийн сайн гэсэн зүйлээ Эзэн Есүс Христэд өгөх агуу их эрхийг эдэлж чадалгүй алддаг. Ингээд дэмий үрсэн амьдралынхаа эцэст хэрэв Аврагч Эзэнд бүх зүрх сэтгэлээ зориулан амьдарсан бол хэрэгцээ нь аяндаа хангагдах байсныг олж мэдэх ажээ.

Хэрэв итгэгч хүн бүр Эзэн Есүсийн үгийг шууд утгаар нь ойлгож хэрэгжүүлдэг байсан бол Эзэний үйлс санхүүгийн бэрхшээлтэй огт тулгарахгүй байх байсан. Сайн мэдээ ч асар хүчтэйгээр, өргөн цар хүрээтэй

тархах байсан. Аль нэг итгэгч хүнд гачигдал гарлаа гэхэд энэ нь бусад итгэгчдийн хувьд өөрт байгаа зүйлээ түүнтэй хуваалцах их аз завшаан, баяр хөөр болох байсан.

Баян чинээлэг хүмүүст сайн мэдээг хүргэхийн тулд баян чинээлэг итгэгч хүмүүстэй байх ёстой гэдэг үнэндээ дэмий хэрэг. Паул шоронгийн хоригдол байхдаа Цезарийн гэр бүлд сайн мэдээг хүргэсэн. (Филиппой 4:22). Хэрэв бид Бурханыг дуулгавартай дагавал энэ хэргийг Бурхан бас шийдэж чадна гэдэгт итгэх болно.

Эзэн Есүсийн жишээ энэ хэргийн эцсийн шийд болж чадна. Зарц нь эзнээсээ агуу биш юм. Жорж Мьюллер ингэж бичиж байжээ: “Өөрийнх нь Эзэний тарчиг ядуу, зовж зүдрэн, гадуурхагдан амьдарч байсан ертөнцөд зарц нь баян цатгалан, агуу хүчирхэг, нэр хүндтэй болохыг хичээнэ гэдэг мунхаг хэрэг”

Христийн амссан зовлон дунд ядуу тарчиг байхын зовлон багтаж байсан (2 Коринт 8.9). Ядуу тарчиг байна гэдэг заавал ноорхой хувцастай, хир буртагтай байхын нэр биш харин баян тансаг амьдрахад шаардагдах хуримтлал, хөрөнгийн эх үүсвэргүй байхыг хэлдэг... Хэрэв Эзэн Есүс болон Түүний элч нар үнэндээ ядуу зүдүү байгаагүй бол хийж бүтээсэн тэр зүйлээ хийж чадахгүй байх байсан гэж Андрию Маррей дүгнэсэн байдаг. Өөр нэгнийг өөд нь өргөхийг хүссэн хүн самари хүн шиг өөрөө доошоо орох ёстой. Хүн төрөлхтний ихэнх хувь нь урьд өмнө ядуу тарчиг хүмүүс байсан одоо ч тийм байгаа.

Хүмүүс гэр орны ахуйн хэрэгцээнд заавал зарим нэг эд материал хэрэгтэй гэдэг. Энэ үнэн.

Хүмүүс, итгэгч бизнесмэн хүнд бизнесээ авч явах тодорхой хэмжээний хөрөнгө хэрэгтэй гэдэг. Энэ үнэн.

Хүмүүс бас Бурханыг алдаршуулахад автомашин зэрэг эд материал хэрэгтэй гэдэг. Энэ ч бас үнэн.

Гэвч итгэгч хүн энэ бүх зүй ёсны хэрэгцээнээс гадна сайн мэдээг дэлгэрүүлэхийн тулд арвиг хямга амьдрах ёстой. Тэрээр “Их хөдөлмөрлө, бага үр, ихийг өг – энэ бүгдийг Христийн төлөө хий” гэсэн уриатай байх нь чухал. (Э. Н Гроув)

Байгаа бүхнээсээ татгалзах тал дээр итгэгч хүн бүр Бурханы өмнө хариуцлага хүлээдэг. Энэ тал дээр нэг нь нөгөөдөө зааж болохгүй бөгөөд хүн бүр Эзэн түүнд үүнийг яаж ойлгуулна түүнчлэн үйлдэх учиртай. Энэ бол цэвэр хувийн чанартай асуудал юм.

Эзэн Есүс бидэнд байгаа бүхнээсээ татгалзах гэж чухам юу болохыг ойлгуулах үед энэ нь биднийг урьд өмнө огт бодож байгаагүй тийм хэмжээний үнэнч зориулалтад чиглүүлж болох ба ийм үед бардам сэтгэл багтах орон зай байхгүй болдог. Ямар ч золиос Голготын толгой дээр Эзэн Есүсийн өргөсөн золиосны дэргэд юу ч биш байх болно. Ер нь ч тэгээд бид өөртөө байлгаад байж болохгүй зүйлсээ, эрт орой хэзээ нэгэн цагт хэрэггүй болох тийм л зүйлсээ Эзэнд өгч байгаа хэрэг.

Гуравдугаар бүлэг

ДАГАЛДАГЧ БОЛОХОД УЧИРДАГ СААД БЭРХШЭЭЛҮҮД

Эзэн Есүсийг дагахаар шийдсэн аливаа хүний замд олон саад бэрхшээл заавал гарч ирдэг. Замаасаа гажих олон шалтаг гарч ирнэ. Янз бүрийн өөр дуу хоолой түүнийг дуудаж үүрч яваа загалмайнаасаа тайрч хаяхыг ятгах болно. Өөрийн таашаалаас татгалзан Есүсийн төлөө өөрийгөө золиослон амьдрах амьдралаар амьдруулахгүйн тулд түүнийг далдын олон хүч анан харж байх болно.

Есүсийн дагалдагч болж болох байсан ч өөр бусад дуу хоолойг илүү их сонссон гурван хүний амьдралын жишээ үүнийг тод харуулжээ.

“Тэднийг замд явж байтал хэн нэг нь Түүнд —Би Таныг хаа ч явсан дагая гэв. Есүс түүнд —Үнэгэнд нүх, тэнгэрийн шувуудад үүр бий. Харин Хүний Хүүд толгой хоргодох ч газар байхгүй гээд өөр нэгэнд —Намайг дага гэхэд тэр хүн —Эхлээд явж, эцгээ оршуулахыг надад зөвшөөрөөч гэжээ. Гэтэл Есүс —Үхэгсдийг үхэгсдээр нь оршуулуул. Харин чи явж, Бурханы хаанчлалыг газар бүр тунхагла гэв. Бас өөр нэг нь Түүнд —Эзэн, би Таныг дагана. Эхлээд гэрийнхэнтэйгээ салах ёс гүйцэтгэхийг Та зөвшөөрөөч гэхэд харин Есүс —Анжсан дээр гар тавьсан атлаа арагшаа харагч хэн боловч Бурханы хаанчлалд үл тэнцэнэ гэж айлджээ.” (Лук 9:57-62)

Нэр нь үл мэдэгдэх гурван хүн Есүстэй нүүр тулан уулзсан аж. Түүнийг дагах хэрэгтэй гэдгийг тэд дотоод сэтгэлдээ мэдэрчээ. Гэвч тэдний энэ сэтгэл болон Христийг бүрэн дагах сэтгэлийнх нь дундуур ямар нэг зүйл орсон байлаа.

НОЁН ЯАРУУ

Эхнийх нь хүнийг ноён Яаруу гэдэг. Тэрээр Эзэн Есүсийг хаа ч явсан дагана хэмээн их л урам зоригтойгоор сайн дураараа шийдэж “Би Таныг хаа ч явсан дагая” гэжээ. Хичнээн үнэтэй байсан ч хамаагүй, үүрч явах загалмай нь хичнээн хүнд байсан ч хамаагүй, туулах зам хичнээн бэрхшээлтэй байсан ч хамаагүй дагая гэж шийдсэн байлаа.

Зэрвэс харахад Есүсийн хэлсэн хариу үг ноён Яаруугийн бэлэн сэтгэлтэй огт хамаагүй мэт санагдана. Есүс түүнд “Үнэгэнд нүх, тэнгэрийн шувуудад үүр бий. Харин Хүний Хүүд толгой хоргодох ч газар байхгүй” гэж хариулжээ. Үнэндээ бол Есүс хамгийн зөв тохирсон хариултыг өгсөн аж. Түүний хэлсэн үг “Чи намайг хаа ч явсан дагана хэмээн батлан хэлж байна. Гэвч материаллаг ая тух байхгүй байсан ч чи Намайг дагахад бэлэн гэж үү? Үнэгэнд энэ дэлхий дээр Надаас илүү ая тух бий. Шувуудад ч бас өөр өөрсдийн гэсэн үүр бий. Харин Би Өөрийнхөө гараар бүтээсэн энэ дэлхий дээр толгой хорогдох газаргүй тэнүүчилж амьдардаг. Чи орон гэрийн ая тухтай байдлыг золиослон Намайг дагахад бэлэн гэж үү? Надад үнэнч сэтгэлээр үйлчлэхийн тулд амьдралын зүй ёсны ая тухаас татгалзахад

бэлэн гэж үү?” гэсэн утгатай байлаа.

Ноён Яаруу энэ бүхэнд бэлэн биш байсан бололтой. Яагаад гэвэл түүний тухай Библид дахин өгүүлсэн зүйл ганц ч байхгүй. Энэ дэлхийн ая тухыг хайрлах сэтгэл нь Христийг үнэнчээр дагах сэтгэлээс нь илүү хүчтэй байсан аж.

НОЁН УДААН

Хоёр дахь хүнийг ноён Удаан гэдэг. Тэрээр эхний хүнтэй адил сайн дураараа шийдвэр гаргаагүй байлаа. Харин Аврагч маань түүнийг хойноосоо дагуулахаар өөрөө дууджээ. Ноён Удаан шууд татгалзсангүй. Тэгэхээр Эзэнийг огт сонирхоогүй хэрэг бололтой. Гэвч түүнд эхлээд хийж гүйцээх ёстой ажил байсан аж. Энэ л түүний гэм буруу байв. Өөрийнхөө хэрэгцээ шаардлагыг Христийн хэрэгцээ шаардлагаас дээгүүр тавьжээ. Эзэний дуудлагад юу гэж хариулсныг нь харцгаая: *“Эхлээд явж эцгээ оршуулахыг зөвшөөрөөч”*. Хүү нь эцэг эхдээ энэ мэт хүндэтгэл үзүүлнэ гэдэг зүй ёсны хэрэг. Нас барсан эцгээ хүндэтгэлтэйгээр нутаглуулна гэдэг Христэч итгэлтэй харшлах зүйл биш. Гэвч энэ дэлхийн эелдэг найрсаг байдал Эзэн Есүсийн сонирхлоос дээгүүр тавигдвал гэм нүгэл болдог. Ноён Удааны амьдралын жинхэнэ хүсэл эрмэлзэл *“Эзэн минь,..... эхлээд би....”* гэсэн түүний хүсэлтээс ил харагдаж байна.

“Эзэн минь...эхлээд би...” гэж хэлсэн үг нь өөрөө тэр чигээрээ утга учиргүй, байж боломгүй зүйл байсныг ноён Удаан ухаараагүй бололтой. Хэрэв Есүс Эзэн мөн л бол эхэнд тавигдах учиртай. “Би” гэсэн биеийн төлөөний үг амьдралын гол суудлыг эзэлсэн цагт Есүс тэр амьдралыг удирдаж чадахгүй.

Ноён Удаанд хийж гүйцэтгэх ажил байсан аж. Түүнийгээ ч эн тэргүүнд тавьжээ. Есүс *“Үхэгсдийг үхэгсдээр нь оршуулуул. Харин чи явж, Бурханы хаанчлалыг газар бүр тунхагла”* гэж хариулсан нь учиртай байв. Өөрөөр хэлбэл Есүс *“Сүнсээр үхмэл хүн ба итгэгч хүний аль алиных нь сайн хийж чаддаг зүйлс гэж бий. Гэвч амьдралд бас зөвхөн итгэгч хүний хийж чадах зүйл гэж байдаг. Тэгэхээр, итгэгч биш хүний элбэг хийж чадах зүйлтэй зууралдаж амьдралаа үрэх хэрэг юу билээ. Сүнсээр үхмэл хүмүүс махан биеэр үхсэн хүмүүсээ оршуулаг. Харин чи бол маш чухал хэрэгтэй хүн. Газар дэлхий дээр Миний үйл хэргийг үргэлжлүүлэх нь чиний амьдралын гол зорилго байг”* гэсэн хэрэг байлаа.

Ноён Удаанд энэ дэндүү үнэтэй санагдсан бололтой. Тэрээр цаг хугацааны тайзнаас нэр нь үл мэдэгдэх нэгэн болон чимээгүйхэн алга болсон юм.

Эхний хүнийг Есүсийн дагалдагч болоход материаллаг ая тухтай байдал саад болсон бол бидний эрхэлдэг ажил эсвэл эзэмшсэн мэргэжил итгэгч хүний амьдралын утга учраас дээгүүр тавигдаж болох аюултайг хоёр дахь хүний жишээ харуулж байна. Нийгэмдээ ажил хөдөлмөр эрхлэхэд буруу зүйл огт байхгүй. Итгэгч хүн өөрийн болон ар гэрийнхээ хэрэгцээг хангахын тулд ажил хөдөлмөр эрхлэх ёстой. Энэ бол Бурханы хүсэл. Гэвч жинхэнэ дагалдагч хүний амьдрал юуны өмнө Бурханы хаанчлал хийгээд Түүний

зөвт байдлыг эрж хайхыг шаарддаг. Бурханы хаанчлалыг тунхаглах нь итгэгч хүний гол мэргэжил юм. Гэсэн атал итгэгч хүн зөвхөн өнөөгийн хэрэгцээг хангах ажлыг эн тэргүүнд тавьж итгэгч биш хүний элбэг хийж чадах зүйлийг хийж амьдралаа дэмий үрдэг.

НОЁН ЗАЛХУУ

Гурав дахь хүнийг ноён Залхуу гэдэг. Тэрээр Эзэнийг сайн дураараа дагахаар шийдсэнээрээ эхний хүнтэй адил боловч *“Эзэн минь ... эхлээд би...”* гэсэн хоорондоо зөрчилтэй үг хэлсэнээрээ хоёр дахь хүнтэй адил байлаа. Ноён Залхуу *“Эзэн, би Таныг дагана. Эхлээд гэрийнхэнтэйгээ салах ёс гүйцэтгэхийг Та зөвшөөрөөч”* гэжээ.

Үндсэндээ түүний хэлсэн үгэнд буруу зүйл огт байхгүй байгааг бид бас дахин хүлээн зөвшөөрөх ёстой. Ойр дотныхоо хүмүүст хайр халамж үзүүлэх эсвэл тэднээсээ салахдаа ёс зүйн дүрэм журмыг сахих нь Бурханы хуультай харшлахгүй. Тэгвэл энэ хүн юун дээр бүдрэв? Ойр дотныхоо хүмүүсийг хайрлах халуун сэтгэл нь Христийн байрыг эзэлсэн аж.

Түүний энэ сэтгэлийг нэвт харсан Эзэн Есүс *“Анжсан дээр гар тавьсан атлаа арагшаа харагч хэн боловч Бурханы хаанчлалд үл тэнцэнэ”* гэжээ. Өөрөөр хэлбэл “Миний дагалдагч хүн чам шиг ийм зөвхөн өөрийгөө бодсон сул дорой байдлыг харуулах ёсгүй. Надад гэр бүлийн холбооноос татгалзахад бэлэн, гэр бүлийн холбоонд уярч хайлдаггүй, Намайг амьдралынхаа өөр бусад бүх хүнээс дээгүүр тавьдаг тийм хүн хэрэгтэй” гэсэн аж.

Ноён Залхуу Есүсийг орхиж зам уруудан гунигтайяа алхан одсон болов уу. Есүсийг дагах гэсэн түүний хэт дэврүүн хүсэл тэмүүлэл гэр бүлийн холбооны хад чулууг мөргөн бут үсрэн хагарчээ. Эх нь уйлан гиншиж “Хэрэв чи эхийгээ орхиод сайн мэдээ дэлгэрүүлэгч болчихвол зүрх минь шаналан шархлах болно шүү” гэж хэлсэн байж ч магадгүй. Мэдэх юм алга. Ямар ч байсан Библи энэ хулчгар эрийн нэрийг дурьдахаас татгалзсан бөгөөд тэрээр Эзэнээс ингэж эргэснээр амьдралынхаа хамгийн агуу боломжийг алдаж “Бурханы хаанчлалд үл тохирох хүн” гэсэн үгсийг булшнахаа чулуун дээр бичүүлж үлдсэн ажээ.

ДҮГНЭЛТ

Эзэн Есүс Христийг насан туршдаа дагах хүсэл зориг дутсан энэ гурван хүний харуулсан зүйлс бол жинхэнэ дагалдагч хүнд хамгийн түрүүнд саад болдог гурван зүйл юм.

Ноён Яаруу – газар дэлхийн ая тухыг хайрлах хайр.

Ноён Удаан – ажил хөдөлмөр эсвэл мэргэжлийг урьтал болгох

Ноён Залхуу – гэр бүлийн дотно холбоог эн тэргүүнд тавих

Эзэн Есүс өнөөдөр ч урьдын адил эрэгтэй эмэгтэй хүмүүсийг баатарлагаар, амь амьдралаа золиослон байж Өөрийнх нь хойноос дагахыг

хүсэн дуудаж байгаа. Үүнээс зугтах зам харгуйнууд ч бас байсаар байгаа.

Дөрөвдүгээр бүлэг

ДАГАЛДАГЧ БОЛ ИТГЭМЖИТ НЯРАВ ЮМ

Лук номын 16-р бүлгийн 1-13-р ишлэлүүдэд өгүүлсэн шударга бус нярвын тухай сургаалт зүйрлэлийг дагалдагчдад зориулсан байлаа. Аврагч Есүс уг зүйрлэлээр бүх үеийн дагалдагчдын баримталбал зохих зарчмыг гарган тавьжээ. Ер нь бол Христийн дагалдагч гэдэг үндсэндээ нярав хүн бөгөөд тэрээр Түүний эд хөрөнгийг хариуцахын зэрэгцээ газар дээрх ашиг сонирхлыг нь хамгаалдаг.

Энэ сургаалт зүйрлэлд төвөгтэй зүйл их бий. Өнгөц харахад шударга бус байдал, худал хуурмагийг сайшаасан мэт. Гэвч зөв талаас нь харж зохих ёсоор нь ойлговол үүний цаана нэн чухал заавар зөвлөгөө нуугдаж байгааг харж болно.

Уг түүхийг товчлон өгүүлбэл ийн аж. Маш их эд баялагтай нэгэн хүн өөрийн ажил хэргийг хариуцуулахаар хүн хөлслөн ажиллуулжээ. Хэсэг хугацааны дараа хөрөнгийг нь үрэн таран хийж байгааг олж мэдмэгц санхүүгийн шалгалт хийхийг шаардаж ажлаас халах сануулга өгөв.

Ирээдүйн амжилт ололт нь тун бүрхэг болж байгааг ухаарсан няравт биеийн хүчний хөдөлмөр хийхэд нас дэндүү өндөр, гуйлга гуйхад дэндүү ичгүүртэй байжээ. Тиймээс хожмын өдрүүдэд анд нөхөдтэй байх төлөвлөгөө зохиов. Тэгээд эзэнд нь өртэй нэг хүн дээр очоод “Чи манай эзэнд хир өртэй вэ?” хэмээн асуухад “Долоон зуун тавин галлон тосны өртэй” гэв Нярав “За яахав, өрнийхөө талыг л төлчих. Бид чиний өрийг бүрэн төлсөнд тооцъё” гэжээ. Мөн эзэнд нь өртэй өөр нэг хүн дээр очиж “Чи хир өртэй вэ?” хэмээн асуутал нөгөө хүн “Найман зуун бушель (Үр тариа хэмжих хэмжүүр. 1 бушель нь 363 л-тэй тэнцэнэ) үр тарианы өртэй” гэв. Нярав түүнд “Тийм үү, за яахав чи зургаан зуун дөчин бушлийг төлчихвөл бид чиний өрийг цайруулая” гэжээ.

Энэ нярвын хийсэн энэ үйлдлээс илүү гайхал төрүүлсэн зүйл бол эзнийх нь хэлсэн үг юм.

“Шударга бус нярвынхаа ухаалаг үйлдлийнх нь төлөө эзэн нь түүнийг магтан сайшаажээ. Учир нь энэ үеийн хөвгүүд өөрсдийн цаг үеийн хэрэгт гэрлийн хөвгүүдээс илүү ухаалаг ажээ. Шударга бус нярвынхаа ухаалаг үйлдлийнх нь төлөө эзэн нь түүнийг магтан сайшаажээ. Учир нь энэ үеийн хөвгүүд өөрсдийн цаг үеийн хэрэгт гэрлийн хөвгүүдээс илүү ухаалаг ажээ.” (Лук 16:8)

Шударга бус үйл ажиллагааг илт сайшаасныг юу гэж ойлгох вэ? Юутай ч нэг л зүйл тодорхой юм. Энэ нярвын ажил олгогч эзэн ч, бидний Эзэн Есүс ч ийм заль мэхийг сайшаагаагүй нь мэдээж. Уг нярвын ажлаас халагдах болсон гол шалтгаан чухамдаа энэ байсан. Итгэл эвдсэн ийм шударга бус үйлдлийг зөв шударга ямар ч хүн сайшаахгүй. Уг сургаалт зүйрлэл өөр юуг ч сургаж болох ч залиланг зөвтгөж байгаа хэрэг огт биш юм.

Шударга бус нярав хожмын өдрүүдээ бодож төлөвлөсөн нь сайшаалтай

ганц зүйл байсан юм. Нярвынхаа ажлыг хийхээ больсон ч найз нөхдөө алдахгүй байх алхмуудыг хийсэн нь “одоог” биш ирээдүйг бодсон хэрэг байлаа.

Уг сургаалт зүйрлэлийн гол санаа ч энэ юм. Итгэгч биш хүмүүс хожмын өдрүүдийнхээ хэрэгцээг хангах гэж зүтгэдэг. Тэд зөвхөн нас өндөр болж тэтгэвэрт гарах он жилүүддээ л санаа зовдог. Ашиг орлоготой ажиллаж чадахгүй болсон үедээ аль болох ая тухтай амьдрахын тулд хичээнгүйлэн хөдөлмөрлөдөг. Нийгмийн баталгаагаа хангах гэж чадах бүхнээ хийдэг.

Энэ тал дээр итгэгч биш хүмүүс итгэгч хүмүүсээс илүү ухаалаг байдаг ажээ. Үүний учрыг олохын тулд итгэгч хүний ирээдүй газар дээр биш харин тэнгэрт байдгийг ойлгох ёстой. Энэ бол нэн чухал санаа. Итгэгч биш хүний тухайд ирээдүй нь одоо цаг ба булшны хооронд байдаг бол Бурханы хүүхдийн тухайд ирээдүй нь Христтэй хамт орших өнө мөнхийн амь юм.

Тэгэхээр, итгэгч биш олон хүн газар дээрх ирээдүйн амьдралд өөрсдийгөө бэлтгэх тал дээр тэнгэр дэх ирээдүйн амьдралдаа бэлтгэх олон итгэгч хүнээс илүү ухаалаг, илүү шаргуу байдгийг уг сургаалт зүйрлэл харуулж байна.

Эзэн Есүс чухам үүнийг үндэслэл болгон уг сургаалт зүйрлэлийг амьдралд ямар байдлаар хэрэгжүүлэхийг харуулж ийн өгүүлсэн юм.

“Би та нарт хэлье. Шударга зөв эд баялгаараа өөрсдийн анд нөхөдтэй бол. Энэ нь эд хөрөнгө чинь үгүйрэх цагт, тэд та нарыг мөнх нутагт хүлээн авахын тул юм.” (Лук 16:9)

Итгэгч биш хүний эд баялаг нь мөнгө эсвэл бусад материаллаг өмч хөрөнгө байдаг. Харин итгэгч бид хүмүүсийг Христ рүү хөтлөхөд үүнийг ашиглаж болно. Уг сургаалт зүйрлэлд “анд нөхөд” хэмээн нэрлэгдсэн хүмүүс бол та бидний мөнгө төгрөгөө зөв ашиглан Есүс рүү хөтөлсөн тэр хүмүүс юм. Та бидний төгсгөлийн үе ойртож байгаа (нэг бол нас барах эсвэл татан авалтын үеэр Христтэй хамт тэнгэрт очих). Тэр үед өмч хөрөнгөө зөв ашиглан Христ рүү хөтөлсөн анд нөхөд маань биднийг өнө мөнхийн оршин суух газарт найр тавин угтах хүмүүс болон үйлчлэх болно.

Ухаалаг нярав хүн ирээдүйгээ энэ мэтээр төлөвлөдөг. Тэрээр богинохон амьдралаа газар дэлхий дээр аюулгүй орших баталгааг эрж хайн өнгөрүүлэхийн оронд мөнгө төгрөгөөрөө дамжуулан Христ рүү хөтөлсөн анд нөхдөөрөө тэнгэрт хүрээлүүлэхийн тулд хичээнгүйлэн зүтгэдэг. Энэ бол Библи, Хуучин ба Шинэ Гэрээнүүдийн аль нэг хэсэг болон Христ итгэлт бусад ном товхимлуудыг хэвлүүлж гаргахад ашиглагдсан мөнгө, сайн мэдээ дэлгэрүүлэгч хүмүүс мөн Христ итгэлт ажилчдад тусламж дэмжлэг үзүүлэхэд хэрэглэгдсэн мөнгө, Христ итгэлт радио нэвтрүүлэг болон бусад үйл ажиллагаануудыг санхүүжүүлэхэд тусалсан мөнгө юм. Товчхондоо янз бүрийн арга замаар сайн мэдээг тараахад ашиглагдсан мөнгө гэсэн үг. “Тэнгэрт эд баялаг хураах цорын ганц арга зам бол эд баялгийг тэнгэрт очих зүйлд зориулах явдал юм.”

Материаллаг өмч хөрөнгө нь эрдэнэт хүний сүнсийг аврах их үйлсэд хэрэглэгдэж байгааг харсан итгэгч хүний “эд зүйлийг” хайрлах хайр багасдаг.

Баян тансаг амьдрал,эд баялаг, материаллаг суу алдар энэ бүхэн түүний дотрыг муухай оргиулна. Зөвт бус эд баялаг тэнгэрлэг урвалд орж Эзэнд үүрд мөнх магтаал хүндэтгэл өргөх зүйл болж хэрхэн хувирахыг харах нь түүний туйлын хүсэл болдог. Мөн түүнчлэн Бурханыг өнө мөнхөд алдаршуулах, хүмүүст өнө мөнхийн ивээлийг өгөх тийм зүйлийг хүмүүсийн амьдралд хийх их хүсэлд автдаг. 1600-гаад оны үед Шотландын Анвот хотод амьдарч байсан нэгэн агуу номлогч:

Анвот хотын ядаж ганц иргэн

Бурханы баруун талд зогсон намайг угтвал

Эммануэлийн газар нутаг дээрх

Миний диваажин нэг биш хоёр болох болно хэлж байсныг түүний үеэл Анне Росс бичиж үлдээсэн байдаг. Чухам үүнтэй адил цангасан сэтгэлийг тийм хүн бас мэдрэх ажээ.

Ийм хүний тухайд бүх алмаас эрдэнэ, бадмаараг, үнэт сувд, банкны хадгаламж, элдэв даатгал, том орд харш, далбаат завь, тансаг машин энэ бүхэн зөвт бус эд баялгаас өөр юу ч биш байх болно. Энэ бүхнийг хувьдаа ашиглавал удалгүй үрэгдэн дуусах ба харин Христийн төлөө ашиглавал өнө мөнхөд ноогдол ашиг өгсөөр байх ажээ.

Материаллаг эд зүйлд хандаж байгаа байдал, тэдгээрээс ямар хэмжээгээр зуурч байгаа зэрэг нь бидний зан чанарыг шалгах шалгуур болдог. Эзэн Есүс үүнийг 10-р ишлэл дээр онцлон дурьдаж ийн өгүүлжээ:

“Хэн маш бага юманд итгэмжтэй байна, тэр нь их юманд ч мөн итгэмжтэй байдаг. Хэн бага юманд шударга бус байна, тэр нь их юманд ч мөн шударга бус байдаг.”

Энэ ишлэлд дурьдагдсан маш бага юм гэдэг нь материаллаг эд зүйлийг захиран зарцуулахтай холбоотой. Материаллаг эд зүйлийг Бурханы алдрын төлөө итгэгч нөхдөө ивээх ивээлийн төлөө ашиглаж чаддаг хүн бол итгэмжтэй хүн юм. Харин өмч хөрөнгөө өөрсдийн ая тух, тансаг амьдрал, хувийн таашаалыг бүрдүүлэхэд ашигладаг хүн шударга бус няравт тооцогддог. Бага юмыг (материаллаг зүйл) хариуцаж чаддаггүй хүнд их юмыг (сүнслэг зүйлийг) хэрхэн хариуцуулах билээ. Зөвт бус эд баялагт шударга бус ханддаг хүн Христийн ажилтны ёсоор итгэмжит байж Бурханы нууцын нярав байж чадна гэж үү? (1 Коринт 4:1)

Тиймээс Аврагч маань үүнийг цааш нь үргэлжлүүлж *“Иймээс хэрэв та нар шударга бус эд баялагт итгэмжтэй байгаагүй бол, хэн та нарт жинхэнэ баялгийг даатгах билээ?”* (Лук 16:11) гэжээ.

Газар дээрх эд баялаг бол жинхэнэ баялаг биш бөгөөд үнэ цэнэ нь хязгаарлагдмал, түр зуурынх юм. Харин сүнслэг эд баялаг бол жинхэнэ баялаг бөгөөд хэмжээлшгүй их үнэ цэнэтэй, шавхагдашгүй ажээ. Материаллаг эд зүйлийг захиран зарцуулах тал дээр итгэл даагаагүй хүнд Бурхан газар дээр эсвэл тэнгэрт сүнслэг өв хөрөнгийг хариуцуулахгүй.

Эзэн Есүс үүнийг улам лавшруулж *“Хэрэв та нар бусдын юманд итгэмжтэй байгаагүй бол, хэн та нарт өөрсдийн чинь юмыг өгөх билээ?”*

(Лук 16:12) гэсэн байдаг.

Материаллаг эд зүйл бол биднийх биш харин Бурханых юм. Бидэнд байгаа бүх зүйл Бурханы хариуцуулж өгсөн зүйл. Энд газар дээр хичээнгүй хөдөлмөр, үйлчлэлийн үр дүнд бий болсон тэр зүйлийг л бид өөрсдийнх хэмээн нэрлэж мөн итгэмжит нярав байсны хариу шагналыг тэнгэрт хүртэх болно. Бурханы өмч хөрөнгийг итгэмжтэйгээр хариуцаж чадахгүй бол энэ амьдралд Бурханы Үгний гүнд нэвтэрч эсвэл тэнгэрт шагнал хүртэж чадахгүй.

Эцэст нь Эзэн Есүс уг сургаалт зүйрлэлийн гол санааг нэгтгэн ийн дүгнэжээ:

“Хоёр эзэнд үйлчилдэг зарц байдаггүй. Учир нь тэр нэгийг нь үзэн ядаж, нөгөөг нь хайрлана. Эсвэл нэгээс нь зуурч, нөгөөг нь зэвүүцдэг. Та нар Бурханд ба эд баялагт зэрэг үйлчилж чадахгүй” (Лук 16:13).

Хоёр зүйлд нэгэн зэрэг үнэнч байх боломжгүй. Есүсийн дагалдагч хүн нэгэн зэрэг хоёр өөр ертөнцөд амьдарч чадахгүй. Нярав хүн нэг бол Бурханыг хайрлаж эсвэл эд баялгийг хайрладаг. Эд баялгийг хайрлаж байгаа бол Бурханыг үзэн яддаг.

Уг сургаалт зүйрлэлийг аврал аваагүй итгэгч биш хүмүүст биш харин Есүсийн дагалдагч нарт зориулан бичсэн юм шүү.

Тавдугаар бүлэг

ХИЧЭЭЛ ЗҮТГЭЛ

Христийн дагалдагч хүн оюуны өндөр чадвартай, бие бялдрын хөгжил сайтай байх албагүй. Энэ бүхнийх нь төлөө түүнийг уучилж болно. Харин ямар ч дагалдагч хүн хичээл зүтгэлгүй байж болохгүй. Түүний зүрх сэтгэл Аврагч Эзэнийхээ төлөө дүрэлзэн асах их гал дөлгүй бол үхмэл юм.

Ер нь бол итгэгч хүн гэдэг *“Таны гэрийн төлөөх зүтгэл Намайг залгих болно”* (Иохан 2:17) гэж хэлсэн тэр Нэгэнийг дагагч билээ. Аврагч Эзэн маань Бурханыг гэсэн, Түүний хүсэл сонирхлын төлөө гал халуун сэтгэлтэй байсан. Түүнийг дагагч хүмүүсийн дунд үлбэгэр, сэтгэлгүй хүмүүс багтах орон зай байхгүй.

Эзэн Есүс газар дэлхий дээр амьдарч байхдаа сүнсний хувьд хүнд дарамтад байсан. Үүнийг Түүний хэлсэн дараах үгсээс харж болно: *“Харин хүртэх ёстой нэгэн баптисм Надад байна. Үүнийг гүйцэлдтэл Би ямар их зовно вэ!”* (Лук 12:50), *“Намайг Илгээгчийн ажлыг Би өдөр байхад хийх ёстой. Хэн ч ажиллаж чадахгүй шөнө ирж байна* (Иохан 9:4).

Иохан Баптистын хичээл зүтгэлийг Эзэн Есүс үнэлж *“Иохан бол асаж, гэрэлтэж байсан дэнлүү байв”* (Иохан 5:35) гэж байсан.

Элч Паул бас үнэнч зүтгэлтэн нэгэн байсан. Нэр нь үл мэдэгдэх нэгэн зохиолч Паулын гал шиг дүрэлзсэн амьдралыг дүрслэн буулгахыг хичээн гар бичмэлдээ ийн бичжээ:

Тэр бол анд нөхөдтэй болох гэж хичээдэггүй, энэ дэлхийн сайн сайхан зүйлийг хүсэж түүнд итгэл найдвараа тавьдаггүй, үхлээс айдаггүй, энэ насны амьдралын төлөө зүтгэдэггүй нэгэн байсан. Бас өөрийн гэсэн эд хөрөнгө, нэр төр, нийгэмд эзлэх байр суурьгүй хүн, Есүс Христийн сайн мэдээг дэлгэрүүлэх ганц бодолтой, Бурханыг алдаршуулах ганц хүсэл зорилготой нэгэн байсан. Мунхаг нэгэн, Христийн төлөө мунхаг гэж тооцогдохдоо дургүйцдэггүй нэгэн. Түүнийг энэ дэлхий хоосон мөрөөдөгч, хэнээтэн, дэмий чалчигч гэх мэт элдэв янзаар нэрлэж болох ч энэ бүхэн түүнийг бүрэн тодорхойлж чадахгүй Түүнийг бас худалдаачин, гэрийн эзэн, жирийн иргэн, эд баялагтай хүн, дээгүүр зиндааны хүн, эрдэм мэдлэгтэй эсвэл бүр эрүүл ухаанаар сэтгэгч гэж нэрлэсэн ч энэ бүхэн бас түүнийг бүрэн тодорхойлж чадахгүй.

Паул нэг бол Есүсийн тухай ярих эсвэл үхэх гэсэн хоёрхон сонголттой байв. Гэвч үхэх байсан ч ярьсаар л байх байсан. Нэг газраа удаан тогтож суудаггүй уул ус, хад чулуу, элсэн цөлийг туулан явдаг байв. Мөн үгийг үл хайрлан чанга хоолойгоор ярих агаад түүнийг юу ч үл зогсоож чадах ажээ. Дуугаа өндөрсгөн ярихдаа далайн хүчтэй шуурган дунд ч ярихаа болиогүй. Сүр хүчит зөвлөгч ноёд болон их хаадын өмнө ч үнэнийг гэрчлэн ярьсаар байсан. Түүний дуу хоолойг үхлээс өөр юу ч таслан зогсоогоогүй бөгөөд тэр ч байтугай цаазлуулахаасаа өмнө, илдний хурц ир түүний толгойг биеэс нь таслахын өмнөхөн тэрээр ярьсаар, залбирсаар, гэрчилсээр, гэм нүглээ хүлээсээр, анхааруулсаар, мөн харгис хэрцгий хүмүүсийг ерөөсөөр байсан юм.

Бурханы өөр бусад хүмүүс ч Бурханы таалалд нийцүүлэх гэсэн дээрхтэй адил гал халуун хүсэл сэтгэлийг харуулж байсан түүх олон бий. Ч.Т. Стадд ийн бичжээ:

Зарим хүн сүм чуулганы цөөхөн хэдэн хүний дотор, сүмийн хонхны дууг сонсон амьдрахыг хүсдэг. Харин би тамын хаалганы үүдэнд цугларсан хүмүүсийг тамаас аврах баг ажиллуулахыг хүсдэг.

Ер нь бол шашингүй үзэлтэй нэг хүний бичсэн нийтлэл Стаддад өөрийгөө Христэд үнэнчээр бүрэн зориулах их хүслийг төрүүлсэн юм. Уг нийтлэлд ийн өгүүлсэн байлаа.

Дэлхийн сая сая хүмүүс энэ насанд үйлдэх шашны зан үйл хийгээд эрдэм ном хойд насны хувь төөргийг тодорхойлдог гэж ярьдаг. Хэрэв үүнийг үнэн гэдэгт би бат итгэх аваас миний хувьд шашин хамгийн чухал зүйл болохсон. Газар дэлхий дээр эдлэх таашаалыг хог мэт хаяж, хорвоогийн ажил үйлсийг утгагүй, бодол, сэтгэл санааг дэмий хоосон зүйл хэмээн үзэх байсан. Шашин намайг өглөөний нойрноос сэрээдэг ганц бодол, орой гүн нойронд хөвөхийн өмнөх үеийн ганц дүр төрх минь болох байсан. Би зөвхөн шашны үйл хэргийн төлөө хөдөлмөрлөж зөвхөн өнө мөнхийн тухай бодно. Ганц хүний сүнсийг аварсан бол хичнээн их зовж зүдэрсэн ч хамаагүй. Газар дэлхийн үйл хэрэг хэзээ ч миний гарыг барьж амыг таглахгүй. Хорвоогийн баяр баясал, гомдол гутралыг оюун бодолдоо хормын төдийд ч оруулахгүй. Би зөвхөн өнө мөнхийг ширтэн харж өөрийнхөө эргэн тойронд байгаа, удахгүй нэг бол өнө мөнхийн баяр жаргалыг олох эсвэл өнө мөнхийн тарчлал зовлонд орох үхэшгүй мөнх сүнстэй хүмүүсийг л анхаарах байсан. Би дэвэн дэлхийгээр хэрэн тэнэж цагаа олсон ч олоогүй ч сургаал номлол заана. Дэлхий ертөнцөд “Дэлхийг бүхэлд нь эзэлсэн ч өөрийн сүнсийг алдвал ямар ашиг байх вэ?” хэмээн заах байсан.

Жон Уисли бол агуу их хичээл зүтгэлтэй хүн юм. Тэрээр “Бүх зүрх сэтгэлээрээ Бурханыг хайрладаг, гэм нүглээс өөр юунаас ч үл айдаг зуун хүнийг надад өг. Тэгвэл би дэлхийг хөдөлгөх болно” гэж байжээ.

Эквадорт тамлуулан алагдсан Жим Елот Есүс Христийн төлөө дүрэлзэн ассан галын бамбар байсан юм. Тэрээр нэг өдөр “*Тэр...., үйлчлэгчдээ галын дөл болгодог*” (Еврей 1:7) гэсэн ишлэлийг тунгаан бодож байхдаа ийн бичсэн байдаг:

Би хир зэрэг шатамхай билээ? Бурхан минь намайг “бусад зүйл” гэсэн галд үл шатах аймшигт зүйлээс салган авраач. Намайг дүрэлзэн асах боломжтой болгохын тулд Сүнсний тосоор нэвт тослооч. Гэвч дүрэлзэн асах гал агшин зуур асаад өнгөрдөг. Сэтгэл минь чи ийм богинохон амьдралыг тэсвэрлэх үү? Миний дотор богинохон насыг насалсан агуу нэгний Сүнс оршин байгаа. Түүнийг Бурханы гэрийн төлөө гэсэн гал халуун сэтгэл шатаасан юм. Бурханы дүрэлзэн асах гал минь намайг түлээгээ болгооч!

Түүний бичсэн эдгээр үгсийн сүүлчийн өгүүлбэрийн санааг Эми Камайклын бичсэн шүлэг өгсөн ажээ.

Гараас тань ирэх их салхинаас
Хамгаалаач гэж гуйх залбирлаас
Хичээн зүтгэхийн оронд
Айн бэмбэгнэж зүрхшээхээс
Эгц өөдөө явах замаас

Хазайн хэлбийхээс
Өнгийн торгонд өөрийгөө ороохоос
Араас тань дагах үнэнч цэргээ
Өө,,Ахмад минь Та авраач.

Өнгөлж зөөллөсөн зүйлийг хайрлах зальжин хайраас
Хялбар сонголт, сул дорой байдлаас
Галготын толгойг бүдгэрүүлэх энэ бүхнээс
Өө, Бурханы Хурга минь авран чөлөөлөөч
Энэ бол сүнсийг бэхжүүлэх арга биш
Энэ бол Загалмайд хүрэх зам биш

Зөв замаар хөтлөх хайрыг
Юунд ч үл шантрах итгэлийг
Ямар ч урам хугарлтад үл цуцах найдварыг
Гал шиг дүрэлзэн асах хүсэл тэмүүллийг өгөөч
Үхдэл болон үжрэхийг бүү зөвшөөрөөч
Бурханы дүрэлзэн асах гал минь, намайг түлээгээ болгооч!

Өнөө үед шашны амиа золислогчдын бүлэг болон хэт улайрагсад хичээл зүтгэлийг Есүст итгэгчдээс илүү их хэмжээгээр харуулж байгаа нь хорин нэгдүгээр зууны Христийн сүм чуулганы нэг ичгүүр юм.

1903 онд араасаа арван зургаан хүнийг дагуулсан нэг хүн дэлхий ертөнц рүү довтолж эхэлсэн бөгөөд түүнийг Владимир Ленин гэдэг байв. 1918 он гэхэд түүнийг дагагчдын тоо нэмэгдсээр дөчин мянгад хүрсэн байлаа. Тэрээр дөчин мянган дагалдагчтайгаа хамт Орос орны нэг зуун жаран сая хүнийг атгандаа оруулсан юм. Хэдийгээр уг хөдөлгөөн саявтараас эхлэн уналтад орсон ч дэлхийн хүн амын тавны нэгийг атгандаа байлгасаар байгаа аж. Бид тэдний үзэл баримтлалыг хүчтэй эсэргүүцэж болох ч хичээл зүтгэлийг нь гайхахгүй байхын аргагүй.

Мексикт байхдаа коммунистуудын эгнээнд орсон америкийн дээд сургуулийн нэг оюутны бичсэн захидлыг Билл Грам анх олны өмнө дэлгэн уншихад олон итгэгч хүнд зэмлэл хүртэж буй мэт сэтгэл төрж байсан буй заа. Уг захидлын дамжуулж буй гол санаа өнөөгийн алан хядагчдын хэлээр бичигдсэн мэт санагдах ажээ. Тэрээр сүйгээ цуцлах болсон шалтгаанаа тайлбарлах зорилгоор уг захидлыг сүйт бүсгүйдээ бичсэн байлаа.

Коммунистууд бид азгүй тохиолдолуудтай учрах өндөр магадлалтай хүмүүс. Биднийг буудаж, дүүжилж, өчиггүй цаазалж, хороож, шоронд хорьж, гүтгэж, доромжилж, ажлаас халж өөр янз бүрийн бусармаг арга замаар амьдралыг маань там болгодог. Коммунистуудаас олон хүн алагдаж, олон хүн шоронд хоригддог. Бид ядуу тарчиг амьдралаар амьдардаг. Амин зуулгад дөнгөж хүрэх хэмжээний мөнгөөр бид амиа зогоож олсон бусад бүх мөнгөө намдаа өргөдөг. Коммунистууд бидэнд олон кино, тоглолт үзэх эсвэл тарган мах идэж, тансаг өргөөнд амьдарч, ганган машин унах мөнгө, цаг зав байхгүй. Биднийг хэт улайрагсад гэдэг. Тиймээ бид бол хэт улайрагсад. Бидний амьдралыг *Дэлхий ертөнцийг коммунизм руу байлдан дагуулах* гэсэн ганцхан агуу том зорилго удирдан жолооддог.

Коммунистууд бидний амьдралын философийг мөнгөөр хэмжихийн аргагүй.

Бид тулалдах үйл хэрэгтэй, амьдралын тодорхой зорилготой хүмүүс. Бидний өчүүхэн “би” хүн төрөлхтний агуу хөдөлгөөнд захирагддаг. Хэрэв амьдрал маань хүнд хүчир болж өчүүхэн “би” намын дарангуйлал дор зовох болсон ч үүнийг бид хүн төрөлхтний төлөө хийх шинэ, үнэн, илүү сайн зүйлд оруулж буй өөрсдийн хувь нэмэр гэж үздэг.

Миний хувьд аминаас минь үнэтэй нэг л зүйл бий. Энэ бол коммунизм юм. Коммунизм бол миний амь амьдрал, ажил хэрэг, шашин шүтлэг, хобби, амраг хайрт, эхнэр, эзэгтэй, идэх талх, мах минь юм. Би өдөр нь түүний төлөө ажиллаж шөнө нь зүүдэлж хонодог. Би өдрөөс өдөрт намдаа улам их автсаар байдаг. Үүний учир аливаа нөхөрлөл, хайр сэтгэлийн явдал эсвэл бүр энгийн яриа хөөрөөг ч амьдралыг маань хөдөлгөж, удирдан жолооддог тэр хүчтэй холбохгүйгээр явуулж чадахгүй. Би аливаа хүн, ном зохиол, үзэл бодол, үйл хөдлөлийг үнэлж дүгнэхдээ эдгээр нь коммунизмын үйл хэрэгт хэрхэн нөлөөлөх, коммунизмд ямар хандлагаар хандаж байгаа зэргийг харж үздэг. Үзэл бодлоосоо болж би хэдийнээ шоронд орсон. Гэвч нууц албаны өмнө ч очиход бэлэн байна.

Коммунистууд өөрсдийн үйл хэрэгт ийм үнэнч байж чадаж байхад итгэгч хүмүүс өөрсдийгөө алдарт Эзэндээ үүнээс илүү үнэнч хайраар, баяртайгаар зориулах ёсгүй гэж үү? Хэрэв Эзэн Есүс бидэнд жоохон ч атугай үнэ цэнэтэй юм бол бидний хувьд бүх зүйл маань байх ёстой. “Хэрэв Христэч итгэл ашигтай зүйл мөн аваас түүнд баатарлагаар итгэх нь ашигтай юм” (Финдли)

“Хэрэв Бурхан дэлхий ертөнцийн авралтай холбоотой ямар нэг зүйлийг Христээр дамжуулан хийсэн бол, Христ үүнийг нь хүн төрөлхтөнд мэдүүлсэн бол үүнийг үгүйсгэсэн, үл тоосон эсвэл янз бүрээр тайлбарласан аливаа зүйлтэй эвлэрэхгүй байх нь итгэгч хүний үүрэг мөн” (Жеймс Денни).

Бурхан Ариун Сүнсний удирдлагад өөрийгөө бүрэн захируулсан хүмүүсийг хүсдэг. Ийм хүмүүс бусдын нүдэнд дарсанд мансуурсан мэт харагдаж болох ч тэднийг илүү сайн таньж мэдэх үед тэд “Бурханы төлөө гэсэн гүн гүнзгий, асар их, ханахыг үл мэдэх цангасан сэтгэлдээ хөтлөгдсөн” байдгийг ойлгох болно.

Дагалдагч нэртэй хэн боловч амьдралд нь хичээл зүтгэл хичнээн чухал хэрэгтэй болохыг ойлгож мэдэх ёстой. Сүмийн тэргүүн Райлын тодорхойлсон тодорхойлолтод хүрэхийг хичээх ёстой.

Хичээл зүтгэлтэй хүн гэж юуны өмнө үйл хэрэгтэй хүн юм. Түүнийг буурь суурьтай, халуун зүрх сэтгэлтэй, няцашгүй, бодолтой, чин үнэнч, дүрэлзсэн сүнстэй гэх мэтээр нэрлэж болох ч энэ бүхэн хангалтгүй ажээ. Тэр зөвхөн ганц л зүйлийг харж, ганц л зүйлд санаа тавьж, ганц зүйлийн төлөө амьдарч, ганц л зүйлд залгиулдаг. Энэ ганц зүйл бол Бурханы таалал юм. Ийм хүн амьдарсан ч, үхсэн ч, эрүүл байсан ч, өвчтэй байсан ч баян байсан ч, ядуу байсан ч, хүмүүст таалагдсан ч эс таалагдсан ч, ухаантай байсан ч, мунхаг байсан ч, магтуулсан ч, зэмлүүлсэн ч, хүндэтгэлийг олсон ч, шившиг болсон ч энэ бүхэн хичээл зүтгэлтэй хүнд юу ч биш юм. Түүний сэтгэл ганц л зүйлийн төлөө дүрэлзэн асдаг. Энэ ганц зүйл нь Бурханы таалал ба Түүнийг суу алдар юм.

Тэрээр энэ ганц зүйлдээ идэгдэн бүрэн шатсан ч үүндээ санаа үл зовох агаад сэтгэл хангалуун байдаг. Өөрийгөө дэнлүүтэй адил хэмээн бодож асахын тулд бүтээгдсэн гэж үздэг. Ассаар байгаад шатаж дууслаа гэхэд Бурханы өгсөн ажил үйлсийг хийж дуусгалаа хэмээн үзнэ. Ийм хүн сүнснийхээ хичээл зүтгэлийг

гаргах газраа үргэлж олж чаддаг. Сургаал зааж, Бурханы төлөө ажиллаж, мөнгө өргөж чадахгүй гэхэд бусдын төлөө уйлж, санаа алдаж, залбирч чаддаг. Тиймээ, хэрэв ийм хүн өвчинд шаналан оронд хадагдсан ядуу гуйлгачин байлаа ч эргэн тойронд нь байгаа гэм нүглийн эсрэг тэмцэж залбирсаар байх ажээ. Иошутай хамт хөндийд тулалдаж чадахгүй гэхэд уулан дээр Мосе, Аарон, Хур нарын ажлыг хийсээр байна. (Египетээс гарсан нь 17:9-13). Өөрөө ажиллаж чадахгүй боллоо гэхэд хийж байсан ажлыг нь үргэлжлүүлэн хийж дуусгах хүнийг илгээх хүртэл нь Эзэнийг дуудан залбирсаар байдаг. Сүнсний хичээл зүтгэлийн тухай ярихдаа би чухам ийм л хүний тухай ярьдаг.

Зуравдугаар хичээл

ИТГЭЛ

Амьд Бурханд итгэх гүн, бат итгэлгүйгээр жинхэнэ дагалдагч байх аргагүй. Бурханы төлөө агуу үйлс бүтээхийг хүсдэг хүн эхлээд Бурханд эргэлт буцалтгүйгээр, өчүүхэн ч эргэлзэж тээнэгэлзэхгүйгээр итгэх ёстой. Хадсон Тэйлор хэмээх сайн мэдээ дэлгэрүүлэгч нэг хүн “Бурханы бүх агуу хүмүүс эхэндээ сул дорой нэгэн байсан ч агуу үйлсийг бүтээж чадсан юм. Яагаад гэвэл тэд Бурханыг өөрсөдтэй нь хамт байгаа гэдэгт хатуу итгэдэг байсан” хэмээн бичсэн байдаг.

Жинхэнэ итгэл бүр Бурханы амлалт дээр буюу Библийн аль нэг хэсэг дээр үндэслэгдсэн байдаг. Энэ бол нэн чухал зүйл. Итгэгч хүн эхлээд Эзэний ямар нэг амлалтын талаар Библээс унших буюу хүнээс олж сонсдог. Ариун Сүнс уг амлалтыг тухайн итгэгчийн ухамсарт ойлгуулж түүний онцлог хэрэгцээнд тохируулан зүрх сэтгэлд нь оруулж өгдөг. Ийм үед өөртэй нь Бурхан шууд ярьсныг тухайн итгэгч ойлгох аж. Амлалт өгсөн Тэр Нэгэн амлалтаа заавал биелүүлэх найдвартай гэдэгт бүрэн итгэсэн итгэгч хүн энгийн хүний хувьд боломжгүй мэт санагдсан ч Эзэний амлалт лавтайяа биелнэ гэж үздэг.

Эсвэл амлалт биш тушаал ч байж болох юм. Итгэлийн тухайд энэ нь ялгаагүй ээ. Бурхан тушаасан л бол уг тушаалыг биелүүлэх хүчийг өгнө. Петрт усан дээгүүр алх хэмээн тушаасан. Гэвч үүнийг хийх чадварыг өгнө гэдэгт Петр хатуу итгэсэн. (Матай 14:28). Эзэн бидэнд сайн мэдээг бүтээл бүрд зарлан тунхагла хэмээн тушаасан. Үүнийг хийхэд шаардагдах ивээлийг Эзэн бидэнд заавал өгнө (Матай 16:15).

Итгэл гэдэг “боломжтой” зүйлд байдаггүй. Хүний хувьд боломжтой зүйл Бурханыг алдаршуулахгүй. Хүний хүч чадал хаана дуусна тэндээс итгэл эхэлдэг. Энэ тухай итгэлийн агуу баатар Жорж Мюллер “Магадлал болон харагдах бараа мэдрэх мэдрэмж дууссан тэр газраас итгэлийн вант улсын нутаг дэвсгэр эхэлдэг” гэж байжээ.

“Хэрэв боломжгүй гэдэг зүйл саад болж байгаа цорын ганц зүйл бол бүх юм бүтнэ гэсэн үг”. Энэ бол итгэлийн үг юм. Энэ тухай Ч.Г Макинтош ийн хэлсэн байдаг:

Итгэл нь Бурханыг гол дүрийн баатар болгодог учир хэцүү, төвөгтэй зүйл гэж юу байдгийг огт мэдэхгүй. Тиймээ, итгэл нь боломжгүй гэх зүйлийн өөдөөс инээдэг. Итгэлийн тухайд Бурхан бол бүх асуултад өгөх хариу – болохгүй бүтэхгүй бүхний шийдэл юм. Итгэл нь бүхнийг Бурханд хамааруулдаг тул зургаан мянган долларын хэрэг үү, зургаан сая долларын хэрэг үү гэдэг түүнд огт хамаагүй. Бурхан бүхнийг чадна гэдгийг тэр мэднэ. Итгэл нь Бурханаас шаардлагатай бүхнээ авдаг. Үл итгэх байдал “Ийм юм, тийм юм гэж яаж байж болох вэ” гэх агаад “яаж” гэсэн үгээр дүүрэн аж. Гэвч “яаж” гэсэн мянган үгэнд итгэл ганц л хариу өгдөг ба энэ бол Бурхан юм.

Хүний бодлоор бол Абрахам Сара хоёр хүүхэдтэй болох боломжгүй байсан. Гэвч Бурхан амласан бөгөөд Абрахамын хувьд боломжгүй ганц л

зүйл байсан нь Бурхан худал хэлэх явдал юм.

“Чиний үр удам ийм болно” гэж урьд нь айлдсан ёсоор тийнхүү олон үндэстний эцэг болохын тулд тэр найдах аргагүй үед найдан итгэсэн. Тэр зуугаад насалсан тул биеийнхээ бараг үхсэнийг болон Сарагийнх нь умай үхмэл болсныг мэдсэн хэдий ч итгэлээр дорой болсонгүй. Харин Бурханы амлалтын талаар тэр үл итгэн тээнэгэлзэжгүй, харин ч итгэлээр хүчирхэгжихдээ Бурханд алдрыг нь өргөн, Бурхан амласнаа биелүүлэх чадвартай гэдэгт бүрэн итгэлтэй байлаа. (Ром 4:18-21)

Итгэл, агуу итгэл зөвхөн амлалтыг харж
Ганцхан Бурханыг харж
Боломжгүй бүхний өөдөөс инээж
“Биелэх болно” хэмээн тунхаглана.

Бидний Бурхан бол боломжгүй бүхнийг болгох мэргэжилтэн юм (Лук 1:37). Түүнд дэндүү хэцүү зүйл гэж байхгүй (Эхлэл 18:14). *“Хүмүүст боломжгүй зүйл Бурханд боломжтой”* (Лук 18:27).

Итгэл нь Бурханд амлалтуудыг нь сануулдаг. *“Итгэлтэй хүнд бүх юм боломжтой”* (Матай 9:23). Мөн Паултай хамт *“Надад хүч өгөгч Түүгээр би бүгдийг хийж чадна”* (Филипой 4:13) гэж хэлдэг.

Эргэлзээ зөвхөн саад бэрхшээлийг хардаг бол
Итгэл харин гарах гарцыг хардаг
Эргэлзээ зөвхөн харуй бүрийг хардаг
Итгэл харин гэрэл гэгээг хардаг.
Эргэлзээ алхах гишгэхээс ч айдаг бол
Итгэл харин өндөрт дүүлэн нисдэг.
Эргэлзээ нь “Хэн итгэх вэ?” гэдэг бол
Итгэл “Би итгэж байна” гэдэг – Нэр нь үл мэдэгдэх зохиолч.

Итгэл нь тэнгэрлэг, ер бусын зүйлтэй холбоотой тул үргэлж “утга учиртай” санагдах нь үгүй. Абрахам хаашаа яах гэж явах гэж байгаагаа мэдэхгүйгээр Бурханд дуулгавартай захирагдан нутгаасаа гарч явсан нь “эрүүл ухаан”-аар хийх зүйл биш байсан (Еврей 11:8). Иошуа Иерихо хотыг зэр зэвсгээр биш харин Бурханд итгэх итгэлээрээ буулган авсан (Иошуа 6:1-20). Энэ дэлхийн хүмүүс иймэрхүү “солиотой” зүйлд инээд нь хүрэх байсан биз ээ. Гэвч дээр дурьдагдсан зүйлс болж өнгөрсөн нь яах аргагүй үнэн.

Ер нь бол итгэл гэдэг маш утга учиртай зүйл. Бүтээл нь Бүтээгчдээ итгэж найдахаас илүү утга учиртай зүйл бий гэж үү? Огт худал хэлж хуурч мэхэлдэггүй, хэзээ ч алдаа гаргадаггүй Нэгэнд итгэх нь тийм солиотой хэрэг үү? Бурханд итгэнэ гэдэг хамгийн утга учиртай, эрүүл, зүй зохистой, зүйл юм. Энэ бол харанхуйд бүдчиж байгаа хэрэг огт биш. Итгэл нь ямар ч алдаа мадаггүй нотолгоог шаардаж үүнийгээ Бурханы алдаа мадаггүй Үгнээс олж авдаг. Бурханд итгэсэн ямар ч хүний итгэл дэмий хоосон өнгөрч байгаагүй өнгөрөх ч үгүй. Эзэнд итгэх итгэлд ямар ч эрсдэл байгүй.

Итгэл нь Бурханыг алдаршуулж бүрэн найдаж болох Түүнд зохих ёсных нь байр суурийг өгдөг. Үүний эсрэгээр үл итгэх байдал нь Бурханы нэрийг

гутааж Түүнийг худалч болгодог (1 Иохан 5:10) Мөн Израилийн Ариун Нэгэний хүчийг боон хязгаарладаг ажээ (Дуулал 78:41).

Хүн гэдэг Дээдийн Дээд Эзэний өмнө шороон дээр сөгдөн сууж даруухнаар Түүнээс юм гуйж байх зохистой нэгэн юм. Чухамдаа итгэл түүнийг энэ байр суурь дээр аваачдаг.

Итгэл гэдэг үзэгдэх зүйлийн эсрэг тал ажээ. Паул “*бид үзэгдэж байгаагаар бус, харин итгэлээр алхаж байна*” (2 Коринт 5:7) гэсэн. Үзэгдэж байгаагаар алхана гэдэг ямар утгатай вэ? Энэ бол нүдэнд харагдах тусламж дэмжлэгт найдна, ирээдүйдээ зориулж зохих хэмжээний хуримтлал үүсгэнэ, нүдэнд үл харагдах эрсдэлүүдээс хүний хүчин зүйлүүдээр хамгаална гэсэн үг. Харин итгэлийн алхаа үүнээс тэс өөр юм. Итгэл нь цаг мөч бүрд ганцхан Бурханд түшиглэж, цаг үргэлж өөрийгөө зөвхөн Эзэнд даатгадаг. Бидний махан бие үл үзэгдэх Бурханаас бүрэн хамааралтай байхаас айн жийрхэх агаад болзошгүй гарз хохирлоос болж өгвөл өөрийгөө хамгаалахыг хичээдэг. Махан бие, цусан зүрхтэй хүн амьдрал цаашид яаж өрнөхийг огт хэлж мэддэггүй учир үүнээсээ бол сэтгэлийн зовлонд унадаг. Харин итгэл нь Бурханы Үгийг дуулгавартай дагахдаа нөхцөл байдлаас үл хамаарах агаад бүх хэрэгцээг нь Эзэн хангаж өгнө гэдэгт итгэх итгэлтэйгээр урагш алхдаг ажээ.

Итгэлээр амьдрахаар шийдсэн дагалдагч хүн бүрийн итгэл заавал соригдох болно. Эрт орой хэзээ нэгэн цагт хүч чадал нь шавхагдана. Аргаа барах үедээ анд нөхдөөсөө тусламж гуйхад ч хүрэх байх. Гэвч хэрэв Эзэн Бурханд үнэхээр итгэж найддаг бол ийм үед зөвхөн Түүн өөд л харах болно. Энэ талаар Ч.Г Макинтош ингэж бичсэн байдаг:

Өөрийн хүсэл сонирхлыг шууд болон шууд бус байдлаар хэн нэгэнд мэдүүлнэ гэдэг итгэлээр амьдрах амьдралын замаас гарч, Бурханыг илт үл хүндэлж буй хэрэг юм. Үнэндээ бол Түүнээс урваж байгаа хэрэг. Мөн Бурхан надад тусалж чадахгүй байна. Тиймээс анд нөхдөөсөө тусламж хүсье гэж хэлж байгаатай адил ажээ. Амийн булгийг орхиод цоорхой савтай ус руу хандаж байгаатай ижил бөгөөд өөрөөсөө Бурханы ивээлүүдийг, Эзэн Бурханаас зүй ёсных нь алдар ба хүндэтгэлийг дээрэмдэн авч буй хэрэг юм.

Итгэлээр улам өсөх хүсэл бол дагалдагч хүнд байвал зохих наад захын чиг хандлага юм (Лук 17:5). Тэрээр авралынхаа төлөө Христэд итгэлээ хэдийнээ өгсөн билээ. Харин одоо Христэд захируулах амьдралынхаа хүрээнүүдийг тэлэн өргөсгөх ёстой. Амьдралдаа өвчин зовлон, сорилт шалгуур, уй гашуу, хүнд гарз амсах бүрдээ Бурханыг илүү ихээр, ойр дотноор таньж мэдэх агаад итгэл нь ч хүчирхэгжих ажээ. Хуучин Гэрээнд Хосей ингэж хэлсэн байдаг: “*Тиймээс мэдэцгээе, ЭЗЭНИЙГ мэдэхийн тулд шамдацгаая*” (Хосей 6:3). Үүнийг ч бас ийм дагалдагч хүн амьдралаараа батлан харуулах болно. Бурханы итгэмжит чанарыг илүү сайн мэдэх тусам илүү агуу зүйл дээр Түүнд итгэхийг хүсэн тэмүүлэх болно.

Итгэл нь Бурханы Үгийг сонсохоос ирдэг тул дагалдагч хүн Библийг унших, судлах, тогтоон цээжлэх, өдөр шөнөгүй тунгаан эрэгцүүлэх замаар Ариун Бичээсийг өөртөө нэвт шингээхийг хүсдэг байх ёстой. Бурханы Үг бол дагалдагч хүний амьдралын луужин, хөтөч, дэнлүү, гэрэл юм.

Итгэлийн амьдралд өсөн дэвжих орон зай үргэлж бий. Итгэлийн хүчээр хичнээн агуу үйлс хийгдэж байсныг бид унших бүрдээ өөрсдийгөө далайн эрэг дээр тоглож байгаа бяцхан хүүхэдтэй адил гэдгээ ухаардаг. Еврей номын 11-р бүлэгт итгэлийн их тэсрэлтийн тухай өгүүлдэг ба 32-40-р ишлэлүүдэд итгэл хэрхэн аажмаар өсөн нэмэгдсээр агуу том зүйл болж буйг харуулжээ.

“Би бас юу ярих вэ? Хэрэв би Гидеон, Барак, Самсон, Иефта, Давид, Самуел болон эш үзүүлэгчдийн тухай яривал надад цаг хүрэлцэхгүй. Тэд итгэлээр хаанчлалуудыг эзэлж, зөвт байдлыг үйлдэн, амлалтуудад хүрч, арслангуудын амыг хааж, галын хүчийг унтраан, илдний ирнээс зайлж, буурайгаас хүчирхэг болгогдож, дайн тулалдаанд зоригжин, харийн дайчдыг буулган авч байлаа. Эмэгтэйчүүд өөрсдийн үхээсдийг амилалтаар буцаан авч байв.

Зарим хүмүүс илүү дээр амилалтад хүрэхийн тулд золилтыг хүлээж авалгүй тамлагдсан юм. Зарим нь доромжлогдон, ташуурдуулсан. Тийм, бас гинжлэгдэн, хоригдож байлаа. Тэд чулуугаар шидүүлэн, соригдож, тас хөрөөдөгдөн, илдэнд хөнөөгдөж, хонь ямааны арьс нөмрөн явж, хоосон тарчиг байн, зовж, ад үзэгджээ. Тэд цөл, уул, агуу болоод газрын нүх сүвээр тэнүүчлэн байлаа. Тэдний хувьд дэлхий зохисгүй байжээ.

Итгэлээрээ тэд бүгдээрээ сайн гэрчлэлийг олоод, амлагдсаныг хүлээн аваагүй аж. Яагаад гэвэл Бурхан бидний төлөө илүү дээр ямар нэгэн юмыг урьдаас харж байсан. Ингэснээр тэд бидэнгүйгээр төгс болгогдох ёсгүй юм”

Эцэст нь хэлэхэд, итгэлээр амьдардаг дагалдагч хүнийг энэ дэлхийн хүмүүс эсвэл бүр итгэгч нөхөд нь ч хоосон мөрөөдөгч, хэт улайрагч хэмээн үзэх болно гэдгийг бид өмнө дурьдсан. “Аливаа хүнд Бурхантай хамт алхах чадварыг өгдөг тэр итгэл хүмүүсийн бодлыг зөв үнэлж дүгнэх чадварыг бас өгдөг” (Ч.Г. Макинтош) гэдгийг бас санах нь чухал.

Долдугаар бүлэг

ЗАЛБИРАЛ

Залбирлын тухай бүх номуудаас хүний сэтгэлд бүрэн хүрч чадах ганцхан ном бий. Энэ бол Библи юм. Залбирлын сэдвээр бичигдсэн бусад бүх номууд дульхан мэдлэг өгөх агаад залбирлын талаар мэдвэл зохих өөр их зүйл дутуу үлдээсэн мэт санагддаг. Энэ ном ч бусад номын хийж чадаагүйг гүйцээнэ гэж бид найдахгүй байна. Бид зөвхөн залбирлын зарим чухал зарчмыг нэн ялангуяа дагалдагчтай холбоотой тэр зарчмуудыг нэгтгэн дүгнэх болно.

Дотоод сэтгэлийн хүчтэй хэрэгцээ шаардлагаас үүдэн гарч ирсэн залбирал бол хамгийн шилдэг сайн залбирал юм. Үүнийг үнэн болохыг бид бүгдээрээ баталж чадна. Амьдрал тогтуун тайван байх үед залбирал мохоо, үлбэгэр байдаг. Харин амьдрал хямрах, аюулын эрмэгт тулах, хүндээр өвчлөх буюу хүнд гарз хохирол амсах үед бид чин сэтгэлийн гүнээс залбирдаг. “Тэнгэрийн орон руу нэвтрэн орох сумны нум дээд зэргээр хөвчлөгдсөн байх ёстой” гэж нэг хүн хэлсэн байдаг. Аргагүй гачигдал, яах ч аргагүй байдал, амин чухал хэрэгцээ шаардлага бол дээд зэргийн сайн залбирлыг төрүүлдэг зүйлс юм.

Харамсалтай нь бид амьдралынхаа ихэнх хэсгийг гачигдалд орохгүйг хичээн өнгөрөөдөг. Бизнесийн арга ухаануудыг ашиглан санамсаргүй тохиолдож болох аливаа зүйлсээс сэргийлэх ая тухтай байдлуудыг бүрдүүлдэг. Хүний арга ухаанаар хөрөнгө хурааж юугаар ч үл дутагдах баян чинээлэг амьдралыг зохиодог. Гэсэн атал залбирал маань яагаад өнгөц, амьгүй байгааг, тэнгэрээс яагаад гал буухгүй байгааг гайхдаг. Хэрэв бид үнэхээр харж байгаа зүйлээрээ биш харин итгэлээр амьдарвал залбиралд маань жинхэнэ хувьсгал гарах болно.

Бид Бурханд “... үнэн зүрхээр ойртон очих...” (Еврей 10:22) ёстой. Энэ бол Бурханд хүрэх сайн залбирлын нэг нөхцөл бөгөөд бид Эзэн Бурханы өмнө жинхэнэ байгаагаараа, чин үнэнээр очих ёстой гэсэн үг. Хоёр нүүр гаргах явдал огт байж таарахгүй. Хэрэв бид энэ нөхцөлийг хангаж чадвал өөрсдийн хүчээр хийж чадах зүйлээ хэзээ ч Бурханаас гуйхгүй. Жишээлбэл, Христэч итгэлийн ажил үйлсэд өөрсдийн хэрэгцээнээс илүү гарсан мөнгийг хэрэглэж болох атал үүнд зориулж мөнгө босгож өгөхийг Түүнээс хэзээ ч гуйхгүй. Бурханаар тохуурхаж болохгүй. Бид Бурханаас хэрэгцээг минь хангаж өгөхийг гуйсан атал өгсөн зүйлийг нь ашиглах хүсэлгүй бол Бурхан нэг удаа хариулсан залбиралдаа дахин хариулахгүй.

Үүнтэй адилаар бид өөрсдөө Бурханы ажилд явах хүсэлгүй атал өөр явах хүн илгээхийг гуйж болохгүй. Лал, хинду болон буддын шашны хүмүүсийн төлөө олон мянган хүн залбирсаар ирсэн. Гэвч ингэж залбирсан бүх хүн өөрөө эдгээр хүмүүст сайн мэдээг хүргэх үйлсэд Эзэнээр ашиглагдахыг хүссэн бол Христ итгэлт үйлчлэлийн түүх илүү урамтай сайхан байх байсан биз ээ.

Залбирал нь энгийн, итгэлтэй, эргэлзээгүй байх ёстой. Залбиралтай холбоотой шашин судлалын элдэв асуудлуудад уусах амархан. Энэ нь

зөвхөн сүнсний мэдрэмжийг бууруулахад л туслах болно. Залбиралтай холбоотой элдэв нууцлаг зүйлсийг тайлан ойлгох гэж хичээхийн оронд энэ талаар зүгээр залбирахад л хангалттай. Залбиралтай холбоотой судалгааны ажлыг шашин судлаач эрдэмтэд нь үлдээе. Харин жирийн итгэгч хүн хүүхдийнхтэй адил итгэлээр тэнгэрийн орны хаалганы өмнө очдог. Агуу Августин “Эрдэм номгүй хүмүүс тэнгэрийн орныг хүчээр эзэлдэг байхад харин эрдэм номтой бид махан бие, цусан зүрхнээс хэтэрч дээш гардаггүй” хэмээн хэлж байсан.

Хэлэх үгийг минь Бурхан ямар аргаар сонсдогийг мэдэхгүй Юутай ч залбиралд минь харин хариулахыг би мэднэ. Чин үнэн залбирлыг минь сонссон гэдгээ хэзээ яаж надад мэдүүлэхийг мэдэхгүй ч эрт орой хэзээ боловч хариу ирнэ гэдгийг мэднэ. Иймээс бид залбирч, хүлээсээр байх ёстой. Гуйсан ивээл минь эргээд надад хүссэн ёсоор минь ирэх эсэхийг би мэдэхгүй. Юутай ч Эзэний хүсэл өчүүхэн минийхээс илүү ухаалаг учир өөрийн залбирал юугаан зөвхөн Түүнд үлдээе – Лола Хенсон.

Залбирлын жинхэнэ хүчийг мэдэрье гэвэл юугаа ч бүү хайрла. Христэд өөрийгөө бүрэн захируул. Түүний төлөө яв. Байгаа бүхнээсээ татгалзан зөвхөн Аврагчийг дага. Өөрийг нь өргөмжлөн дээдэлж хаан суудалд залах тийм үнэнч сэтгэлийг Эзэн Есүс хүсдэг.

Бидний зүгээс хүч хөдөлмөр гаргасан залбирлыг Бурхан илүү үнэлж хүлээн авдаг мэт санагддаг. Эцэгээсээ тухайн өдөрт зориулсан заавар зөвлөгөөг авахын тулд өглөө эртлэн босдог хүн эртэч Тэр Нэгэнтэй харьцахын сайхныг амсдаг.

Мөн түүнчлэн шөнийн турш залбирахад ч бэлэн тийм халуун сэтгэлтэй хүмүүс хэн ч үгүйсгэхийн аргагүй Бурханы хүчийг мэдэрдэг. Ямар ч хүч зараагүй залбирал юунд ч хүргэхгүй бөгөөд зүгээр л нэг хямдхан итгэгчийн дайвар бүтээгдэхүүн болдог.

Хуучин Гэрээнд залбирал, мацаг барилт хоёрыг холбосон байх нь их бий. Ямар нэг хугацаагаар хоол идэхээс татгалзах нь сүнсний дасгал сургуулилтад ихээхэн тустай ажээ. Ийнхүү мацаг барих нь хүний хувьд анхаарал төвлөрөхөд аливааг тодорхой харж ойлгоход мөн оюун ухааныг хурцлахад тустай байдаг бол Эзэний хувьд идэх хоолноос илүү дээгүүр тавьсан залбиралд хариулахдаа илүү дуртай мэт санагддаг.

Амин хувийн эрх ашгийг хайсан залбирлаас зайлсхий. “*Та нар гуйгаад хүлээн авдаггүй. Учир нь та нар өөрсдийн тааламжид зарцуулъя хэмээн буруу хандлагаар гуйдаг*” (Иаков 4:3). Залбиралд энэ тэргүүнд тавигдах ёстой зүйл бол Эзэний хүсэл сонирхол юм. Бид залбирахдаа эхлээд “*Эцэг, Таны нэр ариунаар дуурсгагдаг. Таны хаанчлал ирэх болтугай*” гэж хэлээд дараа нь “*Өдөр тутмын минь талхыг өдөр бүр бидэнд өгөөч*” (Лук 11:2-3) гэх мэтээр залбирах ёстой.

Бурхан бол агуу Нэгэн билээ. Тиймээс бид Түүнийг хүндэтгэж агуу зүйлийг гуйн хүсэх ёстой. Агуу Бурханаас зөвхөн агуу зүйлийг хүлээцгээе.

Их Хааны өмнө очихдоо
Их хүсэлтийг л авч оч

Түүний хайр хийгээд хүч чадал агуу их учир
Таны гуйх зүйл хэзээ ч дэндүү их байхгүй – Жон Ньютон.

Бид хичнээн удаа Эзэнээс өчүүхэн зүйлийг хүсэн хүлээж Түүнийг гомдоож байсан бол? Бид жижигхэн ялалт, өчүүхэн амжилт, шалихгүй хүсэл эрмэлзлэлдээ сэтгэл ханадаг учир Бурханыг үнэхээр агуу Нэгэн мөн гэсэн бодлыг эргэн тойрныхоо хүмүүст төрүүлж чаддаггүй. Жинхэнэ Бурханыг мэддэггүй хүмүүсийн өмнө амьдралаараа Бурханыг гэрчлэн Түүнийг алдаршуулж чаддаггүй. Тэдний анхаарлыг татаж, өөрсдийнх нь ч болж чадах тэр хүч бидний амьдралыг захирч байгааг харуулж бас чаддаггүй. Есүс Христийн элч Паул *“Тэд надаас болж Бурханыг алдаршуулж байсан юм”* хэмээн хэлж байсан. Харин бидний тухай ингэж ярих нь тун цөөн билээ. (Э.У. Моор)

Бид юуны өмнө Бурханы хүслийн дагуу залбирахад анхаарч дараа нь Бурхан гуйлтыг маань сонсож хариулна гэсэн бат итгэлтэйгээр хүсэлтүүдээ өргөн мэдүүлэх ёстой. *“Бид Түүний хүслийн дагуу юуг ч гуйсан, Тэр биднийг сонсдог гэдэг нь Түүний өмнө бидэнд байгаа итгэл зориг юм. Бид юуг ч гуйсан, Тэр биднийг сонсоно гэдгийг бид мэдвэл, бид Түүнээс гуйснаа авсан болохыг мэднэ”* (1 Иохан 5:14-15).

Эзэн Есүсийн нэрээр залбирна гэдэг Түүний хүслийн дагуу залбирна гэсэн үг. Нэг ёсондоо бидний гуйлтыг Есүс Өөрийн Эцэг Бурханд амаараа дамжуулан хэлж байгаатай адил юм. *“Хэрэв та нар Миний нэрээр юуг ч Надаас гуйвал, Би түүнийг чинь хийнэ. Хэрэв та нар Намайг хайрладаг бол, Миний тушаалуудыг сахь”* (Иохан 14:13-14). *“Тэр өдөр та нар Надаас юуны ч тухай асуухгүй. Үнэнээр, үнэнээр Би та нарт хэлье. Хэрэв та нар Миний нэрээр Эцэгээс минь юу ч гуйвал Тэр түүнийг чинь өгнө.”* (Иохан 16:25). *“Би та нарт дахин хэлье. Хэрэв та нараас хоёр чинь ямар нэгэн зүйлийг гуйх талаар газар дээр санаа нийлбэл, тэнгэр дэх Миний Эцэг үүнийг чинь тэдний төлөө биелүүлэх болно. Учир нь хоёр буюу гурван хүн Миний нэрээр хаана цуглана, тэнд Би тэдний дунд байна”* (Матай 18:19-20).

Түүний нэрээр гуйна гэдэг гарт нь хөтлүүлээд дагаж залбирна гэсэн үг юм. Энэ бол хажууд маань сөхрөн суугаа Түүний хүсэл бидний зүрх сэтгэлээр дамжин урсан гарна гэсэн үг. “Түүний нэрээр” гэдэг чухам ийм утгатай. Түүний Нэр бол Тэр өөрөө, Түүний мөн чанарын илэрхийлэл юм. Тиймээс Христийн нэрээр залбирна гэдэг Түүний ерөөлт хүслийн дагуу залбирна гэсэн утгатай. Бурханы Хүүгийн нэрээр бузар муу зүйлийн төлөө гуйж болно гэж үү? Миний залбирч байгаа зүйл Түүний мөн чанарыг илэрхийлж байх ёстой. Миний залбирал ийм байдаг уу? Залбирал нь Ариун Сүнсний хүчийг, Христийн оюун ухааныг, бидний дотор оршин буй мөн бидний төлөө гэсэн Түүний хүсэл сэтгэлийг амьсгал гаргах адил гаргадаг. Эзэний нэрээр илүү их залбирч байхыг Эзэн өөрөө бидэнд заадаг. Бид залбирлынхаа төгсгөлд *“Эзэний ерөөлт нэр дээр залбирлаа”* хэмээн хэлэхгүй байж чаддаггүй билээ. Хэрэв тийм аваас гуйж байгаа бүх зүйл маань Түүний ерөөлт нэрийг нэвт шингээсэн буюу бүгд Түүний нэрийн дагуу байх ёстой. (Самуел Райдаут)

Залбирлаа үнэхээр үр нөлөөтэй байлгая гэвэл Бурхантай асуудлаа дор дор нь шийддэг байх ёстой. Энэ юу гэсэн үг вэ гэвэл амьдралд маань ямар нэгэн гэм нүгэл шургалан орж ирэх бүрд бид даруй түүнийг Бурханы өмнө

гэмшин хүлээж хаях ёстой. “Хэрэв Би зүрхэндээ хорон мууг хүндэтгэсэн бол Эзэн сонсохгүй” (Дуулал 66:18). Бид бас Христ дотор байх ёстой “Хэрэв та нар Миний дотор, Миний үгс та нарын дотор байвал та нар юу хүссэнээ гуй. Тэгвэл та нарын төлөө биелэх болно” (Иохан 15:7). Христийн дотор байгч хүн Түүнтэй маш ойр байж Эзэний хүслийг мэдэх мэдлэгээр дүүрсэн байдаг. Тиймээс залбирахдаа ч мэдлэгтэй залбирч хариулт авна гэдэгтээ бат итгэдэг. Тогтмол Христ дотор байхын тулд Түүний тушаалуудыг дуулгавартай даган биелүүлдэг байх ёстой. Бид “гуйсан болгоноо Түүнээс хүлээн авна. Учир нь бид Түүний тушаалуудыг сахиж, Түүний мэлмийд тааламжтай зүйлсийг үйлддэг билээ” (1 Иохан 3:22). Бурхан залбирлыг маань сонсож хариулдаг байхын тулд бид өөрсдөө зөв сэтгэлтэй байх ёстой (1 Иохан 3:20).

Бид зөвхөн өдрийн тогтсон хэдэн цагт залбирдаг байх ёсгүй. Харин гудамжаар алхаж явахдаа ч, машин жолоодож байхдаа ч, ширээний ард суун ажиллаж байхдаа ч эсвэл гэрийн ажил хийж байхдаа ч Эзэн өөд харж байхаар залбирлын тийм чиг хандлагатай болох ёстой. Тасралтгүй залбирах ийм залбирлын тод жишээг Нехемиагийн амьдралаас харж болно. (Нехемиа 2:4). “Хамгийн Дээд Нэгэний халхавчинд оршигч нэгэн Төгс Хүчит Нэгэний сүүдэр дор амьдарна” (Дуулал 91:1). Төгс Хүчит Нэгэний сүүдэр дор хааяа нэг очихоос тэнд тогтмол байх нь илүү сайн хэрэг билээ.

Эцэст нь хэлэхэд бидний залбирал тодорхой байх ёстой. Тодорхой зүйлийн төлөө залбирч байж тодорхой хариулт авах болно.

Залбирал бол бидэнд олгогдсон үнэхээр гайхалтай эрх юм. Сайн мэдээ дэлгэрүүлэгч Хадсон Тэйлорын хэлсэнчлэн бид чухамдаа залбирлыг ашиглан Бурханаар дамжуулан хүмүүсийг хөдөлгөөнд оруулж сурдаг.

Залбирлын гайхамшигт ертөнцөд гайхамшгийг бүтээх үйлчлэл бидний гарт өгөгджээ! Бид нарны гэрлийг хүйтэн, баргар газруудад тусгаж чадна. Харанхуй хүйтэн шоронгийн өрөөнд итгэл найдварын галыг асааж чадна. Хоригдлуудын хөлөөс дөнгийг нь мулталж чадна. Харийн нутагт, төрсөн гэрийн дулаан уур амьсгалыг аваачиж чадна. Сүнсээр доройтсон хүмүүс далайн чанадад ажиллаж байсан ч тэдэнд тэнгэрлэг найрсаг байдлыг бэлэглэж чадна. Залбирлын хариуд гайхамшиг өгөгддөг!.(Ж. Х Жоуэт)

Энэ тухай Уинхам нэртэй нэгэн зохиолч гэрчлэн бичихдээ: “Сургаал номлоно гэдэг ховор тохиох бэлэг авьяас. Залбирах бэлэг авьяас бол бүр ч ховор тохиох зүйл. Сэлэм лугаа адил хурц номлол заана гэдэг хол байгсдад хүрч үл чадах, зөвхөн ойр тойрныхоо хүмүүст хүрэх зэвсэг юм. Харин залбирал бол илүү өргөн хүрээг хамруулж чаддаг зарим тохиолдолд бүр ч хүчтэй үйлчилж чадах хүчит зэвсэг”

Эзэн минь, Тантай хамт өнгөрөөсөн ганцхан цаг бидний дотоод сэтгэлийг юутай их өөрчилнө вэ. Мөрөн дээрээс маань ямар хүнд ачааг авч хаяна вэ. Ангасан газар хурын ус буухтай адил биднийг өвдөг сөгдөхөд эргэн тойрны маань бүх зүйлс дагаад сөгдөх мэт. Дээш өндийн босоход хол ойрын бүх зүйлс нүдний маань өмнө ил тод ялгаран харагдана. Бид сөгдөнө - юутай дорой! Бид өндийнө - юутай хүчтэй! Гэтэл баяр баясгалан, хүч чадал, эр зориг бүхэн Тантай хамт

байж, Танд залбирах залбирал бидэнд байсаар атал юунд бид өөрсдийгөө болон өрөөл бусдыг үргэлж хүчтэй биш, хайр халамжгүй, сул дорой, зүрх сэтгэлгүй, айсан сандарсан хэмээн буруутгана вэ? – Ричард Тренч.

Наймдугаар бүлэг

СҮНСЛЭГ ТУЛААН

Шинэ Гэрээг унших үед дайн тулааны дүр зургаар газар дээрх Христийн ажил үйлсийг олонтаа дүрсэлсэн байдгийг олж харах тийм хялбар биш ээ. Жинхэнэ Христэд үзэл бол орчин цагийн амар хялбар Христэд үзлээс тэс өөр юм. Үүнийг өнөө үеийн өргөн дэлгэрсэн хувийн таашаалыг хайсан, элбэг хангалуун тансаг амьдралтай хольж хутгаж болохгүй. Христэд үзэл гэдэг үхэн үхтлээ тулалдах тулаан, тамын хүчийн эсрэг тэмцэх байнгын зөрчил тэмцэл юм. Нэгэнт дайн тулаанд орсон гэдгээ, ухрах газар байхгүй гэдгээ ойлгож ухаараагүй дагалдагч хүн энэ дэлхийг амтлагч давс байж чадахгүй.

Дайнд эв нэгдэл чухал Дайнд шалихгүй жижиг зүйл дээр хэрүүл хийх, нэг нэгэндээ атаархах, санал зөрөлдөх цаг зав гарахгүй. Өөр хоорондоо эв түнжин муутай гэр бүл хэврэг байдаг. Эв нэгдэлтэй байна гэдэг даруу төлөв байхын нэр бөгөөд энэ тухай Филипой номын 2-р бүлэгт тодорхой заажээ. Үнэхээр төлөв даруу хүнтэй маргалдаж мэтгэлцэх боломжгүй байдаг. Хэрүүл маргаанд хоёр тал хоёулаа оролцдог. *“Их зан маргаан мэтгэлцээнд л хүргэдэг”* (Сургаалт үгс 13:10). Бардам их зан байхгүй газар хэрүүл маргаан байхгүй.

Дайн тулаанд даруухан, өөрийгөө золиосолсон амьдрал шаардагддаг. Дайн тулааныг заавал хоол хүнсний хомсдол дагалддаг. Итгэгч хүмүүс дайн тулаанд орсон гэдгээ, өөрсдийн нөөцийг аль болох их хэмжээгээр дайн тулаанд зориулах замаар зарлагаа дээд зэргээр хасах ёстойгоо ухааран ойлгох цаг болсон.

Үүнийг нэгэн залуу дагалдагч шиг тодорхой ойлгодог хүн тийм олон байхгүй болов уу. Тэрээр 1960 онд Христитгэлт нэгэн сургуулийн нэгдүгээр курсийн оюутнуудын ангийн дарга байв. Тэр үед түүнд янз бүрийн арга хэмжээ, онц сурлагатанд өгөх шагнал, бэлэг сэлт зэрэгт мөнгө гарган зарцуулах саналууд ирж байжээ. Тэрээр сайн мэдээг дэлэрүүлэх их үйлсэд шууд хувь нэмэр оруулахгүй иймэрхүү зардалд мөнгө зориулахыг сайшаан дэмжихийн оронд ангийн даргын үүрэгт ажлаас чөлөөлөгдөхөөр шийдсэн аж. Түүнийг ангийн даргын үүрэгт ажлаас чөлөөлсөн тухай зарласан тэр өдөр дараах захидал түүний нэг ангийханд тараагдсан байлаа.

Ангийн анд нартаа:

Ангид зохиогдох янз бүрийн арга хэмжээ, онц суралгатанд өгөх шагнал болон бусад бэлэг сэлтэнд мөнгө зарцуулах тухай асуудлыг зөвлөлд өргөн барьсан тэр үеэс хойш би дээрх асуудлуудад хандах итгэгч хүний чиг хандлагын талаар бодох болсон.

Бид өөрсдийгөө, өөрсдийн мөнгө, цаг завьг бүхэлд нь Христэд болон өрөөл бусдад өгч *“Миний төлөө амиа алдсан нь түүнийгээ олох болно”* гэж хэлсэн Эзэний үг хичнээн үнэн болохыг амсаж мэдвэл илүү их баяр хөөрийг олох болов уу гэж бодож байна.

Итгэгч хүн мөнгө болон цаг заваа аврагдаагүй хүмүүст Христийг гэрчлэн таниулах эсвэл Христ доторх Бурханы хүүхдүүдийн итгэлийг өсгөхөд туслах тийм зүйлд зориулахгүй байх нь дэлхий даяар өдөр бүр 7000 мяган хүн өлсгөлөнгөөр үхэж мөн түүнчлэн дэлхийн хүн амын тал хувь нь хүний цоры ганц

итгэл найдварын талаар сонсоогүй байгаа гэсэн үнэн баримттай үл нийцэх мэт санагдана.

Итгэгч бид жижиг хүрээ үүсгэн цуглаж, нийгэмших байдлаа өөрсөдтэйгөө адил бодол санаатай хүмүүсээр хязгаарлаж, цаг зав, мөнгө хөрөнгөө зөвхөн өөрсдийн таашаалд зориулан зарцуулахын оронд Есүс Христийн тухай огт сонсоогүй дэлхийн хүн амын 60 хувьд эсвэл бүр айл саахалтынхаа хүмүүст сайн мэдээг хүргэх үйлсэд тусалбал Бурханыг хичнээн ихээр алдаршуулах билээ.

Бид ангийн фондыг Есүс Христийг алдаршуулах, бидний ойр буюу алс хол оршин суугаа хүмүүст туслах үйлсэд ашиглах боломжтойг мэдсээр атал түүнийг өөрсдөдөө зориулан зарцуулахыг би зөвшөөрч болохгүй гэж бодож байна. Бид энэ мөнгийг өөрсөддөө зарж яагаад ч болохгүй. Хэрэв би миний мэдэх өөр бусад олон хүний адил тарчиг амьдардаг байсан бол амьдралын боломжтой хүмүүс надад сайн мэдээг хүргэж эд материалаар туслаасай гэж хүсэх байсан.

“Та нар хүмүүсийг өөрсдөдөө хэрхэн хандаасай гэж хүснэ, тэдэнд мөн түүнчлэн ханд” “Дэлхийн эд хөрөнгөтэй хэн нэгэн нь өөрийн ах дүүгийн хэрэгцээ, гачигдлыг хараад түүнд туслах сэтгэл үл гаргавал, түүний дотор Бурханы хайр хэрхэн байх билээ?”

Үүний учир Эзэн Есүс Христ өөрийгөө бидний төлөө бүрэн өгснийг (2 Коринт 8:9) та бүхэн харж мэдээсэй хэмээн залбирч 63-р ангийн даргын үүрэгт ажлыг би хүлээлгэн өгч байна.

Эзэн дотор та бүхэнтэй хамтран зүтгэгч Р.М

Дайн тулаан зовлон дагуулдаг. “Өнөөгийн залуус дунд эх орныхоо төлөө алтан амиа өгөхөд бэлэн хүмүүс олон билээ. Тэгвэл итгэгч бид Христ ба Түүний сайн мэдээний төлөө амиа өгөхөд хэнээс ч илүү бэлэн байх ёстой. Ямар ч үнээр олдоогүй итгэл ямар ч үнэ цэнэгүй юм. Хэрэв Эзэн Есүс бидний хувьд ямар нэгэн байдлаар утга учиртай бол амьдралын маань бүх утга учир байх ёстой. Хувийн аюулгүй байдал, зовлон шаналалаас сэргийлэх аливаа зүйл Түүнд үйлчлэхэд саад болох ёсгүй.”

Элч Паулыг өчүүхэн сэтгэлгээтэй шүүмжлэгчид дайрч давшилахад тэрээр элч байх эрхээ хамгаалахдаа өөрийн гарал үүсэл, мэдлэг боловсрол, амжилт ололтыг тоочин дурдаагүй. Харин Эзэн Есүс Христийн төлөө эдэлсэн зовлонгоо ийн тоочжээ:

“Тэд Христийн зарц нар уу? (Би ухаангүй мэт ярьж байна.) Би бүр ч илүү. Хөдөлмөрөөрөө ч илүү, хоригдсоноороо ч илүү бөгөөд тоо томшгүй жанчуулж, үргэлж үхлийн аюулд орж байлаа. Иудейчүүд намайг таван удаа гучин ес ташуурдсан. Намайг саваагаар гурвантаа жанчиж, нэг удаа над уруу чулуу шидэцгээж байв. Гурван удаа би усан онгоцны сүйрэлд өртөж, тэнгисийн гүнд өдөр, шөнийг өнгөрөөж байлаа. Ахин дахин аялан явахдаа, гол мөрний аюул, дээрэмчдийн аюул, нутаг нэгтний аюул, харь үндэстнүүдийн аюул, хотын аюул, говийн аюул, тэнгис дээрх аюул, хуурамч ах дүүсийн дунд байх аюул дундуур явж байсан бөгөөд хөдөлмөр болон хүнд хэцүү байдал дотор байж, олон удаа унталгүй, өлсөж, цангаж, олонтаа хоол ундгүй байж, нүцгэрч, даарч хөрч байлаа. Энэ бүгдээс гадна, би өдөр бүр бүх чуулгануудын төлөө зовних дарамтанд байна” (2 Коринт 11:23-28)

Паул өөрийн итгэлийн хүү Тимотод хандан бичсэн захидалдаа “Христ Есүсийн сайн цэрэг адил надтай хамт зөв” (2 Тимот 2:3) гэсэн байдаг.

Дайн тулаанд удирдлагадаа үг дуугүй захирагдах байдал шаардагддаг. Жинхэнэ цэрэг хүн даргынхаа тушаалыг ямар ч эргэлзээгүйгээр, нэн даруй гүйцэтгэн биелүүлдэг. Христ жирийн даргаас бага зүйлд сэтгэл ханана гэвэл дэмий хэрэг. Бүтээгч, Аврагч Эзэний хувьд тэрээр өөрийг нь даган дайнд орсон хүмүүсээс тушаалыг нь үг дуугүй дагаж бүрэн гүйцэт биелүүлэхийг хүсэн хүлээх эрхтэй билээ.

Дайн тулаан зэр зэвсгээ зөв ашиглахыг шаарддаг. Христэд итгэгчдийн зэвсэг бол залбирал ба Бурханы Үг юм. Итгэгч хүн гал цогтой, итгэлтэй, залбиралд өөрийгөө бүрэн зориулдаг байх ёстой. Зөвхөн энэ л түүнийг дайснуудаас нь хамгаалах бэхлэлт цайз болно. Түүнээс гадна итгэгч хүн Сүнсний сэлэм буюу Бурханы Үгийг бас зөв, гарамгай хэрэглэж сурах ёстой. Дайснууд өөрсдийнхөө хүчээр түүнийг сэлмээ хаях хүртэл хууран мэхлэхийг хичээх болно. Ариун Бичээсийн тэнгэрлэг байдалд эргэлзэх эргэлзээг төрүүлж, хоорондоо зөрчилдөж буй мэт хэсгүүдийг онцлон анхааруулах болно. Шинжлэх ухаан, гүн ухаан, хүний уламжлалт ойлголт зэргийг ашиглан Библийн эсрэг маргаан дэгдээх болно. Гэвч Христийн цэрэг хүн зэвсгээ цагаа олсон ч олоогүй ч хэрэглэж байр сууриа хатуу хамгаалах ёстой.

Энэ дэлхийн хүмүүсийн хувьд итгэгч хүний зэр зэвсэг утгагүй дэмий зүйл мэт санагддаг. Иерихо хотыг буулган авахад үр нөлөөгөө үзүүлсэн тэр төлөвлөгөөг өнөө үеийн цэргийн удирдлагууд үл ойшоох биз ээ. Гидеоны цэргийн багахан хүч өнөө үеийн хүмүүсийн инээдийг хүргэх биз. Давидын чавх, Шамгарын үхрийн шилбүүр болон өнгөрсөн зуунуудын мунхаг хүмүүсээс бүрдсэн Бурханы өрөвдөлтэй цэргийн армиудын талаар юу гэх вэ? Бурхан цэргийн хүчирхэг армийн талд биш харин энэ дэлхийн сул дорой, ядуу хоосон, гологдсон зүйлсийг авч тэд нараар дамжуулан өөрийгөө алдаршуулах дуртай байдгийг сүнслэг ертөнц сайн мэднэ.

Дайн тулаан нь дайснаа мөн түүний стратегийг мэдэхийг шаарддаг. Энэ бол итгэгч хүмүүсийн тэмцэл юм. “Учир нь бидний тэмцэл бол махан бие ба цусны эсрэг биш, харин захирагчид, эрх мэдэл, энэхүү харанхуй ертөнцийн хүчнүүд, тэнгэр дэх бузар муугийн сүнслэг хүчний эсрэг билээ” (Эфэс 6:12). “Сатан ч өөрийгөө гэрлийн тэнгэр элч болгон хувиргадаг учраас гайхах юм алга. Тиймээс хэрэв түүний зарц нар бас өөрсдийгөө зөвт байдлын зарц нар болгон хувиргах аваас энэ нь гайхмаар юм биш аж. Тэдний төгсгөл үйлсийнх нь дагуу байх болно” (2 Коринт 11:14-15) гэдгийг итгэгч бид мэддэг байх ёстой. Сайн бэлтгэгдсэн итгэгч цэрэг хүн дайсны аюул согтуу хүн эсвэл хулгайч дээрэмчин, эсвэл биеэ үнэлэгч хүмүүсийн зүгээс биш харин шашны мэрэгшсэн тэргүүнүүдийн зүгээс ирдэг гэдгийг мэддэг. Бурханы Хүү Христийг загалмайд цовдолсон хүмүүс бол чухамдаа шашны тэргүүнүүд байсан. Эртний чуулганы шахан хавчиж байсан хүмүүс бол шашны тэргүүнүүд байсан. Паул өөрсдийгөө Бурханы зарц хэмээн нэрлэдэг хүмүүсийн гараас хамгийн хүчтэй цохилтыг амсаж

байсан. Өнөөг хүртэл ийм л байсан. Сатаны гар хөл бологчид өнөөдөр зөвт байдлын үйлчлэгчдийн дүрд зүсээ хувиргасан аж. Тэд элдэв шашны хэлээр ярьж, шашны өмсгөл өмсөж, маш их сүсэг бишрэлтэй мэт байдаг ч зүрх сэтгэл нь Христ болон Түүний сайн мэдээг үзэн яддаг.

Дайн тулаан анхаарал сарнихгүй байхыг шаарддаг. “Ямар ч цэрэг цэрэгт татагчдаа таалагдахын тулд өдөр тутмын амьдралын хэрэгт хутгалддаггүй” (2 Тимот 2:4). Христийн дагалдагч хүн Эзэн Есүс Христийн төлөөх зүтгэл болон өөрийнх нь сэтгэлийн дундуур ямар нэгэн зүйл орж саад тотгор учруулахыг зөвшөөрөхгүй байж сурах ёстой. Тэрээр чанга хатуу боловч бусдад хор хүргэдэггүй байх ёстой. Мөн ганцхан их хүсэлд захирагддаг байх ёстой бөгөөд өөр бусад бүх зүйлийг огоорон орхих ёстой.

Дайн тулаанд аюулыг сөрөн зогсох эр зориг шаардагддаг. “Тиймээс бүхнийг хийсний дараа, бузар муу өдөрт эсэргүүцэн бат зогсох чадвартай байхын тулд Бурханы бүрэн зэвсгийг ав. Тэгээд бат зогс...” (Эфэс 6:13-14а). Энэ ишлэлд өгүүлсэн итгэгч хүний зэр зэвсэг дунд ухрах зориулалтын зэвсэг ганц ч байхгүй гэж судлаачид тайлбарласаар ирсэн. Тэгэхээр итгэгч хүнд ухрах газар гэж үгүй аж! Хэрэв бид “....биднийг хайрладаг Түүгээр дамжуулан давуулан дийлдэг” (Ром 8:37) юм бол ухрах хэрэг юу билээ? Хэрэв Бурхан бидний талд зогсдог учраас биднийг эсэргүүцсэн хэн боловч амжилт олохгүй юм бол, тулаанд орохоос өмнө ялалт хэдийнээ бидний талд гэдэг нь баталгаажсан бол ухарч буцах тухай бид яахан бодож чадах билээ?

Өчүүхэн би ялагч хийгээд ялагдагчийн аль байх нь хамаагүй. Хулчгар гэмт хүмүүс бид байдлааны эхний шугамд тулалддаг. Урагш довтлох дайснууд минь хүчирхэг ч зэр зэвсэг минь мохжээ Эзэн минь, Дайснуудын туг далбаа ихэмсэг бардаар намирна. Харин араас минь хутгалахыг Эзэн минь бүү зөвшөөрөөч. – Эми Кармайкал.

Есдүгээр бүлэг

ДЭЛХИЙГ ЭЗЭГНЭХ ЭРХ МЭДЭЛ

Бурхан биднийг бүтээхдээ дэлхийг эзэгнүүлэхээр бүтээсэн. Хүн бид хүн биеийг олж төрөөд дараа нь өт хорхой болж дуусах нь хэзээ ч Түүний хүсэл байгаагүй. Мөн түүнчлэн биднийг амьдралаа “түр зуурын үйлдвэрийн гол ажилтан”-ы ёсоор өнгөрөөхийг Бурхан хүсдэггүй.

Эзэн Бурхан анх хүнийг бүтээгээд түүнд газар дэлхийг захируулахаар өгсөн юм. Хүнд сүр жавхлан ба хүндэтгэлийн титмийг өмсгөж бүх дэлхийг захируулахаар хөлд нь тавьж өгсөн. Хүн бид тэнгэр элчүүдээс бага зэрэг дор боловч агуу дээд, тэнгэрлэг байдлаар хувцаслуулсан.

Анхны хүн Адам Бурханы эсрэг гэм хийх үедээ тэнгэрийн зарлигаар түүнд оноогдсон эрх мэдлийнхээ ихэнхийг алдсан юм. Тэрээр хил хязгааргүй их эрх мэдэл эдлэхийн оронд хязгаарлагдмал газар нутагт тодорхой бус эрх мэдлийг эдлэх болсон аж.

Гэвч бид сайн мэдээгээр дамжуулан эрх мэдлээ дахин эдэлж болохоор болсон. Энэ бол архиран хуцах нохой эсвэл хорт могой зэргийг мэдэлдээ оруулан захирах эрх мэдэл гэхээс илүү Эзэн Бурханд итгэдэггүй хүмүүсийг Христийн өв залгамжлагч болгож, алс хязгаар нутгийг сайн мэдээгээр байлдан дагуулах явдал юм. Ж. Х Жоуэтт хэлэхдээ: “Жинхэнэ христэчитгэл нь цэвэр ёс суртахуун хийгээд сүнслэг байдлаар илэрхийлэгдэж цэвэр ариун, ямар ч хир буртаггүй сэтгэл татам амьдралаар удирдуулдаг” гэсэн байдаг.

Үнэндээ Христэд итгэгч хэмээн нэрлэгдэх нь агуу их нэр төрийн хэрэг бөгөөд Адамын огт мэддэггүй байсан зүйл юм. Бид дэлхий ертөнцийг аврах ажилд Бурхантай хамтран ажилладаг. Т. Юнг ингэж бичиж байжээ: “Хүмүүсийг өөрийгөө ялсан, агуу дээд, эрхэмсэг амьдрал, Христийн хаант улсад үйлчлэх үйлчлэл рүү Эзэний нэрээр адислах нь бидний ажил үүрэг юм.”

Өнөөгийн бид өөрсдийн энэ агуу дээд дуудлагыг ойлгож, зүй ёсоор үнэлж чаддаггүй нь манай үеийн нэг эмгэнэл. Бид амьдралынхаа он жилүүдийг өчүүхэн жижиг зүйлтэй зууралдан өнгөрөөдөг. Дүүлэн нисэхийн оронд газраар мөлхөж, хаан байхын оронд харц боол болдог. Улс орнуудыг Христ рүү байлдан дагуулах хүсэл эрмэлзлэлтэй хүмүүс цөөхөн аж. Харин Чарлиз Спёржин өөр хүн байсан. Тэрээр өөрийн хүүд зориулан доорх хүчирхэг үгсийг бичиж байжээ:

Хэрэв, Бурхан чамайг сайн мэдээ дэлгэрүүлэгч болгохыг хүссэн бол чи саятны ёсоор үхэх ёсгүй. Хэрэв чи сайн мэдээ дэлгэрүүлэгчийн ёсоор амьдрах ёстой газраа хааны нэр сүрд шунавал надад энэ чинь таалагдахгүй. Энэ бүх хаад ноёд, орд харш, титэм зэрэг бүгд нийлээд хүний амийг Христээр дамжуулан аврах эрхэм үйлс, Христийн сүм чуулганыг сүндэрлүүлэн босгох хийгээд сайн мэдээ дэлгэрүүлэгч хүний мөр гараагүй алс хязгаар нутагт сайн мэдээг номлох онцгой хүндэтгэлүүдтэй харьцуулахад юу билээ?

Өөр бас нэг хүн бий. Энэ бол алдартай төрийн зүтгэлтэн, сайн мэдээ дэлгэрүүлэгч Жон Мотт юм. Америкийн Нэгдсэн Улсын ерөнхийлөгч Кулиж

түүнээс Япон улсад суух бүрэн эрхт элчин сайдаар ажиллахыг хүсэхэд тэрээр “Ноён ерөнхийлөгчөө, Бурхан намайг Өөрийнхөө элчин сайд болгохоор дуудсанаас хойш өөр бусад ямар ч дуудлагыг миний чих сонсохоо больсон” хэмээн хариулж байжээ.

Билли Грахам бас дээрх хоёртой адил бодол санаатай хүн байсан. Стандарт Оил хэмээх нефтийн компани алс Дорнодод ажиллуулах хүн хайж байхдаа сайн мэдээ дэлгэрүүлэгч хүмүүсийг төлөөлөгчөөр сонгодог байжээ. Тиймээс түүнд арван мянган доллар санал болгоход Билли татгалзжээ. Тэд хорин тавыг санал болгоход бас татгалзав, Дараа нь тавин мянгыг санал болгоход Билли урьдын адил мөн татгалзахад тэд “яагаад татгалзаад байгаа юм бэ?” гэжээ. Билли тэдэнд “Та нарын өгч байгаа мөнгөнд учир байхгүй. Харин ажил чинь л дэндүү жижиг юм. Бурхан намайг сайн мэдээ дэлгэрүүлэгч болгохоор дуудсан” хэмээн хариулсан гэдэг.

Христэд итгэгч хүний дуудлага бол бусад бүх дуудлагаас илүү эрхэм дээд дуудлага юм. Үүнийг ухааран ойлгох үед бидний амьдрал шинэ өндөрлөгт хүрэх болно. Дахиад бид өөрсдийгөө эмч байхаар, багш байхаар инженер байхаар дуудагдсан гэх мэтээр ярихаа больж оронд нь элч төлөөлөгч байхаар дуудагдсан, бусад бүх зүйл бол амин зуулгад хэрэглэгдэх зүйл хэмээн ярих болно. Бид өөрсдийгөө бүтээл бүрд сайн мэдээг хүргэж, бүх үндэстнийг дагалдагч болгож, дэлхий ертөнцөд авралын зар тараахаар дуудагдсан хүмүүс хэмээн үзэх болно.

Асар том даалгавар байна гэж үү? Тийм ээ асар том боловч боломжгүй биш даалгавар. Гэвч энэ даалгавар итгэгч хүн бүрээс бүх зүрх сэтгэлээрээ нэн даруй хөдлөхийг шаарддаг.

Эхлээд дэлхийн бүх хүн амын талаар бодоцгооё. Өнөөдөр дэлхий дээр зургаан тэр бум хүн амьдардаг бөгөөд хүн амын өсөлт толгой эргэм хурдаар өсөн нэмэгдэж байгаа. Христийн үеэс хойш нэг тэрбум хүнд сайн мэдээг хүргэхэд бүхэл бүтэн арван найман зуун шаардагдсан. Харин нэг зууны дараа хоёр тэрбум хүн болсон. Хорьдугаар зуунд энэ тоо 4.4 тэрбум хүртлээ нэмэгдсэн. Өнөө үед хүн амын гурван өдрийн өсөлт Сан Франсиско хотын хүн амтай тэнцэж байгаа.

Хүн төрөлхтний өсөлтийн энэ тэсрэлтийг тоон үзүүлэлтээр авч үзвэл өнөөгийн хүн амын тоо 1960 оныхоос хоёр дахин их болсон аж. Өөрөөр хэлбэл бүтээлээс хойш амьдарч байсан бүх хүний арван хувь нь өнөөдөр амьд байгаа гэсэн үг.

Дэлхий ертөнцөд яаралтай авралын зар тараах шаардлагатай байгааг бид доорх тоо баримтаас үзэж болно. Өндөр хөгжилтэй улс орнуудын дундаж наслалт 70 гаруй жил байдаг бол бусад улс орнуудынх 40-өөс бага байдаг аж. Хүмүүс өнө мөнх рүү гулсан орсоор байна. Бид тэдэнд сайн мэдээ хүргэх цагаа дэмий үрэх ёсгүй.

Дэлхий ертөнцөд авралын зар хүргэх ажлын гол цөм нь Библи юм. “Тиймээс итгэл нь сонсохоос, сонсох нь Христийн үгээр ирдэг” (Ром 10:17). Дэлхий дээр 6500 гаруй хэл байдаг. Гэтэл Библи 2500 орчим хэл дээр орчуулагдсан ажээ. Эдгээр Библи болон Библийн хэсгүүдээс хэрэглэж байгаа олон хэл хэт хуучирч хүмүүст харь хэл мэт болсон байгаа. Энэ бүхэн дээр нэмэгдэх нэгэн гунигтай гэмээр баримт бол дэлхийн нийт хүн амын 16

хувь нь бичиг үсэггүй хүмүүс бөгөөд тэд Библи байсан ч уншиж чадахгүй.

Барууны улс орнууд шашин шүтлэгийн хувьд эрх чөлөөтэй, сайн мэдээний гэрэл туссан газар төдийгүй уншиж, үзэх материал ихтэй газар. Тэнд ажиллаж байгаа сайн мэдээ дэлгэрүүлэгч хүмүүс дэлхийд авралын зар тараах ажлын галыг өрдөж сайн мэдээгээр дутагдаж байгаа хүмүүсийн хэрэгцээг хөнгөвчилж өгөх ёстой.

Дэлхийн хүн амын гурван хувь нь өөрсдийгөө итгэгч гэдэг хүмүүс боловч нэр зүүсэн хүн олон бий. Авралын зарын итгэгч хүн чухам хэд байгааг хэн ч хэлж мэдэхгүй. Юутай ч нэг хүн нэгэн тооцоог хийж зүрхэлжээ. Энэ бол жинхэнэ итгэгч хүн бүр сайн мэдээг 40 хүнтэй хуваалцвал дэлхийд авралын зарыг хэдийнээ хүргэчих байсан гэсэн тооцоо юм.

Дэлхий дээр нэг тэрбум орчим католик, 217 сая үнэн алдартан, 351 сая протестант байдаг.

Харин хамгийн хурдацтай хөгжиж байгаа шашин бол Лалын шашин юм. Лалын шашинтны 1.3 сая нь 25-аас доош насны залуучууд. Дэлхийн 15 улс орон бараг тэр чигээрээ лалын шашин шүтдэг. Дэлхий дээрх 10200 гаруй шашин шүтлэгээс хинду, будда, атист, иудагийн шашнууд ихэнх хувийг эзэлдэг. Энэ бүгд нийлээд Аврагч Эзэнийг таньж мэдээгүй хүний тоог 1.4 тэр бум болгож байна.

Коммунист үзэл өнөө үед ч Христэд итгэлийн гол дайсан хэвээр байгаа. Энэ үзэл дэлхийн хүн амын тавны нэг буюу Хятад, Куба, Вьетнам, Хойд Солонгос болон өөр бусад газруудын хүмүүсийг сайн мэдээнээс хол байлгахыг хичээсээр ажээ.

Эзэн Есүс дэлхий дээрх бүх хүний төлөө амиа өгсөн учир Түүнд ямар ч шашны хүн бүрийн амь үнэтэй. Хүн бүр сайн мэдээг сонсох ёстой. Тиймээс ч сайн мэдээний хэрэгцээ үнэхээр агуу их ажээ.

Тэгвэл өнөөгийн дэлхий ертөнцөд Христийн сайн мэдээг яаж хүргэх вэ? Үүний хариулт энгийн аж. Бурханыг бүх зүрх сэтгэлээрээ хайрладаг, хөршөө өөрийн бие адил хайрладаг эрэгтэй эмэгтэй хүмүүсээр дамжуулан хүргэж болно. Энэ даалгаврыг зөвхөн бууршгүй их хайраас ундрэн гарах чин сэтгэлийн үнэнч зүтгэлээр биелүүлж чадна.

Христийн хайранд бүрэн олзлогдсон хүмүүс Түүний төлөө юу ч хийхээс үл буцах аж. Тэд дэлхийн ашиг сонирхлын төлөө хэзээ ч хийхгүй зүйлээ Христийг хайрласан хайрынхаа төлөө хийдэг. Тэд өөрсдийн амийг ч үл хайрлах агаад хүмүүс сайн мэдээг сонсох хүсэлгүйгээр мөхөх вий хэмээн өөрсдийгөө зориулсаар, байгаа бүхнээ зарцуулсаар байдаг.

Загалмай дээр цовдлогдсон Эзэн минь

Үхэж байгаа хүний амийг хайрлах их хайрыг надад өгөөч.

Зүрх сэтгэлийг минь Өөртэйгөө үргэлж ойр байлгаач.

Алдагдсан хүмүүсийг Тан руу аваачих

Загалмайн агуу их хайрыг надад өгөөч – Жэймс А. Стюард.

Хайраар хөглөгдөхгүй л бол ямар ч үйл хэрэг амжилт олохгүй, ашиг гаргахгүй. Хайргүй бол үйлчлэл нь хоосон хангинах цантай адил юм. Харин Христийн төлөө асан дүрэлзэх их зүтгэлтэй хүн хайраар удирдуулан явбал дэлхий дээрх ямар ч хүч сайн мэдээний урагш тэмүүлэх их хүчийг зогсоож чадахгүй.

Тэгвэл, Есүс Христэд бүрэн худалдагдсан, Түүнийг хайрлах хайранд

хөтлөгдсөн, газар дэлхий, далай тэнгисийг сүр жавхлант сайн мэдээний үгээр хөндлөн гулд туулсан, шинэ шинэ газар нутаг руу цуцахыг үл мэдэн тэмүүлсэн, уулзаж учирсан хүн бүрийг Христийн амиа өгсөн хүн хэмээн үздэг, хүн бүрийг өнө мөнхөд Эзэнд магтаал хүндэтгэлийг өргөгч болгохыг хүсэн тэмүүлдэг хэсэг бүлэг дагалдагчийг дүрсэлж нэг үзэцгээе. Христийг мэддэггүй дэлхийн бүсад хүмүүст Түүнийг мэдүүлэхийн тулд ийм хүмүүс ямар аргаар ажиллах вэ?

Шинэ Гэрээнд нэгдүгээрт, олон нийтэд ил тод тунхаглах, хоёрдугаарт хувьчлан сургаж бэлтгэх (жнь, Үйлс 20:20) гэсэн хоёр арга замаар сайн мэдээг тараах тухай өгүүлсэн байдаг.

Эхнийх нь арга замыг Эзэн Есүс болон Түүний дагалдагчид нийтлэг хэрэглэдэг байсан. Тэд хүмүүс олноороо цугласан газар бүрийг сайн мэдээ дэлгэрүүлэх боломж хэмээн үзэж сайн мэдээг тунхагладаг байсан. Тиймээс бид ч бас зах зээлийн газар, шорон, янз бүрийн цугларалтууд наран шарлагын газар, голын эрэг зэрэг хүмүүс олноороо цугласан газруудыг сайн мэдээ дэлгэрүүлэх газар гэж үздэг. Сайн мэдээний яаралтай хэрэгцээ болон түүний агуу их дээд чанар таатай нөхцөл байдал бүрдэхийг хүлээх аргагүй болгож байна.

Есүст итгэх итгэлийг сурталчлах хоёр дахь арга зам бол хувь хүнийг хувьчлан сургаж бэлтгэх арга юм. Эзэн Есүс чухам энэ аргыг хэрэглэн арван хоёр дагалдагчаа сургаж бэлдсэн. Тэрээр өөртэй нь хамт байж болох, Өөрийнхөө өмнөөс илгээж болон энэ цөөхөн хүнийг дуудсан юм. Тэрээр өдрөөс өдөрт тэдэнд Бурханы үнэнийг заан сургаж, ажил үүргийг хүлээлгэн өгч, өмнө нь тулгарах аюул, хүнд хэцүү байдлуудыг урьдчилан сануулж байсан. Бурхантай харьцахдаа тэднийг байлцуулж суу алдарт боловч хүнд хэцүү тэнгэрлэг төлөвлөгөөнийхөө хамтран зүтгэгч болгосон. Дараа нь тэднийг сүрэг чоно руу хонь болгон илгээсэн юм. Ариун Сүнсний хүчийг олсон тэд, үхлээс амилан, тэнгэр өөд одсон суу алдарт Аврагчийг дэлхий ертөнцөд таниулахаар хөдөлцгөөсөн. Энэ арга үнэхээр үр нөлөөтэй байсныг нэг нь урваж арван нэгүүлээ болсон энэ цөөхөн хүн дэлхий ертөнцийг Эзэн Есүс Христийн төлөө хэрхэн орвонгоор нь эрүүлснээс харж болно.

Элч Паул энэ аргыг зөвхөн өөрөө хэрэгжүүлсэн төдийгүй Тимотод мөн захиж *“Олон гэрч нарын өмнө надаас сонссон зүйлсийг бусдад заах чадвартай итгэмжит хүмүүст даатга”* (2 Тимот 2:2) хэмээн хэлж байсан. Үүнийг хэрэгжүүлэхийн тулд эхлээд анхаарал болгоомжтойгоор, залбирлаар итгэмжит хүмүүсийг сонгох хоёрдугаарт, тэдэнд сүр жавхлант зөн харааг дамжуулах гуравдугаарт, бусдыг дагалдагч болгохоор тэднийг илгээх ёстой. (Матай 28:19)

Тооны хойноос хөөцөлдөж хүмүүсийг бөөн бөөнөөр нь хойноосоо дагуулахыг хүсэн шунадаг хүмүүст энэ арга явцгүй, залхуутай мэт санагдах байх. Гэвч Бурхан юу хийж байгаагаа Өөрөө мэдэх бөгөөд Түүний арга хамгийн дээд зэргийн сайн арга юм. Зөвхөн өөрийн таашаалыг хайдаг үй олон сүсэгтнээс үнэнч зүтгэлтэй, итгэмжит цөөхөн дагалдагч Бурханы төлөө илүү ихийг хийн гүйцээж чадна.

Ийм дагалдагчид Христийн Нэрээр урагш давшихдаа Бурханы Үгэнд тоймлогдсон үндсэн зарчмуудыг мөрдлөг болгодог. Юуны өмнө тэд могой

шиг ухаантай боловч тахиа шиг гэм хоргүй байх аж. Хүнд бэрх зам туулах үедээ Бурханы нөөцөөс мэргэн ухааныг авахын зэрэгцээ итгэгч нөхдийнхөө дэргэд номхон даруу, дорд дөлгөөн байдаг. Тэдний биеийн хүч чадлаас айх шалтаг хэнд ч үгүй бөгөөд харин тэдний залбирал болон зогсоошгүй гэрчлэлээс айвал зохино.

Ийм дагалдагчид дэлхийн улс төрөөс хол байдаг. Аль нэг засаг төр буюу улс төрийн бодлогын эсрэг тэмцэх ёстой хүмүүс гэж өөрсдийгөө боддоггүй. Тэд ямар ч төр засгийн дор ажиллаж чадах ба Есүсээс татгалзаж Түүнийг гэрчлэхээ болихыг л шаардахгүй бол ямар ч засаг төрд үнэнч байж чадна. Хэрэв тэднээс үүнийг шаардвал тэд энэ шаардлагыг дагахаас татгалзаж үр дагаврыг нь биеэрээ амсахад бэлэн байдаг. Гэвч тэд хэзээ ч хүний засаглалын эсрэг хуйвалдаж хувьсгалт үйл хэрэгт оролцдоггүй. Эзэн Есүс Иохан 18:36-д *“Миний хаанчлал бол энэ ертөнцийнх биш ээ. Хэрэв Миний хаанчлал энэ ертөнцийнх байсан бол Намайг иудейчүүдийн гарт өгөхгүйн тулд Миний зарц нар тэмцэх байсан. Харин одоо Миний хаанчлал эндхийнх биш”* хэмээн хэлээгүй гэж үү? Есүсийн дагалдагчид бол тэнгэрлэг улс гүрний элчин сайд бөгөөд тиймээс ч энэ дэлхийг харийн хүний ёсоор аянчны ёсоор туулдаг.

Тэд юу ч хийсэн үүндээ туйлын үнэнч шударга хандаж ямар нэгэн байдлаар заль мэх гаргахаас зайлсхийдэг Тэдний “үгүй” нь үгүй байж “за” нь за байх аж. Мөн зөв зорилгоор худал хэлж болно гэсэн нийтлэг ойлголтоос татгалздаг. Ямар ч тохиолдолд сайны төлөө мууг үйлдэх нь үгүй. Ийм хүн бүр гэм нүгэл хийснээс үхсэн нь дээр гэдийг ухамсраараа харуулж чаддаг.

Ийм хүмүүс ажил үйлсээ тухайн орон нутгийнхаа сүм чуулгантай бат холбодог нь тэдний бас яг баримталдаг нэг зарчим юм. Тэд хүмүүсийг Эзэн Есүст итгүүлэхээр дэлхийн ургацын талбай руу явдаг боловч итгэсэн хүмүүсийн ариун итгэлийг өсгөж, бэхжүүлэхийн тулд тэднийг тухайн газрынх нь чуулганы нөхөрлөлтэй холбож өгдөг. Чуулган бол Есүст итгэх итгэлийг газар дэлхий дээр сурталчлах Бурханы нэгж байгууллага бөгөөд чухам энд хамгийн шилдэг, хамгийн бөх бат ажлын суурь тавигддаг гэдийг жинхэнэ итгэгч хүн ойлгож мэдсэн байдаг.

Дагалдагч хүн аливаа холбоо сүлбээнээс зайлсхийх нь ухаалаг хэрэг мөн. Итгэгч хүмүүсийн үйл хөдлөлийг хүний аль нэг байгууллага зааж зааварчлах ёсгүй. Тэд үүний эсрэг бат хатуу зогсох ёстой бөгөөд хийх ажлынхаа зааврыг тэнгэр дэх удирдлагаасаа шууд хүлээн авдаг. Энэ бол нутгийнхаа чуулганы итгэгчдийн итгэл болон тушаал зааваргүйгээр ажилладаг гэсэн үг биш юм. Харин үүний эсрэгээр итгэгч нөхдийн өгсөн тушаал зааврыг аливаа үйлчлэлд зориулан дуудсан Бурханы дуудлагын баталгаа хэмээн үздэг. Гэвч Христэд үйлчлэхдээ Өөрийнх нь өгсөн удирдамж ба Үгний дагуу үйлчлэхийг илүүд үзэх ёстой.

Эцэст нь хэлэхэд ийм дагалдагч хүмүүс нэрд гарахаас зайлсхийж арын шугамд байхыг хичээдэг. Учир нь Есүсийг алдаршуулж Түүнийг бусдад таниулах нь тэдний гол зорилго юм. Тэд өөрсдөдөө агуу зүйлийг эрж хайдаггүй бөгөөд дайсандаа ч төлөвлөгөөгөө мэдүүлэхийг хүсэхгүй. Үүний учир дагалдагчид аливаа магтаал ба зэмлэлийг үл хайхран сайрхаж гайхуулалгүйгээр чимээгүйхэн ажилладаг. Тэд “тэнгэр бол ажлынхаа үр

жимсийг хүртэх хамгийн аюулгүй, хамгийн найдвартай газар” гэдгийг мэддэг.

Аравдугаар бүлэг

ДАГАЛДАГЧ БА ГЭРЛЭЛТ

“Мөн тэнгэрийн хаанчлалын төлөө өөрсдийгөө тайган болгосон тайган ч байдаг юм. Үүнийг хүлээж авах чадвартай нэг нь хүлээн аваг” (Матай 19:12).

Дагалдагч хүн бүр Бурхан намайг гэрлүүлэхийг хүсдэг үү эсвэл ганц бие байлгахыг хүсдэг үү гэсэн асуулттай тулгардаг. Энэ бол бүхэлдээ зөвхөн Эзэнтэй хамт шийдэх хувийн асуудал юм. Энэ талаар хэн ч хэн нэгэнд заах ёсгүй бөгөөд энэ хэрэгт хөндлөнгөөс оролцох нь аюултай хэрэг мөн.

Бурханы Үгэнд гэрлэлтийн тухай ерөнхийд нь заахдаа үүнийг Бурхан анх хэд хэдэн зорилгоор хүн төрөлхтөнд зориулан үүсгэсэн гэдэг.

Гэрлэлт нь хүмүүст нөхөрлөл ба баяр жаргалыг эдлүүлэхэд зориулагдсан. Бурхан *“Хүн ганцаараа байх нь сайн биш”* (Эхлэл 2:18) гэдгийг харсан ажээ.

Гэрлэлт нь хүн төрөлхтнийг өсгөн үржүүлэхэд зориулагдсан. Үүнийг Эзэний өгсөн тушаалаас тодорхой харж болно: *“Өсөн нэмэгдэж, өнөр өтгөн болж газар дэлхийг дүүргэн, газрыг эзэмш”* (Эхлэл 1:28).

Гэрлэлт нь гэр бүлийн болон нийгмийн цэвэр ариун байдлыг хадгалахад зориулагдсан. *“Харин садар самуун байдалд орохгүйн тулд эр хүн бүр эхнэртэй, эмэгтэй хүн бүр нөхөртэй байг”* (1 Коринт 7:2). Гэрлэлт нь цэвэр ариун амьдрал, Христэд үйлчлэх үйлчлэл болон үнэнч зүтгэлтэй харшлах тухай Бурханы Үгэнд заасан зүйл ганц ч байхгүй. Харин Библид *“Бүгд гэрлэлтийг хүндлэгтүн. Ор дэр нь ч бузартаагүй байг”* (Еврей 13:4а) гэсэн байдаг. Бас *“Эхнэрийг олдог хүн сайныг олж...”* (Сургаалт үгс 18:22) гэсэн үг Библид бий. *“Ганцаараа байснаас хоёул байх нь илүү дээр болой”* (Номлогчийн үгс 4:9) гэж хэлсэн номлогчийн үгсийг, ялангуяа эр эм хоёр хоёулаа Эзэнд үйлчлэх үйлчлэлээр нэгдсэн бол гэрлэлттэй холбох нь их байдаг. Дэд хууль номын 32:30-д нэг хүн мянган хүнийг хөөдөг бол хоёр хүн арван мянган хүнтэй тулалддаг гэсэн нь нэгдэж нийлсэн хүчний үр нөлөө хэрхэн нэмэгддэгийг харуулсан аж.

Гэсэн ч хэдийгээр гэрлэлт нь ерөнхийдөө хүн төрөлхтөнд зориулсан Бурханы хүсэл мөн боловч хүн бүрд зориулсан Бурханы хүсэл байх албагүй. Гэрлэлтийг хувь хүний зайлшгүй эдлэх эрх хэмээн үзэж болох ч Эзэн Есүсийн дагалдагч хүн Эзэндээ ганц сэтгэлээр үйлчлэхийн тулд энэ эрхээсээ татгалзаж болох талтай.

Эзэн Есүс Өөрийнх нь төлөө тайган болохоор шийдсэн хүмүүс Түүний хаант улсад орох болно хэмээн хэлж байсан. *“Учир нь эхийнхээ хэвлийгээс төрөхдөө тайган төрсөн хүн байдаг. Хүмүүсийн тайган болгосон тайган хүмүүс ч байдаг. Мөн тэнгэрийн хаанчлалын төлөө өөрсдийгөө тайган болгосон тайган ч байдаг юм. Үүнийг хүлээж авах чадвартай нэг нь хүлээн аваг”* (Матай 19:12).

Энэ бол хувь хүн зөвхөн сайн дурын үндсэн дээр өргөх тангараг

бөгөөд энэ нь доорх хоёр хүчин зүйл дээр үндэслэгддэг:

1. Бурхан түүнээс ганц бие амьдралаар амьдрахыг хүсэж байгааг мэдрэх мэдрэмж
2. Гэр бүлийн амьдралын нэмэлт үүрэг хариуцлагаас ангид байж Эзэний үйл хэрэгт өөрийгөө бүрэн зориулах хүсэл.

Үүний тулд хүн Бурханы дуудлагыг тодорхой сонсож ойлгосон байх ёстой (1 Коринт 7:7б). Зөвхөн энэ тохиолдолд тухайн дагалдагч Эзэн түүнд шаардлагатай ивээл хайрыг өгнө гэдэгт бат итгэж чадна.

Үүнийг сайн дурын үндсэн дээр хийх ёстой. Гэрлэхгүй байх шийдвэрт шашин нөлөөлөх тохиолдолд цэвэр бус, ёс суртахуунгүй явдалд орох аюул улам нэмэгддэг.

Гэрлээгүй хүн өөрийгөө Хааны ажил үйлсэд илүү бүрэн зориулж чадах тухай элч Паул онцлон тэмдэглэсэн байдаг. *“Гэрлээгүй хүн Эзэнд яаж таалагдах вэ хэмээн Эзэний юмсад санаа тавьдаг. Харин гэрлэсэн хүн эхнэртээ яаж таалагдах вэ хэмээн ертөнцийн юмсад санаа тавьдаг”* (1 Коринт 7:32-33).

Элч Паул хэдийнээ гэрлэсэн хүмүүст ч бас хандан Христийг таниулах агуу их үйлсэд бүх зүйлээ зориулахыг ахар богино цаг хугацаа биднээс шаардаж байна хэмээн хэлж байсан.

“Ах дүү нар аа, үүнийг би та нарт хэлье. Цаг хугацаа охор богино болжээ. Цаашдаа эхнэртэй хүмүүс нь эхнэргүй мэт уйлж байгаа хүмүүс нь уйлаагүй мэт, баярлаж байгаа хүмүүс нь баярлаагүй мэт, худалдан авч байгаа хүмүүс нь өмч хөрөнгөгүй мэт, энэ ертөнцийг хэрэглэж байгаа хүмүүс нь бүрэн дүүрнээр ашиглаагүй мэт болох ёстой аж. Учир нь энэ ертөнцийн хэлбэр өнгөрөн одож байна” (1 Коринт 7:29-31).

Энэ бол мэдээж эр хүн гэр бүлийн үүрэг хариуцлагаас татгалзаж, эхнэр хүүхдүүдээ орхин сайн мэдээ дэлгэрүүлэхээр явах ёстой гэсэн үг биш ээ. Харин гэр бүлийн таатай сайхан, сэтгэл хангалуун амьдралын төлөө амьдарч, эхнэр хүүхдээ Христийг хоёр тавих шалтаг болгон ашиглах ёсгүй гэсэн үг юм.

Ч.Т Стадд сүйт бүсгүй нь түүнийг хэт их хайрласнаас бол Эзэн Есүсийг хоёрт тавих вий хэмээн болгоомжилсон тул түүнд өдөр бүр уншиж байх шүлгийг ийн зохиосон гэдэг:

Эзэн Есүс Тандаа би хайртай
Та надад Чарлигаас ч илүү үнэтэй.

Коммунистууд дэлхий ертөнцийг өөрсдийн үйл хэргийн төлөө байлдан дагуулах их үйлсийн төлөө гэр бүлээ хоёрт тавьж сурсан хүмүүс. Үүний нэг жишээ бол Гордон Амолд Лонсдэйл юм. Түүнийг 1960 онд Англи улсад тагнуул хийсэн хэргээр баривчилсны дараа цагдаа нар түүнээс эхнэрийнх нь бичсэн захиа болон тэр захидалд хариулсан зургаан хуудас захидлыг олж байжээ. Эхнэр нь түүнд ийн бичсэн байлаа:

Амьдрал үнэхээр шударга биш ажээ. Чамайг ажилтай гэдгийг, ажил хийх үүрэгтэй гэдгийг бас ажилдаа дуртай ажилдаа бүхнээ зориулан хичээнгүйлэн ажилладаг гэдгийг би сайн ойлгож байна. Гэсэн ч эмэгтэй хүний хувьд миний ойлголт тун явцуу бөгөөд би маш их зовон шаналж байна. Хэрэв чи надад хайртай гэдгээ бичвэл сэтгэл минь бага зэрэг хөнгөрөх болов уу.

Энэ хэсэгт зориулан Лонслэйдийн бичсэн хариу:

Миний хэлж чадах ганц зүйл гэвэл би ганц л удаа амьдарна. Энэ ганц амьдралаа эргэн харахад ичихээргүй амьдрахыг би бүхнээс илүү хүсэж байна. Би доо 39-тэй. Надад тийм их нас үлдсэн гэж үү?

“Ах дүү нар аа, үүнийг би та нарт хэлье. Цаг хугацаа охор богино болжээ. Цаашдаа эхнэртэй хүмүүс нь эхнэргүй мэт” (1 Коринт 7:29) байгтун хэмээн элч Паул бичиж байсан.

Залуу дагалдагчид бодлогогүйгээр яаран гэрлэх нь бий. Энэ нь тэднийг Христийн үйлсэд дээд зэргээр ашиглагдах замаас салгах урхи болгох боломжийг адгийн муу ёрын сүнсэнд олгодог. Сайн мэдээ дэлгэрүүлэгч, ирээдүйтэй, хүсэл эрмэлзлэлээр дүүрэн олон сайхан залуучууд гэрлээд зорилгоосоо няцаж байсан удаатай.

Гэрлэлт нь Христийг хүн бүрт сонсгох их үйлсийн биелэлтэд саад болох заналт дайсан болж болно.

Гэрлэлтийг Бурхан өгсөн. Гэвч энэ нь Бурханы хүсэлд саад болох үед буруугаар ашиглагдах ажээ. Харийн нутагт очиж ажиллахаар Бурханаар дуудагдсанаа тодорхой мэдэх атал өөр хэн нэгэнтэй амьдралаа холбосноос болж зорьсон газраа хүрэлгүй буцсан эр, эм олон хүнийг нэрлэж болно.... Хүний амьдралд зориулсан Бурханы зорилгод юу ч, тэр ч бүү хэл Бурханаас заяасан амьдралынх нь хань ч саад болох ёсгүй.... Сайн мэдээ дэлгэрүүлэгч зарим хүн хайртай хүмүүсээ Бурханы хүслээс дээгүүр тавьснаас болж өнөөдөр хүмүүс Христийг мэдэж авахгүйгээр нас нөгцсөөр байна.

Сайн мэдээг дэлгэрүүлэх үйлсийн тэргүүн шугамд ажиллахаар зорьсон сайн мэдээ дэлгэрүүлэгч хүмүүс ялангуяа ганц бие байх нь илүү дээр байдаг.

Галын тэргүүн шугамд явж байгаа эрэгтэй эмэгтэй хүмүүс амьдралын хамгийн наад захын ая тухтай байдлаа алдах нь бүү хэл амь насаа ч алдаж болох аюултай тулгардаг. Ийм хүмүүс бэрхшээл зовлонг дааж, сайн цэргийн ёсоор тулалдаж, энэ насны амьдралын элдэв зүйлд дарагддаггүй, илүүдэл жингүй сайн тамирчин шиг байх үүрэгтэй... Энэ бол онцгой үйлчлэлд зориулсан дуудлага, ажил мэргэжил, тусгай томилолт юм.

Энэ дуудлагыг сонсож улмаар хүлээн авч хариулсан хүмүүс онцгой шагналыг хүртэх болно. *“Үнэнээр Би та нарт хэлье. Хүний Хүү Өөрийн сүр жавхлант сэнтийдээ залрах үед Намайг дагасан та нар ч мөн Израилийн арван хоёр овгийг шүүж, арван хоёр сэнтий дээр залрах болно. Миний нэрийн төлөө өөрийн гэр орноо, ах дүүсээ, эгч дүүсээ, эсвэл эцэг эхээ,*

хүүхдүүдээ, эсвэл эдлэн газраа орхисон хүн бүр зуу дахин ихийг хүртэх бөгөөд мөнх амийг өвлөх болно” (Матай 19:28-29)

Арван нэгдүгээр бүлэг

ТӨЛӨХ ҮНИЙГ ТООЦ

Эзэн Есүс итгэлийн тухай уран гоё яриагаараа хүмүүсийг урхидах гэж хэзээ ч оролдож байгаагүй. Бас олонд алдартай номлол сургаалаар араасаа үй олон хүн дагуулахыг ч хүсээгүй.

Харин хүмүүс Түүнийг тойрон шавах үед дагалдагч байх тухай чанга хатуу сургаалыг зааж тэднийг шигшдэг байсан.

Эзэн Есүс нэг ийм тохиолдолд Өөрийг нь дагах хүсэлтэй хүмүүс эхлээд төлөх үнээ тооцох ёстойг ярьж ийн хэлжээ:

“Та нарын хэн чинь цамхаг барья гэж хүсвэл, эхлээд үүнийг дуусгах хангалттай хөрөнгөтэй юу гэдгээ үзэхийн тулд суугаад зардлыг нь тооцоолдоггүй вэ? Тэгэхгүй бол, түүнийг сууриа тавьчихаад дуусгаж чадахгүйг нь харсан бүхэн түүнийг шоолж, Энэ хүн барьж эхэлсэн ч, дуусгаж чадсангүй” гэх болно.

Эсвэл нөгөө хааны эсрэг дайлаар мордохдоо, өмнөөс нь айсуй хорин мянган дайчдыг арван мянган дайчид нь сөрж зогсох хүч болж чадах эсэхийг урьдчилан зөвлөлдөхөөр суухгүй байх ямар хаан байх билээ? Хэрэв чадахгүй бол, өнөөх хааныг бүр хол байхад нь тэр энхийн хэлэлцээр гуйн элчээ илгээнэ” (Лук 14:28-32).

Тэрээр дээрх ишлэлүүдэд итгэгч хүний амьдралыг барилга барих ажил болон дайн тулаантай зүйрлэсэн аж.

Есүс хэлэхдээ барилга барихаасаа өмнө түүнийг барьж дуусгахад хүрэлцэхүйц мөнгө байгаа эсэхийг эхлээд тооцохгүйгээр барьж эхлэх нь мунхаг хэрэг мөн. Эс бөгөөс дутуу баригдсан барилга таны холын хараагүйг илтгэсэн хөшөө болон зогсох болно гэжээ.

Юутай үнэн үг вэ! Олон хүнийг хамарсан авралын зарын үйл ажиллагаан дээр сэтгэлийнхээ халуун дулаан хөдлөлөөр Христийг хүлээж авахаар шийдэх нэг хэрэг. Харин өөрөөсөө татгалзаж, өдөр бүр загалмайгаа үүрэн Христийг дагана гэдэг өөр хэрэг. Итгэгч болохын тулд ямар ч үнэ төлөх шаардлагагүй боловч золиос ба хагацлын замаар явж, Христийн төлөө зовлон эдэлдэг итгэгч байхын тулд их үнэ төлөх хэрэгтэй болно. Христэд амьдралын гарааг сайн эхлүүлэх нэг хэрэг боловч нартай сайхан, хүйтэн бүрхэг өдрүүдийн алинд ч, жаргах зовохын алинд ч, баярлаж гунихын алинд ч өдрөөс өдөрт Эзэний төлөө амьдарна гэдэг өөр хэрэг.

Итгэгч биднийг энэ дэлхий ёжлонгүй ширтэн харж байгаа. Христэд амьдрал нэг бол бүхнийг авч эсвэл юу ч үгүй хоцордог гэдгийг дэлхий ертөнц яагаад ч юм сайн мэддэг. Үнэнч итгэлтэй итгэгч хүнийг хараад тэр шоолж, тохуурхаж, элэглэж болох боловч дотроо Христэд өөрийгөө бүрэн зориулсан хүнийг гүнээ хүндлэх сэтгэлд автдаг. Харин хоёрын хооронд итгэгч хүнийг хараад жигших агаад “энэ хүн барилга барьж эхлүүлсэн боловч дуусгаж чадсангүй. Анх итгэгч болохдоо их л сүржин байсан. Харин одоо биднээс ялгарах юмгүй болжээ. Эхлээд их хурдтай давхиж байсан бол

одоо дугуй нь дөнгөн данган эргэж байна” хэмээн элэглэн тохуурхах ажээ.

Тийм ч учраас Эзэн Есүс “эхлээд зардлаа тооц” гэсэн аж.

Есүсийн ярьсан хоёр дахь дүрслэл өөр улсын эсрэг дайтах гэж байгаа хаантай холбоотой байв. Тэр хаан эхлээд өөрийнх нь арван мянган цэрэг хоёр дахин их хүчтэй дайсных нь цэргийн ангийг ялж чадах эсэхийг тооцож үзэх ёстой биш гэж үү? Эхлээд дайн зарлачхаад эсрэг талын цэргүүд өөд өөдөөсөө дайрч эхлэх үед цэрийнхээ хүчийг тооцвол мунхаг хэрэг болохсон. Ийм тохиолдолд цагаан туг өргөн, бууж өгөх гэрээ хийлгэхийн тулд баг цэрэг илгээж, шороон дээр дэмий л мөлхөн энх тайван тогтоохыг номхон даруухнаар гуйхаас өөр арга зам үлдэхгүй биз ээ.

Христэч амьдралыг дайнтай зүйрлэх нь огтхон ч хэтрүүлэг болохгүй. Христэч амьдралд дэлхий буюу махан бие ба муу ёрын сүнс гэсэн хүчирхэг дайснууд бий. Урам хугаралт, цус урсалт, зовлон шаналлууд бий. Үүр цайхыг хүлээн эвшээлгэж шөнийн урт удаан харуулд зогсох үе ч бий. Нулимс, хүнд хүчир хөдөлмөр, сорилт шалгуурууд ч бий. Мөн өдөр бүр үхлийг туулна.

Христийг дагахаар шийдсэн хүн бүр Гетсемани болон Голготын толгодыг санах ёстой. Дараа нь төлөх үнээ бас тооцох хэрэгтэй. Дагалдагч байна гэдэг нэг бол Христэд өөрийгөө бүрэн гүйцэд тэр чигээр нь үнэнчээр зориулах эсвэл гутамшиг доромжлолд бууж өгөх хэрэгтэй болно.

Эзэн Есүс энэхүү хоёр дүрслэлээрээ Түүнийг дагах шийдвэрийг сэтгэлийн хөдлөлөөр яаран гаргаж болохгүйг сонсогч нартаа анхааруулсан ажээ. Өөрийг нь дагах хүмүүс хавчилт, сорилт шалгуур, зовлон зүдгүүрийг амсах болно гэдгийг Тэр тэдэнд баттай хэлж чадах байв. Тиймээс эхлээд тэд ямар үнэ төлөхөө тооцох ёстой байлаа!

Ямар үнэ вэ? Энэ асуултад дараагийнх нь ишлэл ийн хариулжээ. *“Иймээс та нарын хэн нь ч байгаа бүхнээсээ эс татгалзваас Миний шавь байж чадахгүй”* (Лук 14:33).

Төлөх ёстой үнэ гэж “бүх зүйл” буюу хүнд байгаа бүхэн нь бас өөрөө бүхэлдээ аж. Аврагч өөрөө ийм л үнэ төлсөн бөгөөд Түүнийг дагах хүмүүс үүнээс бага байх аргагүй билээ. Бүх утгаараа хязгааргүй баян чинээлэг байсан Тэр өөрөө сайн дураараа ядуу хоосон болсон байхад Түүний дагалдагчид илүү бага үнээр Түүнийхтэй адил титмийг хүртэж болно гэж үү?

Ингээд Эзэн Есүс яриагаа дараах маягаар эцэслэн дүгнэжээ: *“Давс бол сайн юм. Харин давс нь амтгүй болбол юугаар давслаг болгох билээ?”* (Лук 14:34).

Библи бичигдэж байсан тэр үеийн хүмүүст өнөө үед бидний хоолны ширээн дээр байдаг шиг тийм цэвэр давс байдаггүй байсан бололтой. Тэд элс шороо зэрэг янз бүрийн зүйлтэй холилдсон давс хэрэглэдэг байжээ. Давс амтаа алдаж болох байсан агаад үлдсэн хэсэг нь амтгүй, юунд ч хэрэггүй зүйл болдог байсан ба үүнийг хөрсөнд бордоо болгон ашиглах ч боломжгүй байжээ. Тэр үед ийм давсыг заримдаа зам дээр асгадаг байв. *“Энэ нь гадагшаа хаягдаж, хүмүүсийн хөл доор гишгээгдэхээс өөр юунд ч хэрэг болдоггүй”* (Матай :5:13).

Энэ дүрслэлийн хэрэгжүүлэх санаа тодорхой аж. Христ итгэлт хүн ганц л зорилгын төлөө оршин байдаг. Энэ бол Бурханд бүрэн зориулагдсан

амьдралаар Түүнийг алдаршуулан амьдрах зорилго юм. Итгэгч хүмүүс газарт эд баялаг хураах, хувийн таашаал, ая тухтай байдлаар өөрийгөө зугаацуулах, энэ дэлхийд нэр алдар олохыг хичээх ашиг тусгүй зүйлд өөрийн амьдрал ба авьяас чадлыг үрэх гэх мэтээр амтаа алдаж болох талтай.

Өөрийн амьдралын оршин буй ганц зорилгыг алдсан итгэгч хүн бусад бүх зүйлийг алдах бөгөөд ямар ч ашиг тусгүй, өнгө үзэмжгүй зүйл болох болно. Хувь заяа нь амтаа алдсан давс мэт хүмүүсийн хөлд гишгэгдэж тэдний элэг доог болж жигшил зэвүүцлийг төрүүлэх болно.

Эцэст нь Есүс “Сонсох чихтэй нь сонсогтун” (Лук 14:35) гэжээ.

Эзэн Есүс хэлсэн үгийг нь хүн бүр хүлээн авахгүй гэдгийг мэддэг байсан тул хүмүүст хандан чанга хатуу үг хэлснийхээ дараа энэ үгийг их хэлдэг байжээ. Бүх хүн хэлсэн үгнийх нь гол санааг гуйвуулж өөрсдийнхөөрөө тайлбарлана гэдгийг Тэр мэдэж байв.

Гэвч хэлсэн үгийг нь дуулгавартай хүлээн авч дагах хөгшин залуу янз бүрийн хүмүүс байсаар байх болно гэдгийг бас мэдэж байсан тул тийнхүү хэлсэн ажээ. “Сонсох чихтэй нь сонсогтун” Түүнийг үгийг сонсох хүмүүс төлөх үнээ тооцох тэр хүмүүс бөгөөд тэд ийн хэлэх аж:

Эзэн Есүсийг би дагахаар шийдсэн

Өөр хэн ч надтай нийлэхгүй байсан ч би дагасаар л байх болно.

Өмнө минь загалмай ард минь дэлхий байна

Эргэж буцах зам надад үгүй.

Арван хоёрдугаар бүлэг

ТАРЧЛАЛ ЗОВЛОНГИЙН ХАР СҮҮДЭР

Есүс Христэд өөрийгөө бүрэн зориулсан хүнд амьд байх уу үхэх үү гэдэг тийм ч чухал биш болдог ажээ. Түүнд Эзэнийг алдаршуулах нь юу юунаас илүү чухал.

“Христ одоо ч урьдын адил амиар ч бай, үхлээр ч бай бие дотор минь өргөмжлөгдөх болно.” (Филиппой 1:20) Энэ үг “Жон Бетти хоёрын агуу ялалт” номд олонтаа давтагддаг.

Алдартай авралын зар тараагч Жим Елотын бичсэн номд бас үүнийг онцлон тэмдэглэсэн байдаг ба тэрээр Уитон Коллежийн оюутан байхдаа өдрийнхөө тэмдэглэлд “Би аукчуудын төлөө үхэхэд бэлэн байна” хэмээн бичиж байжээ. Тэрээр бас ийн бичсэн байдаг:

Эцэг минь хэрэв Та хүсэж байвал амь амьдралыг минь, цусыг минь Өөртөө авч ариун галаараа шатаагаач. Миний амь нас минийх биш учир би түүнийг Танаас харамлахгүй. Амь насыг минь ав Эзэн минь, бүгдийг нь ав. Амь амьдралыг минь дэлхийн төлөө өргөх өргөл болгон асга. Таны тахилын ширээн дээр урссан цус л үнэ цэнэтэй билээ.

Бурханы олон арван баатарлаг хүмүүсийн Бурхантай харьцах харьцаа чухам ийм байсан бөгөөд тэд: *“Хэрэв улаан буудайн үр газар унаад үхэхгүй бол тэр ганцаараа үлдэнэ. Харин хэрвээ тэр үхвэл олон үр бий болгоно”* (Иохан 12:24) гэдгийг ойлгодог байжээ. Тэд улаан буудайн ийм үр болоход бэлэн байсан.

Энэ бол Эзэн Есүс дагалдагч нартай заадаг байсан тэр чиг хандлага юм. *“Учир нь хэн амиа аврахыг хүснэ, тэр нь амиа алдах болно. Харин хэн Миний төлөө амиа алдана, тэр нь амиа аварна”* (Лук 9:24).

Энэ үгийг бид тунгаан бодох тусам утга санаа нь улам тодорхой болж ирдэг.

Нэгдүгээрт, амь амьдрал маань бидний өөрийнх биш харин Өөрийнхөө үнэт цусны үнээр үнэлсэн Түүнийх юм. Өөр хүнд хамаарагдах зүйлээс бид зуураад байж болно гэж үү? Ч.Т. Стадд 1883 онд Кембрежийн их сургуулиас доорх үгсийг бичихдээ уг асуултад хариулсан аж:

Хэдийгээр Есүс миний төлөө үхсэн гэдгийг би мэдэж байсан ч амь амьдрал маань минийх биш гэдгийг хэзээ ч ухаарч байгаагүй. Золин авалт буюу чөлөөлөлт гэдэг нь ямар нэгэн үнэ төлөн байж буцаан авах гэсэн утгатай. Тиймээс хэрэв би нэгэнт Түүнийх болсон бол нэг бол хүний юманд санаархсан хулгайч болох эсвэл байгаа бүхнээ Бурханд зориулах хоёр л зам үлдэнэ.

Хоёрдугаарт, Эзэн Есүс биднийг амьд байх хугацаанд эргэж ирдэггүй л юм бол бид ямар ч байсан үхэх л болно. Тэгэхээр Мөнхийн Хаанд үйлчилсээр үхэх эсвэл энгийн нэг тоон үзүүлэлт болон үхэхийн аль нь илүү эмгэнэлтэй вэ? Жим Елот нэгэнтээ “Дахиад хэзээ ч алдагдахгүй зүйлийг олж

авахын тулд өөртөө байлгаж болохгүй зүйлээ өгсөн хүн мунхаг хүн огт биш юм” хэмээн онож хэлсэн байдаг.

Гуравдугаарт, Эзэн Есүс бидний төлөө амиа өгсөн байхад Түүний төлөө амиа өгөх нь бидний хийж чадах хамгийн наад захын зүйл гэдэг нь ойлгомжтой. Нэгэнт зарц нь эзнээсээ агуу байдаггүй тул бид Эзэн Есүсээс илүү хялбар аргаар тэнгэрийн оронд очих ямар эрхтэй билээ? Ч.Т. Стаддыг “Хэрэв Есүс Христ Бурхан байгаад бидний төлөө үхсэн юм бол Түүний төлөө бид юугаа ч золиосолсон ихэднэ гэж үгүй” гэж хэлэхэд хүргэсэн зүйл бол чухамдаа энэ байсан юм.

Дөрөвдүгээрт, амь амьдралаа аль болох түргэн орхих аваас түүгээр дамжуулан ойр дотны маань олон хүн мөнх амьтай болж болохыг мэдсээр атал түүнээс зуурна гэдэг гэмт хэрэг юм. Хүмүүс өөрийн биеийг ихэвчлэн эмнэлгийн судалгаа шинжилгээний сонирхолд зориулан өргөх нь бий. Зарим хүн галд автсан байрнаас хүмүүсийн амийг аврахын тулд өөрийн амийг өгдөг. Бас зарим хүн эх орноо харийн дайснаас хамгаалах дайн тулаанд амь насаа алддаг. Тэгвэл хүмүүсийн амь бидний хувьд ямар үнэтэй вэ? Бид Ф. У. Маертай хамт дараах үгийг хэлж чадах уу?

Миний хувьд хүмүүс гэдэг
Ялалт байгуулж чадах байсан ялагчид
Хааны титмээс татгалзсан харц боолууд юм.
Тэд дэмий л элдвийн хоосон гайхамшигт найдаж
Эд зүйлд найдвараа тавьдаг.

Гэтэл хангинан цангинах бүрэн дуу адил
Гэнэт хамаг бие минь их хүсэлд автлаа
Өө, тэднийг аврахсан! Тэдний төлөө мөхөхсөн.
Тэдний амины төлөө үхэж, тэдний төлөө өргөл болохсон.

Хүн бүр тамлагдан алагдах албагүй. Дүүжлүүр, жад сэлэм, цаазын тавцан энэ бүхэн тоотой цөөхөн хүнд зориулагдсан байдаг. Гэвч итгэгч хүн бүр тамлагдагчийн сэтгэлтэй, тамлагдагчийн хичээл зүтгэлтэй, тамлагдагчийн үнэнч итгэлтэй байж чадах ёстой. Итгэгч хүн бүр Христийн төлөө амь амьдралаа хэдийнээ орхисон хүмүүс шиг амьдрах ёстой.

Эрүүл ч бай, өвчтэй ч бай
Солонго татсан ч, аянга буусан ч
Титэм болсон загалмай дээр дээр оч.
Би өөрийн бие болон сэтгэлийг
Бурханд анжислуулахаар хаяж өгнө. – Нэр нь үл мэдэгдэх зохиолч.

Арван гуравдугаар бүлэг

ДАГАЛДАГЧ БАЙХЫН ХАРИУ ШАГНАЛ

Эзэн Есүст зориулагдсан амьдралд өөрийн гэсэн хариу шагнал бий. Христийг дагахад баяр хөөр, сэтгэлийн таашаалыг эдэлж амьдралыг жинхэнэ утгаар нь амсах болно.

Аврагч Эзэн маань *“Амиа ологч нь түүнийгээ алдах болно. Миний төлөө амиа алдсан нь түүнийгээ олох болно.”* гэсэн үгийг олонтаа давтан хэлсэн байдаг. Түүний хэлсэн энэ үг Сайн мэдээний дөрвөн номд илүү олон дурьдагддаг ажээ. (Матай 10:39, 16:25, Марк 8:35, Лук 9:24, 17:33, Иохан 12:25-ийг тус бүр үзнэ үү). Энэ үг яагаад ингэж олон давтагдах болов? Яагаад гэвэл Христ итгэлт амьдралын хамгийн үндсэн зарчмуудын нэгийг гарган тавьсан аж. Тухайлбал, өөртөө хадгалахыг хичээн зууралдах амьдрал алдагддаг бол Түүний төлөө асгарсан, амьдрал олдож, аврагдаж, баяр жаргалаар дүүрч, өнө мөнхөд зориулан хадгалагддаггүй гэж үү?

Урам зориггүй, үлбэгэр итгэгч хүний амьдрал илүү их зовлонтой болдог бол Христэд өөрийгөө бүрэн зориулах үед Түүний сайн сайхныг амсдаг ажээ.

Жинхэнэ дагалдагч байна гэдэг Есүс Христийн боол байхыг хэлэх бөгөөд Түүнд үйлчлэх нь жинхэнэ эрх чөлөө болохыг олж мэдэх болно. *“Би эзэндээ хайртай. Би чөлөөлөгдөж явахгүй”* (Египетээс гарсан нь 21:5) гэж хэлж чадах хүн бүр үнэндээ эрх чөлөөтэй хүмүүс юм.

Дагалдагч хүн ялихгүй буюу түр зуурын зүйлстэй зууралдах ёсгүй. Харин өнө мөнхийн зүйлд санаа тавьж, Тэйлор Хадсоны адил цөөхөн зүйлтэй байхныг амсаж мэддэг байх ёстой.

Дагалдагч хүн олны танил биш байж болох ч хүмүүс түүнийг мэддэг. Хэдийгээр үхсэн мэт боловч байнга амьд, залхаан цээрлүүлэгдсэн боловч алагддаггүй. Гуниг зовлонд ч баяр хөөртэй байдаг. Хэдийгээр өөрөө ядуу ч өөр олон хүнийг баян болгодог, өөрийн гэх юу ч үгүй ч бүхнийг эзэмшдэг ийм л хүмүүс. (2 Коринт 6:9-10).

Жинхэнэ дагалдагч хүний амьдралыг дэлхий дээрх хамгийн сүнслэг амьдрал хэмээн баттай хэлж болох бол өнө мөнхөд түүний амьдрал хамгийн их шагнал хүртэх болно гэдгийг бас үүнтэй адилаар баттай хэлж болно. *“Учир нь Хүний Хүү тэнгэр элч нарын хамт Эцэгийнхээ алдрын дотор ирж, хүн бүрд үйлсийнх нь дагуу хариуг өгнө”* (Матай 16:27).

Тиймээс энэ насанд хийгээд өнө мөнхөд жинхэнэ ёсоор ерөөгдсөн хүн гэдэг “Эзэн Есүс минь би өөрийн гарыг амьдралаасаа холдуулан зайлуулъя. Таныг зүрх сэтгэлийнхээ хаан суудалд залъя. Өөрийнхөө хүслээр намайг өөрчилж, ариусган цэвэршүүлээч” (Билл Борден) хэмээн хэлж чаддаг хүн юм.

Тэр үүнийг хүсээгүй

Суу алдрын титмийг өмссөн Есүс

Сөнөн мөхөж буй хөөрхий дэлхийг хараад

Гуниг зовлонг маань өрөвдөж

Өөрийн амийг бидний төлөө өргөсөн. Гайхамшигт хайр!

Мөхөж байна, мөхөж байна! мөхлийн зам дээрх олон хүн
Хөөрхий зүрх сэтгэл нь даахын аргагүй хүнд ачаанд дарагджээ.
Гэвч тэднийг зөвхөн Есүс аварч чадна, харин очиж хэлэх хүн алга
Тэднийг гэм нүгэл, гуниг зовлонгоос нь өргөн авах хүн алга.

“Есүс тэднийг мөхүүлэхийг хүсээгүй”
Хүн бидний гуниг, шаналал зовлонгоор хувцасласан Есүс
Гашуудан гунигсдыг тайтгаруулахаар
Гуниг зовлон, ичгүүрт шаналсан зүрхийг эдгээхээр ирсэн.
Мөхөж байна, мөхөж байна! ургац алдаж байна.
Ургац хураагч ч цөөхөн, урт шөнө ч айсуй.
Есүс чамайг дуудаж байна. ургац хураалтад яаран гар.
Эрдэнэт хүний амь – энэ бол чиний ажлын талбай.

Өөрийн таашаал, энэ дэлхийн зовлон жаргалд
Дэндүү их харин Есүсийн төлөө маш бага цаг заржээ.
Өлссөнийг хооллож, алдагдсаныг олж
Өнө мөнхийн баяр жаргалыг тэдэнд амсуулах
Есүсийн ажилд зарцуулах цаг огт үгүй аж.
Мөхөж байна, мөхөж байна! Сонсогтун, тэд биднийг дуудаж байна.
Аврагчаа бидэн дээр авчраач, Түүнийг бидэнд мэдүүлээч.
Эцэж байна бид, хүнд ачаанд дарагдаж байна.
Эцэс төгсгөлгүй уйлсаар нүд маань булингартжээ.

“Есүс хэнийг ч мөхүүлэхийг хүсээгүй”
Есүсийн дагалдагч байтлаа миний бие
Ердийн хүмүүс үй олноороо там руу явахыг харсаар байж
Үл туслан сэтгэл амар амьдарч чадна гэж үү?
Мөхөж байна мөхөж байна! Үүнийг Та хүсээгүй.
Эзэн минь уучил намайг, урам зориг хайрла
Энэ дэлхийг хайрлах хайрыг минь үгүй хийж
Өнө мөнхийн үнэ цэнийг харж амьдрахад минь туслаач.

Арван дөрөвдүгээр бүлэг

ТАНЫ ЭД БАЯЛАГ ХААНА БАЙДАГ ВЭ?

“Газар дээр өөрсдөдөө эд баялаг бүү хураа. Тэнд хивэн хорхой болоод зэв идэж сүйтгэдэг, хулгайч эвдэж ороод хулгайлан авдаг аж. Харин тэнгэрт эд баялгийг өөрсөддөө хураа. Учир нь тэнд хивэн хорхой болоод зэв идэж сүйтгэдэггүй, хулгайч ч эвдэж ордоггүй, хулгайлдаггүй. Та нарын эд баялаг хаана байна, зүрх сэтгэл чинь бас тэнд байх болно” (Матай 6:19-21).

Хүний эд баялаг хаана байна тэнд зүрх сэтгэл нь байдаг. Эд баялаг нэг бол аюулгүй газар эсвэл тэнгэрт байх агаад нэгэн зэрэг аль алинд нь байх аргагүй. “Итгэгч хүн эд баялагаа орхин явдаг ч эд баялаг дээрээ очдог” гэж нэг хүн хэлсэн байдаг.

Эзэн Есүс дагалдагч нартаа газар дээр эд баялаг хураахыг хориглож байсан. Дагалдагч нарынх нь зүрх сэтгэл тэнгэрт байхыг хүссэж аж.

Христийн энэ сургаал өнөөгийн бидэнд дэндүү туйлширсэн, эрс сургаал мэт санагддаг. Тэр үнэхээр тэгж хэлэх гэсэн гэж үү? Нас өндөр болсон хойноо хэрэглэх зүйлийг хурааж цуглуулах ёстой гэж хүн бүр боддоггүй гэж үү? Биднийг хашир болгоомжтой байж хүнд бэрх өдрүүдэд хэрэглэх нөөцтэй байхыг, нэг нэгэндээ санаа тавихыг Есүс хүсдэггүй гэж үү? Энэ бол их чухал асуултууд. Өөрийгөө Христийн дагалдагч гэж үздэг хүн бүр эдгээр асуултад чин сэтгэлээсээ шударгаар хандах ёстой.

Хариултууды нь хаанаас олох вэ? Итгэгч хүний амьдрал дахь эд баялагийн талаар Библид юу заадаг вэ? Ирээдүйдээ бэлтгэх буруу юу? Итгэгч хүний амьдралын хэм хэмжээ ямар байх ёстой вэ?

Арван тавдугаар бүлэг

АЖИЛ ХЭРЭГТ ХИЧЭЭНГҮЙ БАЙ

Юуны өмнө, мөнгө олохын төлөө хөдөлмөрлөхийг Библид хориогүй гэдгийг бид бүгд мэднэ. Элч Паул өөрийн ахуй амьдралд хэрэглэх мөнгө олохын тулд майхан хийдэг байсан (Үйлс 18:1-3, 2 Тессалоник 3:8). Тэрээр ажиллах хүсэлгүй хүнийг бүү хоолло гэж Тессалоникийн итгэгч нарт заадаг байсан (2 Тессалоник 3:10). Тэгэхээр аливаа хүн өөрийн болон ар гэрийнхээ хэрэгцээг хангахын тулд хичээнгүй хөдөлмөрлөх ёстойг Библи эргэлзээгүй онцлон тэмдэглэдэг аж.

Тэгвэл итгэгч хүн ямар ч аргаар аль болох их мөнгө олохыг хичээх ёстой юу? Үгүй ээ, Ингэж хэлэх нь зохисгүй юм. Итгэгч хүн аль болох их мөнгө олохыг хичээх ёстой боловч дараах зүйлсээр хязгаарлагдах ёстой. Үүнд:

Итгэгч хүний эрхэлж буй ажил Эзэний зүйлээс дээгүүрт тавигдах ёсгүй. Юуны түрүүнд Бурхан болон Түүний зөвт байдлыг эрэлхийлэх үүрэгтэй (Матай 6:33). Ажлын ачааллаас болж Бурханд өргөх магтаал хүндэтгэл ба үйлчлэлийг орхигдуулж болохгүй.

Итгэгч хүн гэр бүлийнхээ өмнө хүлээсэн үүргээ орхигдуулах ёсгүй (1 Тимот 5:8). Энгийн хүмүүсийн тухайд нөхөр нь их мөнгө олох тусам эхнэр хүүхдүүддээ зарах цаг нь багасдаг. Тиймээс гэр бүлийнхээ хүмүүстэй хамт байх цагийг баян тасаг амьдралаар нөхөн орлуулж болохгүй. Ингэх нь тэднийг сүнсний болон ёс суртахууны ялзралд оруулах болно. Итгэгч хүний эхнэр хүүхдэд бурханлаг эр нөхөр ба эцгийн ойр дотно харьцаа, заавар зөвлөгөө банкны зузаан дэвтрээс илүү их хэрэгтэй.

Итгэгч хүн нэр хүндтэй ажил хөдөлмөрөөс мөнгө олдог байх ёстой (Сургаалт үгс 10:16). Энэ бол эргэлзээгүй зүйл. Итгэгч хүн эрүүл мэндэд хортой эсвэл ёс суртахууны хэм хэмжээг бууруулах аливаа зүйлд хөрөнгө оруулах буюу үйлдвэрлэх, түгээх, сурталчлах зэрэгт оролцож болохгүй. Мөн түүнчлэн аврал аваагүй байгаа хүмүүсийг зугаацуулах ажилд амьдралаа үрэх ёсгүй. Итгэгч хүний эрхлэх ажил бүтээлч бөгөөд олон түмэнд тустай байх ёстой.

Үүнээс гадна итгэгч хүн шударга арга замаар мөнгө олох ёстой (Сургаалт үгс 20:17). Эрхэлж байгаа ажил хөдөлмөр нь нэр хүндтэй боловч ажиллах арга зам нь шударга бус байж болох талтай. Жишээ нь:

- Орлогын албан татвар дээр хуурч мэхлэх (Сургаалт үгс 12:22)
- Жин хэмжүүр дээр булхай гаргах (Сургаалт үгс 11:1)
- Дүүргийн албан хаагчдад хээл хахуул өгөх (Сургаалт үгс 12:23)
- Онц ялгаагүй бүтээгдэхүүнийг ялгаатай мэтээр сурталчлах (Сургаалт үгс 20:6)
- Орлого зарлагын албан бичгийг буруугаар үйлдэх (Сургаалт үгс 13:5)
- Зах зээлийн газар буюу үнэт цаасны зах дээр наймаалцах буюу мөрий тавих (Сургаалт үгс 13:11)

- Ажилчдадаа хийсэн ажилд нь үл тохирох цалин хөлс өгөх (Сургаалт үгс 22:16)

Иаков “Харагтун, тариаланг чинь хураасан ажилчдын хөлс, та нарын саатуулаад байгаа тэр хөлс та нарын эсрэг хашхирч байна. Ургацыг чинь хураасан хүмүүсийн хашхираан Түмэн цэргийн Эзэний сонорт хүрчээ” хэмээн дуу алдсан нь сүүлчийн энэ заалттай холбоотой байв.

Итгэгч хүн мөнгө олохдоо өөрийн эрүүл мэндэд аюул учруулахгүйгээр хөдөлмөрлөх ёстой. Итгэгч хүний бие бол Ариун Сүнсний орших газар юм (1 Коринт 6:19). Эд баялгийг олж авахын тулд өөрийн эрүүл мэндийг сүйтгэх ёсгүй.

Эцэст нь хэлэхэд, итгэгч хүн эдэнд шунахгүйгээр мөнгө олдог байх ёстой. Хэзээ ч материаллаг эд баялгийн боол болж болохгүй (Матай 6:24). Амьжиргаандаа хэрэглэх мөнгө олох нь зөв боловч мөнгөнд дурлаж болохгүй (Сургаалт үгс 62:10).

Тэгэхээр, эцэст нь дүгнэж хэлэхэд итгэгч хүн Бурханыг эн тэргүүнд тавьж, гэр бүлийнхээ өмнө хүлээсэн үүргээ биелүүлж, бүтээлчээр хөдөлмөрлөж, шударгаар наймаалцаж, эрүүл мэндээ хамгаалж, шуналаас хол байж чадвал мөнгийг хичнээн ч хэмжээгээр олж болох ажээ.

Арван зургаадугаар бүлэг

ОЛЖ БОЛНО ХАРИН БҮҮ ЗУУР

Дараагийн асуулт “Мөнгө хадгалах нь буруу юу?”. Шинэ Гэрээнд өгүүлснээр бол буруу ажээ.

Баян чинээлэг хүнийг Библи буруутгадаггүй. Хүн эд хөрөнгө өвөлж аваад ганц шөнийн дотор баян болж болно. Гэвч эд баялгаа яах тал дээр хэлэх зүйл их бий.

Энэ талаар Библид юу гэж заадгийг үзэцгээе:

Юуны өмнө итгэгч бид бол Бурханы нярав юм (1 Коринт 4:1-2). Энэ бол бидэнд байгаа бүхэн биднийх биш харин Бурханых гэсэн үг. Түүний мөнгийг Түүнийг алдаршуулах замаар ашиглах нь бидний үүрэг. Олсон орлогынхоо 90 хувийг өөртөө ашиглаад үлдсэн 10 хувийг нь Эзэнд өгнө гэдэг Шинэ Гэрээний нярвын тухай буруу ойлголт юм. Бидэнд байгаа бүхэн бүгд Түүнийх.

Хоёрдугаарт, бид идэх хоол өмсөх хувцсандаа сэтгэл хангалуун байх ёстой. “Хэрэв бидэнд хоол хүнс, хувцас хунар байвал эдгээрээр бид сэтгэл хангалуун байх болно” (1 Тимот 6:8). Энд хэрэглэгдсэн хувцас гэдэг үг бүтээх буюу дээвэрлэх гэсэн утгатай бөгөөд аливаа төрлийн орогнох газар, хорогдох байртай холбоотой ажээ. Тиймээс уг ишлэл итгэгч биднийг идэх хоол, өмсөх хувцас, амьдрах орон гэр зэрэг амьдралын наад захын хэрэгцээндээ сэтгэл хангалуун байх ёстой гэж байгаа аж. Эзэн Есүс биднийг орон байртай байх ёстой гэсэн нь газар дээр байхдаа Өөрийнхөө хэрэглэж байснаас илүү их зүйл хэрэглэхийг бидэнд зөвшөөрчээ. Түүнд унтах газар гэж байгаагүй (Матай 8:20)

Бизнес эрхэлдэг итгэгч хүнд үл хөдлөх болон ажил хэргээ явуулах хөрөнгө гэж заавал байх ёстой нь мэдээж. Түүхий эд худалдан авах, ажилчдынхаа цалинг тавих, өдрөөс өдөрт гарч ирэх санхүүгийн элдэв төлбөр зэргийг төлөх зэрэгт мөнгө хэрэгтэй болдог. Тиймээс Библи нь ажил хэргээ явуулах мөнгө санхүүтэй байхыг итгэгч хүмүүст хорьдоггүй.

Гуравдугаарт бид элдэв дэмий зүйлд мөнгө үрэлгүй аль болох хэмнэж амьдрах ёстой. Есүс таван мянган хүнийг хооллосныхоо дараа үлдсэн хоол хүнсийг цуглуулж ав хэмээн дагалдагчдадаа хэлж байсан (Иохан 6:12). Түүний энэ жишээ бидэнд боломжтой болгоныг хадгалж нөөцлөх хэрэгтэйг сургаж байна.

Бид хэрэгтэй хэрэггүй зүйл маш их худалдаж авдаг. Ялангуяа цагаан сараар хүмүүсийн гар дээр тавих зүйлсийг маш ихээр худалдан авдаг ба тэдгээр нь эцэстээ энд ч хэрэггүй зүйл болон хаягддаг.

Заримдаа бид арай хямд үнэтэй боловч чанарын хувьд ялгаагүй зүйл худалдан авахын оронд хамгийн үнэтэйг нь худалдан авах нь бий. (Хямд зүйл худалдан авах нь дээр гэдэг ч худлаа. Бид үнэ, чанар, зарцуулах цаг хугацаа зэргийг сайн тооцох ёстой).

Бид хүссэн болгоноо худалдан авах хүслээ дарж чаддаг байх ёстой. Хүний Хүү Есүсийн тусын тулд арвилан хэмнэх замаар амьдрах зуршилтай болох ёстой.

Бид хэрэгцээнээсээ илүү гарсан бүхнээ Эзэний үйлсэд хандивлах ёстой. (1 Тимот 6:8). Бидэнд байгаа бүхэн Түүнийх гэдгийг бүү март! Бид бол Түүний зарц нар юм. Бидний бизнес газар дээрх Түүний үйл хэргийг өргөжүүлэхэд хэрэглэгдэх ёстой бөгөөд бид үүний төлөө чадах бүхнээ хийх ёстой.

Идэх хоол, өмсөх хувцас, амьдрах орон байрнаас илүү гарсан бүхнээ Эзэний үйлсэд зориулан хандивлана гэдэг муйхар, бодлогогүй, алсын хараагүй хэрэг гэсэн эсэргүүцэл даруй гарч ирэх байх.

Яг ийм зүйл хийсэн нэг хүний түүх бидэнд бий. Тэр бол нэгэн ядуу бэлэвсэн эмэгтэй бөгөөд тэрээр өөрт байсан хоёр зоосоо хандивын хайрцагт хийсэн байдаг. Гэвч Есүс түүнийг зэмлээгүй бөгөөд *“Би та нарт үнэнээр хэлье. Энэ ядуу бэлэвсэн эмэгтэй бүхнээс илүүг өглөө. ⁴Учир нь тэд бүгд илүүдлээсээ өргөлд хийсэн атал харин энэ эмэгтэй ядуу хэрнээ амин зуулгандаа хэрэгтэй байсан бүхнээ өглөө”* (Лук 21:3-4) гэжээ.

Итгэгч биднийг газар дээр эд баялаг хураахыг хориглосон билээ. Энэ тухай өгүүлсэн Библийн хэсэг тод ойлгомжтой бөгөөд ямар ч алдаа мадаггүй юм.

“Газар дээр өөрсдөдөө эд баялаг бүү хураа. Тэнд хивэн хорхой болоод зэв идэж сүйтгэдэг, хулгайч эвдэж ороод хулгайлан авдаг аж. Харин тэнгэрт эд баялгийг өөрсдөдөө хураа. Учир нь тэнд хивэн хорхой болоод зэв идэж сүйтгэдэггүй, хулгайч ч эвдэж ордоггүй, хулгайлдаггүй. Та нарын эд баялаг хаана байна, зүрх сэтгэл чинь бас тэнд байх болно” (Матай 6:19-21).

Ихэнх итгэгч хүн дээрх ишлэлийг Библид байдаггүй мэтээр амьдардаг. Энэ үгийг Есүс хэлсэн, тэнгэрлэг үг гэдэгт бид итгэдэг боловч өөрсдөд маань хамаатай гэж огт боддоггүй учраас даган биелүүлдэггүй. Тиймээс ч эдгээр үгсийг Эзэн Есүс огт хэлээгүй мэт байх аж.

Гэвч газар дээр эд баялаг хураах нь гэм нүгэл мөн гэдэг нь үнэн хэвээр байх болно. Ингэх нь Бурханы Үгтэй зөрчилдөх болно. Бидний хаширлал, алсын хараа гэж нэрлэдэг тэр зүйл бол үнэндээ ёс бус, эсэргүүн зүйл юм. Эд баялаг байгаа газар зүрх сэтгэл байдаг нь үнэн.

АНУ-ын дэд ерөнхийлөгч байсан доктор Жонсон нэг удаа нэгэн тансаг эдлэнд зочилжээ. Том орд харш, сайн засаж янзалсан зүлэг ногоон дээгүүр хэсэг явсны дараа тэрээр “Хүнийг үхэж чадахгүй болгодог зүйлс чинь л энэ шүү дээ” гэсэн гэдэг.

Эцэст нь, бид ирээдүйгээ Бурханд даатгаж чаддаг байх ёстой. Бурхан хүмүүсийг Өөрт нь итгэх итгэлээр, Өөрөөс нь хамааралтайгаар амьдрахыг хүсдэг. Бидэнд *“Өдөр тутмын минь талхыг энэ өдөр бидэнд өгөөч”* (Матай 6:11) гэж залбирахыг зааж өгсөн. Тэрээр маннагийн түүхийг ярихдаа өдөр бүр өөрийн хэрэгцээг Эзэнээс авч байх тухай заасан (Египетээс гарсан нь 16:14-22). Есүс Өөрөө бидний аюулгүй байдал бөгөөд бид энэ дэлхийн эвдэрхий зүйлсэд найдах ёсгүй.

Итгэгч бид Бурханы нярвууд бөгөөд бидэнд байгаа бүхэн Түүнийх, бид амьдралд зайлшгүй шаардагдах зүйлсээр сэтгэлээ хангаж, чадах хэмжээгээрээ арвилан хэмнэж, хэрэгцээнээс илүү гарсан бүхнээ Эзэний ажил үйлсэд зориулан өгч, газар дээр эд баялаг хураахгүй байж ирээдүйгээ

Эзэнд даатгаж сурахыг Мөнх Эзэн Өөрийн хүмүүсээс хүсдэг ажээ.

Арван долдугаар бүлэг

ЮУ НЬ БУРУУ ВЭ?

Итгэгч хүн эд баялаг хураахын буруу нь юу вэ?

Нэгдүгээрт, Библид болохгүй гэж хэлсэн (Матай 6:19). Энэ л бидэнд хангалттай. Адам Ева хоёр сайн мууг мэдүүлэх модны жимсийг яагаад идэж болохгүй байсан бэ? Яагаад гэвэл Бурхан тэдэнд бүү ид гэж хэлсэн. Тиймээс энэ асуудал дээр Бурхан бидэнд хэдийнээ хариулсан ажээ.

Эд баялаг хураах нь дэлхийн сүнслэг хэрэгцээг үл анзаарах байдалд хүргэдэг учир бас буруу юм (Сургаалт үгс 24:1-12). Бурханы нигүүслийн тухай сайн мэдээг сонсоогүй хүн олон сая бий. Библи эсвэл сайн мэдээний тухай сайн ном товхимол байхгүй хүмүүс ч олон сая байгаа. Бурхангүйгээр, Христгүйгээр, итгэл найдваргүйгээр нас барж байгаа хүн ч олон сая аж.

Сайн мэдээг тараах хэрэгсэл нь байсаар атал түүнийг хэрэглэхгүй байна гэдэг сүнсний хувьд төрсөн ах дүүгээ хөнөөж буй хэрэг (Езекиел 33:6).

Эд баялаг хураах нь түүнийг хурааж буй хүний зүрх сэтгэлд Бурханы хайр байхгүй байгааг илтгэдэг. *“Дэлхийн эд хөрөнгөтэй хэн нэгэн нь өөрийн ах дүүгийн хэрэгцээ, гачигдлыг хараад түүнд туслах сэтгэл үл гаргавал, түүний дотор Бурханы хайр хэрхэн байх билээ?”* (1 Иохан 3:17).

Хуучин Гэрээний уяман өвчтэй хоёр өлсгөлөн хүн их хэмжээний хүнс олоод эхний ээлжид өөрсдийгөө цатгаад дараа нь олзоо бусадтайгаа хуваахаар явсан байдаг (Хаад 2 7:8-10). Бурханы агуу нигүүслийг хүртсэн итгэгч хүмүүс Бурханы хууль дор амьдардаг байсан уяман өвчтэй тэр хүмүүсээс илүү энэрэнгүй байх ёстой биш гэж үү?

Гуравдугаарт, хэрэв бид мөнгийг их хэмжээгээр хуримтлуулбал өлөн зэлмэн амьдралтай дэлхийн олон сая хүний өмнө дээд зэргийн хувиа бодсон, энэрэх сэтгэлгүй хүмүүс болно (Сургаалт үгс 3:27-28, 11:26) Лук номын 16-р бүлэгт гардаг чинээлэг хүн хаалгыг нь сахин амьдардаг ядуу гуйлгачин эрийг огт анзаардаггүй байсан. Хэрэв тэр эр цонх руугаа очоод хөшгөө ярж гадагш харсан бол мөнгөнийхөө зарим хэсгээр тусалж болох жинхэнэ гачигдал гэж юу байдгийг харах байсан. Гэвч түүнд энэ хамаагүй байв.

Энэ дэлхий Лазар шиг хүнээр дүүрэн юм. Тэд бидний хаалгыг сахин амьдардаг. Есүс бидэнд *“Чи хөршөө өөрийн адил хайрла”* (Матай 22:39) гэсэн. Хэрэв бид одоо Түүний хэлэхийг сонсохоос татгалзвал хожим Түүний ийн хэлэхийг сонсох болж болно:

“...та нар Намайг өлсөж байхад идэх юм өгөөгүй, цангаж байхад минь уух юм өгөөгүй.... Үнэнээр Би та нарт хэлье. Та нар эдгээр хамгийн дордод нь ийнхүү үйлдээгүй бол Надад ч хийгээгүй хэрэг” (Матай 25:42,45)

Газар дээр эд баялаг хуримтлуулах тохиолдолд энэ нь Бурханы дайснуудад Түүний нэрийг гутаан доромжлох шалтаг болдог учир буруу юм (Ром 2:24). Гүн ухаантан Вольтерийг “Мөнгө бүх хүнийг нэг шашинтай болгодог” хэмээн хэлэхэд хүргэсэн зүйл энэ юм.

Авралыг аваагүй хүмүүсийн дунд Есүсийн сургаалыг мэддэг хүн олон

бий. Есүс бидэнд хөршөө хайрла хэмээн сургадгийг тэд мэднэ. Есүсийн дагалдагч гэж өөрсдийгөө нэрлэх атал нүсэр том байшин, ганган машин, тансаг хоол хүнс, үнэтэй хувцас эдэлж хэрэглэдэг хүмүүсийн хэлэх үг хийх үйлдэл хоёр хоорондоо зөрчилдөж байгааг тэд харж мэддэг.

Христийн чуулган нойрноосоо сэрэх цаг болсон! Дэлхий дээрх мэдлэг боловсролтой залуустай ярилц. Христитгэлийг шүүмжлэх тэдний шүүмжлэлийг сонс! Тэд Есүсийн ёс зүйг эсэргүүцэхгүй. Харин ядууралд автагдсан дэлхий ертөнцөд баян тансаг амьдарч байгаа итгэгч хүмүүсийг, чинээлэг сүм чуулгануудыг хүчтэй эсэргүүцдэг.

Гэвч бид зөвхөн итгэгч биш хүмүүст нөлөөлөх тал дээр биш бас залуу итгэгч нарт хэрхэн нөлөөлөх тал дээр санаа тавих ёстой. Тэд ахмад хүмүүс ямар үлгэр дуурайл үзүүлэхийг ажиглан харж байдаг. Тэдэнд бидний хэлэх үгнээс илүү амьдралын хэв маяг чухал. Бид амьдралд чухам юуг үнэлж, юуг эрхэмлэн баримталдгийг ням гаргийн чуулган дээрх бидний урам зоригтой сайхан үгнээс биш харин ажлын өдрүүдийн энгийн амьдралаас маань илүү харагддаг.

Итгэгч бид Христийг чин үнэнээр дагаж байгаа эсэхийг залуу үеийнхэн үнэлэхдээ бидний орон байрны үнэ өртгийн хэмжээгээр үнэлдэг. Бурханы ажил үйлсэд шаардагдах хөрөнгө мөнгийг өөрсдөө элбэг гаргаж чадах атал үүнд зориулан мөнгө хандивлахыг уран гоё үгээр уриалан дууддаг хүмүүс тэдэнд сайхан санагдах нь үгүй.

Хэрэв бид амьдралаа эд хөрөнгө хуримтлуулахад зориулдаг бол залуу үеийнхэн энэ жишээг дагахад гайхах зүйлгүй. Бид Эзэн Есүсийн сануулж хэлсэн үгийг мартаж өгсөү:

“Бүдрэх чулуунууд ирэх нь зайлшгүй ч, харин бүдрүүлэгч нэгэн золгүй еэ! Түүний хувьд балчир эднээс нэгийг нь бүдрүүлснээс тээрмийн чулуу хүзүүнээсээ дүүжлээд тэнгист хаягдсан нь дээр байхсан” (Лук 17:1-2).

Эд баялаг хуримтлуулах нь Бурханыг луйвардаж байгаатай адил тул бас гэмт зүйл мөн ажээ (Малахи 3:8). Бидэнд байгаа бүхэн бүгд Бурханых гэдгийг бид хэдийнээ үзсэн. Хэрэв бид энэ бүхнийг Бурханы төлөө үл ашиглах аваас эцэст нь Бурхан түүнийг үүнд ашиглаж чадах өөр хүмүүст өгөх болно. Бид өөрт байгаа бүхнээ хичнээн алчуурт боон хав дарсан ч нэмэргүй (Лук 19:20-26).

Мөнгө санхүү дээр сайн нярав байх тухай Эзэний тушаалыг сахиж үл чадах аваас бидний сүнсний гэрэл бөхөж бүдгэрэх болно (Матай 6:22-23). Бид бас үүнтэй холбоотой Библийн хамгийн энгийн ойлгомжтой ишлэлийг ч олж харахаа больж эхэлнэ.

Бидний төрөлх муу мөн чанар аливааг мушгин гуйвуулах зантай нь үнэн билээ.

????? хуудас 114

Үүнтэй холбоотойгоор Харрингстон Лиис нэгэнтээ ийн бичиж байжээ. “Соёлжсон хүний хамгийн эмзэг эрхтэн бол түүний түрийвч бөгөөд сонсогчдынхоо халаасыг тэмтэрсэн номлол заасан номлогч хамгийн ширүүн

эсэргүүцэлтэй тулгардаг”

Сион уулан дээр амар тайван, тарган цатгалан амьдарч байгаа хүмүүст өөрөөсөө татгалзах тухай Библийн ишлэлүүд тун бага ач холбогдолтой мэт санагдах биз ээ. Түүнээс гадна бид өөрсдөө дагаж мөрддөггүй Библийн ишлэлийг өрөөл бусдад үр нөлөөтэйгөөр зааж чадахгүй нь мэдээж. Тиймээс мөнгө санхүүтэй холбоотой асуудал дээр болон амьдралын өөр бусад бүх тал дээр Библийг дагахгүй байх нь Библийг эрэмдэглэх аюулыг дагуулдаг (Матай 13:14-15).

Эд баялаг хураах нь итгэлээр амьдрах байдлыг бараг боломжгүй болгодог. Яагаад? Яагаад гэвэл эд баялагтай мөртлөө түүндээ найдахгүй байх аргагүй байдаг. Мөнгө ихтэй хүн түүнээсээ хичнээн их хамааралтай байдгаа мэддэггүй. “*Баян хүний эд хөрөнгөө нь түүнд бэхлэлт бүхий хот ба Өөрийнх нь төсөөлдгөөр өндөр хана мэт ажээ*” (Сургаалт үгс 18:11).

Ийм хүн мөнгөнөөс бүрэн хамааралтай амьдрах ба өөрт тохиолдох бүх асуудлыг мөнгөөр шийдэх гэж хичээдэг. Мөнгө түүний одоогийн амьдралын сайн сайхан, ирээдүйн аюулгүй байдлуудыг хангана гэж үздэг. Хэрэв гэнэт бүх мөнгөө алдвал түүний түшиг тулгуур алга болж тэрээр хүнд цохилтод орох ажээ.

Мөнгөтэй хүн нүдэнд үл харагдах Бурханд итгэж найдахын оронд нүдэнд үзэгдэх хадгаламжийн дэвтэрт илүү итгэдэг нь үнэн. Өөр юунд ч биш ганцхан Бурханд итгэж найдна гэдэг түүний хувьд хүнд цохилт юм.

Бид хувь заяагаа Бурханы гарт даатган орхих үедээ аюулгүй байдлыг төдийлөн сайн мэдрэх нь үгүй. Үүний эсрэгээр хувь заяа маань бидний гарт байдаг мэт аашилж багахан хэмжээний тав тухтай, аюулгүй байдлуудыг бий болгосноор санамсаргүй тохиолдлууд болон аливаа өөрчлөлтүүдээс өөрсдийгөө хамгаална гэж боддог. Энэ бол хүн болгонд байдаг нийтлэг мэдрэмж. “Хүн бүр Эцэг Бурханы хайр халамжид үл итгэх байдал руу амархан гулсан орох аюултай байдаг” (Самуел Кукс).

Бурхан итгэгч бидний амьдралыг өөрөөс нь бүрэн хамааралтай байхыг хүсдэг. Гэвч бид газар дээр эд баялаг хураах замаар Түүний энэ хүслийг уландаа гишгэдэг аж.

Бурханы таалалд бүрэн нийцэх амьдрал бол итгэлийн амьдрал юм. Итгэлгүйгээр Түүнд таалагдах боломжгүй (Еврей 11:6).

Итгэлийн амьдрал бол аюулгүй байдлыг хангах цорын ганц амьдрал. “.....амлалт нь итгэлээр ирдэг” (Ром 4:16). Учир нь Бурханы амлалтаас илүү баттай зүйл гэж үгүй. Тиймээс Түүний амлалтад итгэх итгэлийн амьдрал бол сэтгэл амар тайван амьдрал юм.

Бухимдах, сэтгэл санааны тогтворгүй байдалд орох зэрэг нь Бурханд итгэх итгэлийн амьдралаас биш харин материаллаг эд зүйлээс болж үүсдэг.

Итгэлийн амьдрал бол Бурханыг алдаршуулах цорын ганц амьдрал юм. Итгэлээр биш харин харагдаж байгаа зүйлд итгэж амьдрах үед бид хүний оюун ухааныг илүү алдаршуулах ажээ.

Итгэлийн амьдрал итгэгч болон итгэгч биш хүмүүст тод харагддаг. Энэ нь залбиралд хариулдаг Бурхан тэнгэрт оршин байдаг гэдгийг гэрчилдэг. Итгэл бол харагдаж байгаа зүйлийн эсрэг тал юм. Нүдэнд харагдаж байгаа зүйлд итгэх нь итгэл биш бөгөөд харин нүдэнд үл харагдах зүйлд итгэнэ

гэдэг жинхэнэ итгэл юм. Тиймээс эд баялаг хурааж буй хүн итгэлээр амьдарч чадахгүй.

Итгэгч болсон хүн тэр даруй итгэлийн амьдралаар амьдарч чадахгүй. Итгэлээр амьдрахын тулд их хүчин зүтгэл гаргах шаардлагатай болдог. Ялангуяа чинээлэг амьдралтай хүмүүсийн хувьд бүр ч хэцүү. Итгэгч хүн Бурханд итгэж найдахаас өөр арга замгүй болох тийм байдалд өөрийгөө аваачих ёстой. Үүний тулд өөрт байгаа бүхнээ зарж ядууст тараан өгөх ёстой болно. Өөрт байгаа бүхнээсээ, өөр бусад бүх тусламж дэмжлэгээс салсан цагт итгэгч хүн зөвхөн Бурханд итгэж найдах итгэлийн амьдралаар амьдарч чадна.

Эзэн Есүсээс татгалзсаар байгаа, Түүний дагалдагчдыг хавчин гадуурхдаг дэлхий ертөнцөд хаад ноёд мэт амьдрах нь Эзэнийг үл хүндэтгэсэн хэрэг болно. Элч Паул Коринт хотын итгэгчдийг ганган хээнцэр өмсгөл өмсөж, толгойдоо титэм зүүн наадмын талбайн хамгийн үнэтэй суудалд заларсан хүмүүс мэт дүрслээд элч нарыг талбайн голд өлөн зэрлэг араатантай тулалдахаар зэхэж буй үзмэрээр дүрсэлж байжээ.

“Та нар хэдийн бялхсан бөгөөд баян болжээ. Та нар бидэнгүйгээр хаад болжээ. Та нар үнэхээр хаад болсон байгаасай гэж би хичнээн их хүснэ вэ. Тэгвэл бид ч та нартай хамт хаанчилна шүү дээ! Учир нь Бурхан элч болох биднийг үхэх ял оногдсон хүмүүс мэт бүхний сүүлчийнх болгосон гэж би боддог. Яагаад гэвэл бид ертөнцөд, тэнгэр элч нарт ч, хүмүүст ч үзмэр болжээ. Бид Христийн төлөө мулгуу аж. Харин та нар Христ дотор хашир аж. Бид мөхөс, харин та нар хүчтэй. Та нар алдар хүндтэй, харин бидэнд алдар хүнд ч алга. Энэ мөчийг хүртэл бид өлсөж, цангаж, ядмаг хувцаслан, ширүүн нударгад өртөж, орон гэргүй байж, гараа ажиллуулан нөр их хөдөлмөрлөж байна. Биднийг зүхэхэд нь ерөөж, хавчихад нь тэвчиж, гүтгэхэд нь тайтгаруулахыг бид хичээдэг. Бид одоо хүртэл дэлхийн хог, бүгдийн шаар шавхруу мэт болсон” (1 Коринт 4:8:13).

Коринт хотын итгэгчид Есүсийг хаан ширээнд залрахаас ч өмнө хаадын ёсоор хаанчилдаг болсон байлаа. Хааныг хаан ширээнд залах ёсол дээр хаанд титэм зүүлгэхээс өмнө албатууд нь титэм өмсөнө гэдэг ноцтой доромжлол, үл хүндэтгэсэн байдал гэж тооцогддог.

Хөрөнгө мөнгө хураана гэдэг Эзэн Есүсийн үзүүлсэн үлгэр дуурайл огт биш юм. Есүс хязгааргүй баян атал биднийг баяжуулахын тулд ядуу болсон (2 Коринт 8:9).

Шинэ Гэрээний эх бичигт ядуу хэмээн хөрвүүлэгдсэн хоёр үг байдаг. Эхнийх нь үг ажил хөдөлмөр эрхэлдэг боловч амин зуулгаас илүү гарах зүйлгүй хүний байдлыг илтгэдэг. Хоёр дахь үг нь эд баялгаар дутмаг буюу эд баялаггүй гэсэн утгатай аж. Элч Паул Эзэн Есүсийг хоёр дахь үгээр нь дүрсэлсэн байдаг. Итгэгч биднээс хичнээн нь бүх талаараа Есүсийг дагахад бэлэн байдаг бол?

Эд баялаг нь итгэгч хүний залбиралд ихээхэн саад болдог нь түүний бас нэг муу тал юм. Бүх юмаар бүрэн хангагдсан хүн юуны төлөө залбирах билээ? Өөрсдөө элбэг хийж чадах зүйлээ Бурханаас гуйна гэдэг бас үүнээс ч илүү зальжин хэрэг. Жишээлбэл, итгэгч бид өөрсдөө бүрэн санхүүжүүлж

чадах төслийг санхүүжүүлж өгөхийг Бурханаас гуйх нь их бий. Заримдаа Эзэний өөрийнх нь мөнгө өөрт нь хүртэхгүй байх явдал их гардаг.

Эцэст нь, эд баялаг хуримтлуулсан итгэгч хүнийг хараад баян болох хүслээр итгэгч болох хүн гарч мэдэх тул итгэгч хүн эд баялаг хуримтлуулах нь буруу юм. Эртний итгэгчдийн ядуу зүдүү байдал тэдний сул биш харин давуу тал байсан.

Дэлхий ертөнцийг орвонгоор нь эргүүлсэн тэр шашны анхны номлогчид бүгд ядуу хүн байсан нь зөвхөн тэнгэрээс заяасан байж таарна. Хэрэв элч нарт сонсогчдыг өөртөө татахын тулд өгөх мөнгө байсан бол эсвэл дайснуудаа айлгах цэргийн ангиар хамгаалуулдаг байсан бол элч нарын сургаал номлолын олсон амжилтад гайхаад байх зүйл нэг их үгүй байх байсан биз ээ. Гэвч Эзэний дагалдагчдын ядуу зүдүү байдал үл итгэгчдийн маргааны тасалж гарыг нь мухарладаг. Хүний төрөлх чанарт төдий л таатай бус сургаал заадаг, хүмүүсийг өөртөө татах буюу үгэндээ оруулахын тулд өгөөд байх мөнгө сэлтгүй Галат аймгийн хэдэн дорд хүн дэлхий ертөнцийг доргоож Ромын эзэнт гүрний нүүр царайг өөрчилсөн юм. Эдгээр эрчүүдийн тунхаглаж байсан Христийн сайн мэдээ энэ бүхнийг хийсэн бөгөөд тэр нь Бурханы Үнэн байсан юм.

Монголд сайн мэдээ дэлгэрүүлж байсан Гилмоур ийн бичсэн байдаг. “Хэрэв би тэдний дунд баян байсан бол тэд надаас үргэлж юм гуйх байсан. Намайг юу юунаас илүү бэлэг сэлт өгөгч хүн хэмээн үзэх байсан. Хэрэв би тэд нар дээр сайн мэдээнээс өөр юу ч үгүй очвол Бурханы юутай ч зүйрлэшгүй бэлэгнээс тэдний анхаарлыг саринуулах зүйл байхгүй байх болно.”

Иохан Петр хоёр сүмийн үүдэн дээр хазгар гуйлгачинтай тааралдаад түүнийг өглөг өгөөч хэмээн гуйхад Петр *“Надад алт, мөнгө байхгүй. Харин өөрт байгаагаа л би чамд өгье гээд, —Назарын Есүс Христийн нэрээр [босоод] явагтун”* (Үйлс 3:6) гэж байжээ.

Бүх итгэгч хүн ядуу байх албагүй, зөвхөн номлогчид л ядуу байх ёстой гэж хэлэх хүн гарч магадгүй. Гэвч Библид номлогчид болон бусад итгэгчдийн хооронд, харь газар болон өөрийн нутагт сайн мэдээ дэлгэрүүлэгчдийн хооронд санхүүгийн ялгаатай стандартыг тогтоосон байдаг гэж үү?

Арван наймдугаар бүлэг

ҮЛ ХӨДЛӨХ ЭД ХӨРӨНГӨ

Итгэгч хүн эд баялаг хураах нь яагаад буруу тухай бид нилээн ярилаа. Харин одоо өөрийн болон ар гэрийнхээ ирээдүйн хэрэгцээнд зориулан мөнгө хураадаг итгэгч хүмүүсийн үйлдлийг зөвтгөхөд ашигладаг зарим маргаануудын талаар ярьцгаая.

Эхний маргаан. Өндөр настай болсон хойноо хэрэглэх мөнгө хадгална гэдэг байж болох зүйл. Бид ажил хийж чадахаа больсон үедээ яах вэ? Хүнд өдрүүд заавал ирэх болно. Бурхан биднээс эрүүл ухаанаар сэтгэхийг хүсдэг.

Үнэмшилтэй сонсогдож байгаа биз? Гэвч энэ бол итгэлийн хэл яриа биш юм. Нөөц хөрөнгө бол Эзэнд итгэх итгэлийг орлуулж буй тулгуур буюу суга таяг юм.

Бид өөрөө өөрсдийнхөө ирээдүйн хэрэгцээг хангахаар шийдэх үед “Хичнээн хэмжээний хөрөнгө хүрэлцэх вэ? Хэдэн нас наслах бол? Мөнгөний ханш хир зэрэг унасан байх бол? Эм эмчилгээнд их зардал гаргах хэрэгтэй болох болов уу?” гэх мэт асуудлуудыг бодолцох хэрэгтэй болно.

Бидэнд хичнээн хэмжээний хөрөнгө мөнгө хүрэлцэхийг хэн ч хэлж мэдэхгүй. Тиймээс өндөр насны цөөхөн хэдэн жилийнхээ хэрэгцээг хангах гэж бүх насаа эд баялаг цуглуулахад зориулдаг. Энэ зуур Эзэнийг луйвардаж, аюулгүй байдлыг өгч чадахгүй зүйлээс түүнийг хайн амьдралаа дэмий үрдэг аж.

Гэвч зөвхөн өнөөдрийнхөө хэрэгцээний төлөө уйгагүй хөдөлмөрлөж, Эзэнд чадлынхаа хирээр үйлчилж, хэрэгцээнээс илүү гарсан бүхнийг Эзэний үйлсэд зориулж, ирээдүйгээ Түүнд итгэн даатгах нь илүү дээр билээ. Есүс өөрийг нь эн тэргүүнд тавьсан хүмүүст *“Харин эхлээд Түүний хаанчлал болон Түүний зөвт байдлыг хайгтун. Тэгвэл энэ бүхнийг та нарт нэмж өгөх болно”* (Матай 6:33) гэж амласан.

Эзэний мөнгийг сайн мэдээ дэлгэрүүлэх үйлсэд ашиглаж байсан Филиппой хотын итгэгчдэд хандан Паул ийн бичиж байжээ: *“Миний Бурхан Өөрийн алдар дахь баялгаар Христ Есүс дотор та нарыг хэрэгтэй бүхнээр тань хангана.”* (Филиппой 4:19).

Хүмүүс тэтгэвэрт гарсан хойноо Эзэнд амьдралаа зориулна хэмээн найдаж бусад бүх насаа эд баялаг олж хураахад зориулна гэж боддог нь энэ эрийн үеийн нэгэн эмгэнэлтэй ойлголт юм. Энэ бол амьдралынхаа хамгийн сайн сайхан он жилүүдийг бусадтай хамтран ажиллахад зориулаад хөдөлмөрийн чадваргүй болсон он жилүүдээ Эзэнд зориулна гэсэн үг билээ. Гэвч хөдөлмөрийн чадваргүй болох үе гэж байх эсэх нь бас тодорхойгүй юм. Ихэнх тохиолдолд Библийнхээ тоосыг гөвж амжихаас өмнө амьдрал дуусах нь бий.

Хүнд хүчир өдрүүдэд зориулж хөрөнгө мөнгө нөөцлөх нь эрүүл ухаан мэт. Гэвч энэ нь үнэндээ юу болохыг Камерон Томпсон оновчтойгоор ийн хэлсэн байдаг: *“Гартаа ямар нэгэн юм наалдуулахгүй байх тал дээр ихээхэн анхаарч санаа тавьдаг хүмүүсийн дээр Бурхан хайр ивээлээ харамгүй*

асгадаг. Өөрийн амсаж болох хүнд хүчир өдрүүдийг өнөөгийн дэлхийн зовлон шаналлаас дээгүүр тавьдаг хүмүүс Бурханы ивээлийг амсахгүй”

Газар дээр эд баялаг хураахыг зөвтгөхөд хэрэглэдэг хоёр дахь маргааныг хүмүүс 1Тимот 5:8 дээр үндэслэдэг: *“Харин хэрэв хэн нэгэн нь өөрийнхнийгөө, ялангуяа төрсөн гэр бүлийнхээ хүмүүсийг тэтгэхгүй байвал тэр хүн итгэлийг үгүйсгэсэн хэрэг болох бөгөөд итгэгч бус хүнээс ч бүр дор юм”*.

Паул энэ ишлэлд чуулганы бэлэвсэн эмэгтэйчүүдэд хэрхэн хандах талаар өгүүлэхдээ бэлэвсэн эхнэрийн садан төрлийн итгэгч хүмүүс түүнийг асран халамжлах үүрэгтэй гэжээ. Хэрэв асран халамжлах садан төрлийн хүн байхгүй бол энэ үүргийг чуулган хүлээх ёстой ажээ.

Гэвч Паул бэлэвсэн эмэгтэйд хэзээ нэгтээ ирээдүйд хэрэг болно хэмээн хөрөнгө мөнгө хуримтлуулан хадгалах тухай яриагүйг анхаарах нь чухал. Харин түүний өнөөгийн хэрэгцээний тухай ярьжээ. Итгэгч хүмүүс гачигдалтай байгаа садан төрлийнхөө хүмүүст өдрөөс өдөрт санаа тавих ёстой. Эс бөгөөс хайр ба өгөөмөр сэтгэлийг заадаг Христитгэлийг үгүйсгэж буй хэрэг болно. Итгэгч биш хүмүүс хүртэл өөрийнхөө хүмүүсийг харж ханддаг шүү дээ. Тиймээс үүнийг үл хийдэг итгэгч хүн итгэгч биш хүмүүсээс дор болох аж.

Уг ишлэлд нөөц хөрөнгө, хандив, хөрөнгө оруулалт гэх мэтийн талаар огт өгүүлээгүй бөгөөд ирээдүйн үүрэг хариуцлага биш харин өнөөгийн хэрэгцээний талаар өгүүлжээ.

Гурав дахь маргаан бол хоёр дахь маргаантай нилээн холбоотой юм. Итгэгч олон эцэг эх хүүхдүүддээ тодорхой хэмжээний өв хөрөнгө үлдээх ёстой гэж боддог. Тэд 1 Тимот 5:8 өгүүлсэн өөрийнхнийхөө хүмүүсийг тэтгэх гэдэг чухам ийм утгатай гэж үздэг. Хүүхдүүд нь итгэгч үү үгүй гэдгээс үл хамааран тэдэнд зохих хэмжээний хөрөнгө үлдээхийг тэд маш их хүсдэг.

2 Коринт 12:14-ийг заримдаа эцэг эхчүүд үр хүүхдүүддээ зориулж мөнгө хураах ёстой хэмээн заахад ашигладаг. Уг ишлэлд *“Учир нь хүүхдүүд эцэг эхийнхээ төлөө биш, харин эцэг эх нь хүүхдүүдийнхээ төлөө баялгийг хураах ёстой”* гэжээ.

Дээр өгүүлсэнчлэн уг ишлэлийн хам сэдэв Паулд үзүүлэх санхүүгийн мөнгөн тусламжийн тухай өгүүлсэн ажээ. Паул Коринт хотын итгэгчдээс мөнгө огт авч байгаагүй бөгөөд харин Коринт хотод сургаал ном зааж байхдаа өөр сүм чуулганаас ирүүлсэн бэлэг сэлтээр тэтгүүлдэг байсан аж. Харин одоо Коринт хот руу дахин очих гэж байжээ. Ингэхдээ тэдэнд ачаа дарамт болохыг хүсээгүй (12:14) бөгөөд тэдний зүгээс үзүүлэх санхүүгийн аливаа тэтгэлгээс хамааралгүй байхыг хүсэж байгаагаа илэрхийлжээ. Паулд тэдний материаллаг эд хөрөнгийг биш харин сүнсний сайн сайхныг илүү сонирхож байв.

Тийм ч учраас *“Учир нь хүүхдүүд эцэг эхийнхээ төлөө биш, харин эцэг эх нь хүүхдүүдийнхээ төлөө баялгийг хураах ёстой”* хэмээн нэмж хэлсэн байлаа. Коринт хотын итгэгчид Паулын хүүхдүүд Паул тэдний эцэг байв (1 Коринт 4:15). Тэрээр илт егөөдсөн байдлаар тэд түүнийг биш харин тэр тэднийг тэтгэх ёстой гэжээ. Үнэндээ тэд түүнийг ивээн тэтгэхэд тус нэмэр оруулах ёстой байсан учир (1 Коринт 9:11,14) Паул үүнийг тийнхүү

егөөдөөд тэдний тусын тулд тэд нараар тэтгүүлэх эрхээсээ татгалзсан байв.

Уг ишлэл хожмын өдрүүдэд зориулан хөрөнгө мөнгө хураахтай огт холбоогүй болохыг анхаарах нь чухал. Энэ тухай огт яриагүй аж. Харин өнөөгийн хэрэгцээний тухай өгүүлсэн бөгөөд Паул “Ер нь бол хүүхдүүд нь эцэг эхийнхээ биш харин эцэг эх нь хүүхдүүдийнхээ хэрэгцээг хангадаг” хэмээн хэлсэн ажээ.

Хүүхдүүддээ зориулж өв хөрөнгө хураахыг дэмжсэн ишлэл Шинэ Гэрээнд байхгүй нь мэдээж. Эцэг эхийн үлдээж чадах хамгийн агуу өв бол сүнслэг байдал бөгөөд хөрөнгө мөнгөний хойноос хөөцөлдөх нь сүнслэг өвийг үлдээхэд саад болох болно.

Итгэгч хүмүүсийн үлдээсэн материаллаг өв хөрөнгөөс хичнээн олон муу муухай зүйл урган гарч байсан билээ.

Гэнэт орж ирсэн эд баялгаас болж сүнслэг байдлаа алдсан итгэгч залуус олон бий. Тэд эд материал элдэв таашаалд мансууран согтож Эзэний үйлчлэлийг орхигдуулдаг.

Түүнээс гадна гэрээслэл болон эд хөрөнгөөс болж гэр бүлд үүсдэг зөрчил тэмцлүүд бас бий. Эгч нь дүүдээ, дүү нь ахдаа атаархана. Үүнээс болж насан туршид нэг нэгэндээ хорсож муудалцана.

Лук 12:13-14 –т өв залгамжлалаас болж үүдэн гарсан гэр бүлийн хэрүүл маргааны тухай өгүүлжээ. Есүс энэ хэрэгт оролцохыг хүссэнгүй. Тэр ийм хэргээр газар дэлхий дээр ирээгүй. Гэвч гэрээслэлд нэр нь багтаагүй, золгүй хүнд хандан шуналаас болгоомжлохыг сануулан хэлэх цаг гаргасан байдаг.

Бас нэг нөхцөл байдал бий. Эцэг эхчүүд үр хүүхдэдээ юм үлдээхийн тулд насан турш уйгагүй хөдөлмөрлөдөг. Хожим нь хөгшин настай болоод гэр бүлийнхнийхээ асаргаанд ордог. Гэтэл ачыг үл санах хүүхдүүд нь тэдний мөнгөнд гараа дүрэхийн тулд тэднийг насан өөд болохыг арайхийн хүлээх нь бий.

Итгэгч биш хүүхэд буюу итгэгч биш хүмүүстэй гэрлэсэн итгэгч хүү, охиндоо үлдээсэн мөнгө ихэвчлэн Христийн жинхэнэ биш хуурамч сүм рүү орж сайн мэдээг дэлгэрүүлэхэд биш харин даран боогдуулахад ашиглагддаг. Энэ талаар сайн бодоод үзээрэй! Итгэгч хүний мөнгө Үнэний эсрэг тэмцэхэд ашиглагддаг!

Түүнээс гадна бас гэрээслэлийн татвар болон албаны хүмүүст төлдөг их хэмжээний мөнгөний талаар бодох ёстой. Энэ бүх мөнгийг аврагдаагүй хүмүүсийг авралтай болгох үйлсэд ашиглаж болох байсан.

Зарим итгэгч хүн энэ бүхнээс зайлсхийхийн тулд мөнгөө Христэч үйл ажиллагаа явуулдаг байгууллагад үлдээх нь бий. Гэвч тэдний мөнгө хүссэн тэр байгууллагад нь баттай очно гэсэн баталгаа байхгүй. Гэрээслэлүүд үргэлж маргаан дагуулж зөрчигдөх нь их. Тэгээд ч мөнгө үлдээх тухай ойлголтыг дэмждэг Библийн хэсэг, ишлэл гэж ганц ч байхгүй. Гэрээслэлээр үлдээсэн мөнгийг авах тэр үед тухайн байгууллага Эзэн болон Эзэний Үгэнд үнэнч хэвээр байна гэсэн баталгаа бас байхгүй билээ.

Итгэгч хүн гэрээслэл үлдээснийхээ төлөө тэнгэрт шагнал хүртэхгүй. Түүнийг үхэх тэр мөчид мөнгө нь түүнийх байхаа болино.

Хүн эд баялгийг овоолдог боловч түүнийг хэн авахыг мэддэггүй

(Дуулал 39:6). Амьд сэрүүн байхдаа мөнгөө Эзэнд зориулан өгөх нь таны мөнгө Эзэний төлөө ашиглагдах болно гэдгийг баттай мэдэх цорын ганц арга юм. Бас ирээдүйд шагнал хүртэх ганц зам ч энэ юм.

Бид Эзэн Есүс удахгүй ирнэ гэдэгт итгэдэг гэдэг. Тэгвэл Түүний ирэх цаг ойртох тусам материаллаг эд зүйлийн ач холбогдол багасах болно гэдгийг бид бас ойлгох ёстой. Түүнийг ирэх үед бидний эд баялаг өөрсдөд маань ч, Бурханы үйлсэд ч үнэ цэнэгүй болох болно. Тиймээс эд хөрөнгөө одоо Есүсийн төлөө ашиглах нь юу юунаас илүү дээр ажээ.

“Хэрэв хүн бүр даруухан амьдралаас илүү гарсан бүхнээ Эзэний үйлсэд зориулна гэвэл бид яаж амьдрах билээ? Ядаж хэн нэг нь эд хөрөнгөтэй байх ёстой биш үү?” гэж маргах хүн гарах байх.

“Яаж амьдрах вэ?” гэв үү? Хариултыг нь хэлье. “Итгэлээр илүү их харж байгаа зүйлээрээ аль болох бага амьдрах хэрэгтэй.” Ингэж амьдрах нь бүтэхгүй гэж маргаад нэмэргүй ээ. Яагаад гэвэл бүтнэ, болно гэдгийг эртний чуулган хэдийнээ харуулсан билээ.

“Итгэсэн бүгд хамтаараа байцгаан, байгаа бүхнээ нийтээрээ хэрэглэж байв. Тэд эзэмшил, өмч хөрөнгөө худалдаж, түүнийгээ хүн бүрийн хэрэгцээг харгалзан бүгдэд түгээдэг байлаа” (Үйлс 2:44-45).

“Гачигдаж дутагдсан хүн тэдний дунд байсангүй. Учир нь газар, орон байр эзэмшигчид нь цөмөөрөө тэр бүгдээ худалдсан өртгийг нь авчирч, элч нарын хөлд тавихад, тэд хүн бүрд хэрэгцээнийх нь хэрээр хуваарилдаг байлаа” (Үйлс 4:34-35).

Паул Коринт хотын итгэгчдэд хандан бичсэн захидалдаа бидний эд хөрөнгө хөдөлшгүй хатуу биш харин уян зөөлөн байх тухай заасан байдаг. Жинхэнэ гачигдал хэрэгцээ хаана байна тийшээ бидний эд хөрөнгө урсан очдог байх ёстой. Тэгвэл бид өөрсдөө гачигдалд орох үед хөрөнгө мөнгө бид нар руу урсан ирэх болно. Ингэж Бурханы хүмүүсийн дунд эрх тэгш байдал байнга тогтох аж.

“Бусдын хувьд хөнгөн болж, та нарт зовлон болоосой гэсэндээ бус, харин тэгш байхын үүднээс ингэв. Өнөө цагт та нарын элбэг дэлбэг байдал тэдний хэрэгцээг хангаж байгаачлан тэдний элбэг дэлбэг байдал бас та нарыг хангах болно. Тэгэхлээр тэгш байх болно. Энэ нь “Ихийг хураасан хүнд нь илүүдсэнгүй, багыг хураасан хүнд нь дутсангүй” гэж бичсэнчлэн юм” (2 Коринт 8:13-15).

Өөрөөр хэлбэл, хэрэв хүн өөрийгөө Эзэнд үнэхээр бүрэн зориулан амьдарч, эд хөрөнгөдөө итгэмжит нярвын ёсоор хандвал түүнд гачигдал тохиолдох үед бусад итгэгчид түүнтэй эд зүйлээ хуваахдаа дуртай, баяртай байх болно.

Үнэнийг хэлэхэд бусдаас хамааралтай байна гэж бодоход л бидний дургүй хүрдэг билээ. Бид бие даасан байдлаараа бахархдаг. Гэвч ийм амьдрал бидний дотор амьдарч байгаа Эзэн Есүсийн амьдралын биш харин хувь хүний өөрийнх нь амьдралын илрэл биш гэж үү?

Бэлэвсэн эхнэрийг асран халамжлах тухай 1 Тимот 5:3-13-т Паулын

бичсэн заавар зөвлөгөө хүмүүний зүрхэнд Бурханы хайр цутган орсон, ариун хүмүүс харилцан нэг нэгэндээ санаа тавьдаг, жинхэнэ гачигдал гарсан газар руу хөрөнгө мөнгө чөлөөтэй урсан очдог тийм сүм чуулгантай холбоотой ажээ. Энэ бүхэн зөвхөн эртний чуулганы үед л боломжтой байсан харин өнөө үед бол бүтэхгүй хэмээн маргах хүн байвал түүнд өнөө үед ч боломжтой хэмээн хариулах байна. Итгэлийн амьдралаар амьдардаг итгэгч хүмүүс бий. Тэдний амьдралд үгүйсгэхийн аргагүй их хүч, бусдыг татах гоо үзэсгэлэн оршин байдаг.

Гэвч, Паул *“Би тарчигхан байхыг ч мэднэ, элбэг дэлбэг байхыг ч мэднэ”* (Филиппой 4:12) гэж хэлээгүй гэж үү хэмээн эсэргүүцэх хүн гарах байх. Ингэж хэлж байгаа хүн тарчигхан Паулыг эзгүй цөл газар, өлөн зэлмэн, ангаж цангасан, туйлдаа хүртэл эцэж цуцсан, уранхай ноорхой гутал хувцастайгаар төсөөлж элбэг дэлбэг Паулыг сүүлийн үеийн загварын үнэтэй ганган хувцас өмссөн, үнэтэй тансаг машин хөлөглөсөн гялалзсан залуу хэмээн төсөөлсөн байх. Өөрөөр хэлбэл ядуусын дунд ч баячуудын дунд ч амьдарч байсан гэх байх.

Гэвч Паул чухам үүнийг Филиппойчуудад бичсэн захидалдаа хэлэх гээгүй ажээ. Паул уг захидлыг далайн эргийн амралтын газраас биш харин шоронгоос бичсэн гэдгийг мартаж болохгүй. Тэрээр шоронгоос бичсэн мөртлөө *“Гэвч би бүгдийг элбэгээр хүлээн авч хангагдсан. Би Епафродитоос та нарын илгээсэн юмсыг тань хүлээн аваад дүүрэн байна Бэлэг тань Бурханд таашаагдах тааламжит тахил ба анхилуун үнэр юм.”* (Филиппой 4:18) гэжээ.

Шоронд хоригдоно гэдэг тарчигхан байдлын нэг тал гэж бид бодох байх. Гэвч Паул үүнийг элбэг дэлбэг байдлын нэг тал хэмээн үзсэн аж. Тиймээс бид Филиппой 4:12-ыг баян тасаг амьдралыг зөвтгөх зүйл болгож болохгүй. Энэ бол уг ишлэлийн гол санаа биш юм.

Тэгвэл Бурхан биднийг баясаж цэнгэх бүх зүйлсээр элбэг хангадаг гэсэн ишлэл бий. Түүнийг яах вэ? (1 Тимот 6:17). Уг ишлэлийг итгэгч хүн амьдралын сайн сайхан бүхнийг амсах ёстой, өөрөөр хэлбэл хамгийн сүүлийн үеийн хамгийн сайн бүхнийг эдлэх эрхтэй гэдгийг нотлох Библийн үндэслэл болгон иш татах явдал их гардаг. Ийм хүмүүс “Дэлхий дээрх хамгийн сайн сайхан бүхэн Бурханы хүүхдүүдэд зориулагдсан” гэсэн үгийг уриагаа болгодог. Гэвч дахиад л хам сэдвийг нь орхигдуулчихлаа. Уг ишлэл яаж эхэлснийг харцгаая: *“Чи энэ үеийн ертөнцийн баячуудад хандан биеэ бүү тоо, эд хөрөнгөний тодорхойгүй байдалд найдвар бүү тавь... хэмээн тушаа.”* (1 Тимот 6:17) гэжээ. Өөрөөр хэлбэл энэ ишлэлийн үгс өөрийгөө эрхлүүлэх шалтаг болохоос илүү чинээлэг байхаас болгоомжлуулсан өнгө аястай бичигджээ.

Тэгвэл Бурхан бидэнд баясаж цэнгэх зүйлсээр элбэг хангасан гэдэг ямар утгатай вэ? Эдгээр зүйлсийг хурааж цуглуулахын тулд биш харин бусадтай хуваалцахын сайхныг эдлүүлэхийн тулд өгдөг гэсэн үг. Үүнийг дарах хоёр ишлэлээс тодорхой харж болно:

“Сайныг үйлдэж, сайн үйлсээрээ баян болж, өглөгч бөгөөд хуваалцахад бэлэн бай хэмээн тэдэнд тушаа. Ингэхдээ тэд ирээдүйн төлөө өөрсдөдөө сайн үндэс суурийг тавин эрдэнэсийг хурааснаараа жинхэнэ аминд хүрэх

юм” (1 Тимот 6:18-19).

Бид эд баялагтай байхын сайхныг биш харин түүнийг Бурханы алдрын төлөө, бусдын сайн сайхны төлөө ашиглахын сайхныг амсах ёстой.

Түүнээс гадна Абрахамыг баян хүн байсан боловч (Эхлэл 2:23) түүнийг Бурханы анд нөхөр (Иаков 2:23) байсан гэдгийг бидэнд олонтаа сануулах нь бий. Энэ үнэн гэдэг нь мэдээж. Гэвч Абрахам Хуучин Гэрээний үед амьдарч байсан ба Бурхан тэр үед Эзэнийг дуулгавартай дагасан хүмүүст чинээлэг аж амьдралыг амалдаг байсан. Эд баялаг Бурханы хайр ивээлийн илрэл байв. Бурханы нигүүслийн энэ эрин үед ч бас тийм биш гэж үү? Эд баялгаас татгалзах нь энэ эрин үеийн ивээл гэж хэлэх нь илүү онох болов уу.

Лазар болон чинээлэг эрийн тухай сургаалт зүйрлэлд (Лук 16:19-31) Хуучин Гэрээний хэмжигдэхүүн эсрэгээр туссан ажээ. Чинээлэг эр эд баялгаа бусдын тусын тулд ашиглахын оронд өөртөө зориулан хураасныхаа төлөө яллагдсан байлаа.

Бидэнд бас шоргоолжноос суралц хэмээн заадаггүй гэж үү?

“Залхуу минь, чи яв, шоргоолж юу хийдгийг ажиглан хар, ухаантай бай. Түүнд ахлагч, харгалзагч ба удирдагч гэж байхгүй атлаа, Өөрийнхөө хоол тэжээлийг зуны цагт бэлдэж, Ургац хураах цагаар нөөцөө цуглуулдаг” (Сургаалт үгс 6:6-8).

Шоргоолж хүртэл ирээдүйнхээ хэрэгцээнд зориулж хүнс нөөцөлж байхад бид бас энэ тал дээр түүнийг дуурайх ёстой гэдгийг энэ ишлэл харуулж байгаа бус уу? Тийм ээ. Гэвч мартаж болохгүй нэг чухал зүйл бий. Шоргоолжны ирээдүй газар дээр харин итгэгч хүний ирээдүй тэнгэрт байдаг. Итгэгч хүн газар дээр түр оршин суугч буюу аянчин юм. Түүний гэр тэнгэрт байгаа. Тиймээс ирээдүйнхээ төлөө тэнгэрт эд баялгийг хураах ёстой.

Харин газар дээрх амьдралын тухайд юу өмсөх билээ, юу идэх билээ хэмээн маргаашийнхаа төлөө санаа зовох ёсгүй (Матай 6:25). Үүний оронд хэзээ ч үүрнийхээ хажууд агуулах сав барьдаггүй ч тэнгэрлэг Эцэгээр тэжээгддэг шувуудыг дуурайх ёстой. Бяцхан болжморыг хүртэл харж халамжилдаг Бурхан биднийг хичнээн ихээр хайрлаж халамжлах билээ!

Эцэст нь чинээлэг хүмүүст сайн мэдээг хүргэхийн тулд чинээлэг байх хэрэгтэй гэж бас маргадаг. Эртний чуулганы итгэгчид үүнийг ойлгодоггүй байсан бололтой.

Эртний сүм чуулганы олон итгэгчид Христийн сайн мэдээг газар сайгүй тараахыг маш их хүссэн учир өөрсдийгөө зарц болгон хөлслүүлж, боол болгон зарж байсан нь чинээлэг хүмүүс болон өндөр албан тушаалтнуудын гэрт хүлээн зөвшөөрөгдөж, тэнд амьдарснаар Есүсийн хайр болон авралыг эдгээр гэрүүдэд мэдүүлэх боломжтой болохын тулд байсныг түүх өгүүлдэг.

Арван есдүгээр бүлэг

ЭНЭ ТАЛААР БИБЛИД ЮУ ГЭЖ ЗААДАГ ВЭ?

Ядуу зүдүү байдал ноёрхсон дэлхий ертөнцөд баян чинээлэг амьдардаг итгэгч хүмүүсийг зөвтгөхөд ашигладаг хэдэн гол маргааны талаар бид ярилцлаа. Энэ цөөхөн хэдэн тааруухан маргааныг няцааж чадах эд баялгийн аюулыг сэрэмжлүүлсэн Библийн хэсгүүд олон бий.

“Итгэлтэй хүн ерөөлөөр бялхах болно. Харин баяжих гэж яарч тэвддэг хүнд заавал шийтгэл ирнэ... Хорон муу нүдтэй хүн эд баялгийн араас яаравчилдаг боловч Ядуурал гадаа нь ирчихээд буйг үл анзаардаг” (Сургаалт үгс 28:20,22) .

Материаллаг эд хөрөнгөний хойноос улайран хөөцөлдөх нь Бурханы дүр төрх, Түүнтэй ижил байдлаар бүтээгдсэн нэгний хувьд үл тохирох зүйл юм.

“Хэн ч хоёр эзэнд үйлчилж чадахгүй. Тэр нэгийг нь үзэн ядаж, нөгөөг нь хайрлах болно. Эсвэл нэгээс нь зуурч, нөгөөг нь зэвүүцнэ. Та нар Бурхан болоод эд баялагт хоёуланд нь зэрэг үйлчилж чадахгүй” (Матай 6:24).

Энд Бурхан, мөнгө хоёрыг аль алинд нь нэг зэрэг үйлчлэх боломжгүй эрс тэс хүсэл сонирхотой хоёр эзнээр төлөөлүүлжээ. Энэ ишлэл дэлхийд ч одоо баян, тэнгэрийн оронд ч дараа нь баян байж газар дээр эд баялгийг таалан эдэлж дээд тэнгэрт ч бас шагнал хүртэн хоёр өөр ертөнцөд нэгэн зэрэг амьдрах гэсэн их хүслийн галыг унтраах аж. Харин бид энэ хоёрын аль нэгийг сонгох ёстой.

“Есүс шавь нартаа —Үнэнээр Би та нарт хэлье. Баян хүн тэнгэрийн хаанчлалд орох нь нэн бэрх аж. Би та нарт дахин хэлье. Баян хүн Бурханы хаанчлалд орохоос тэмээ зүүний сүвэгчээр нэвтрэх нь илүү хялбар гэв. Шавь нар нь үүнийг сонсоод ихэд гайхан —Тэгвэл хэн аврагдаж чадах вэ? гэцгээхэд Есүс тэднийг хараад,—Энэ нь хүмүүст боломжгүй, харин Бурханд бүх юм боломжтой гэж айлдав” (Матай 19:23-26).

Есүсийн хэлсэн энэ үгийг бид хир нухацтай авч үздэг болгэж би хаая их боддог. Тэрээр чинээлэг хүнийг Бурханы хаанчлалд ороход хэцүү гэж хэлээгүй. Харин хүний хувьд ямар ч боломжгүй гэжээ. Зарим хүн зүүний сүвэгчийг хотын дааман хаалгатай адил хэмээн тайлбарладаг. Тэмээ энэ хаалгаар орохын тулд доошоо бөхийх хэрэгтэй болдог байжээ. Гэвч уг ишлэлд өгүүлсэн зүү бол оёдлын зүү бөгөөд ямар ч тэмээ ийм зүүний нүхээр багтаж орохгүй. Тиймээс тэнгэрлэг хүчний ер бусын гайхамшиг л зөвхөн чинээлэг хүнийг Бурханы хаанлал руу оруулж чадах аж. Тэгвэл бид аливаа хүний өнө мөнхийн жаргалд саад болдог тэр зүйлийг юунд тэгтлээ их өмгөөлнө вэ?

“Харин баячууд та нар золгүй еэ! Та нар тайвширлаа дүүрнээр хүлээн авсан” (Лук 6:24) Энэ ишлэлд Бурханы ариун Хүү баян чинээлэг

хүмүүсийг золгүй гэжээ. Баян чинээлэг гэсэн энэ үг энд шууд утгаараа хэрэглэгдсэн аж. Тэгвэл бид яагаад Бурханы ерөөгөөгүй хүмүүсийг ерөөх гэж хичээнэ вэ?

“Өмч хөрөнгөө худалдаад өглөг үйлд. Хэзээ ч хуучрахгүй уутыг өөрсдөдөө зэх, тэнгэрт шавхагдашгүй баялгийг хураа. Тэнд хулгайч ойртохгүй, хивэн хорхой сүйтгэхгүй. Юу гэвэл та нарын баялаг хаана байна, тэнд бас зүрх сэтгэл тань байх болно” (Лук 12:33-34).

Есүс энэ үгийг дагалдагч нартаа зориулан хэлсэн байв (22-р ишлэлийг үз). Гэвч бид үүнийг бидэнд хандаж хэлээгүй гээд аль болох зайлсхийхийг хичээдэг. Иймэрхүү ишлэлүүдийг эсэргүүцсэнээр бид Бурханы ерөөлийг л зөвхөн эсэрүүцэх болно.

Бурханы нигүүслийн дор байгаа манай энэ эрин үед зориулж өөрт байгаа үнэтэй бүхнээ зар гэж хэлээгүй гэж үү? Бид үнэт эрдэнийн зүүлт чимэглэлүүдээ, эх уран зургуудаа, эртний ховор үнэт тавилгуудаа, алт мөнгөн эдлэлүүдээ, маркны цуглуулгуудаа бүгдийг нь зараад мөнгий нь дэлхий даяар олон сая хүнийг авралтай болгох үйлсэд зориулах ёстой ажээ. Бидний зүрх сэтгэл хаана байдаг вэ? Банканд уу? Эсвэл тэнгэрт үү? *“...та нарын баялаг хаана байна, тэнд бас зүрх сэтгэл тань байх болно”*

“Үүнийг сонсоод Есүс түүнд —Чамд нэг л зүйл дутуу байна. Эзэмшиж байгаа бүхнээ худалдаж, ядууст тарааж өг. Тэгвэл чи тэнгэрт баялагтай болно. Тэгээд ирж, Намайг дага гэв. Харин тэр үүнийг сонсоод ихэд гунигтай болов. Учир нь тэр маш баян хүн байжээ” (Лук 18:22-23).

Энд өгүүлэгдэж буй чинээлэг залуу эр онцгой тохиолдол байсан, байгаа бүхнээ зар гэсэн тушаал бүх хүнд хамаагүй гэж хэлэх тохиолдол олон гардаг. Тийм байлаа ч уг ишлэлийн сургаал бидний өмнөхөн үзсэн Лук 12:33-34-р ишлэлүүдийн сургаалаас онцын ялгаагүй юм.

“Харин сүсэглэл ба сэтгэл хангалуун байдал нь хамтдаа байвал энэ нь агуу ашиг мөн. Учир нь бид ертөнцөд юуг ч авчраагүй. Мэдээж бид эндээс юуг ч бас авч гарч чадахгүй. Хэрэв бидэнд хоол хүнс, хувцас хунар байвал эдгээрээр бид сэтгэл хангалуун байх болно. Харин баяжих хүсэлтэй хүмүүс сорилтод ба урхи, мөн зүсэн бүрийн мунхаг, хор хөнөөлтэй хүсэлд унадаг. Эдгээр нь хүмүүсийг үгүйрэл ба сүйрэлд хүргэдэг. Учир нь мөнгөний хайр бол бүх төрлийн бузар муугийн үндэс мөн. Зарим хүмүүс үүнийг хүссэнээр итгэлээсээ төөрөн одож, түмэн зовлонгоор өөрсдийгөө сүлбэжээ. Харин Бурханы эр хүн ээ, чи энэ бүгдээс зайлсхий. Зөв байдал, сүсэглэл, итгэл, хайр, тэвчээр ба дөлгөөн занг эрхэмлэ” (1 Тимот 6:6-11).

Паул мөнгөнд шунадаг хүмүүс өөрсдийгөө олон арван гуниг зовинолоор цоо хатгаж байгаа хэрэг гэжээ. Ямар гуниг зовинолууд вэ?

Эхнийх нь эд баялгийг заавал дагалддаг зовинок юм. *“Их ч, бага ч идсэн ажилчин хүний нойр таатай байдаг атал баян хүний цатгалан гэдэс өөрийг нь унтуулдаггүй ажээ” (Номлогчийн үгс 5:12).* Аюулгүй байдлыг өгөх учиртай эд баялаг эсрэгээрээ хулгайчаас, ханш уналтаас эсвэл үнэт

цаасны зах зээлийн хэлбэлзлээс айх айдсыг авчирдаг.

Хоёрдугаарт, хэт элбэг дэлбэг материаллаг эд зүйл хүүхдүүдийнх нь сүнсний өсөлтийг хэрхэн сүйрүүлж байгааг харахын зовлон байдаг. Чинээлэг эцэг эхтэй хүүхдүүдээс Эзэний төлөө амьдарч чадах нь тун цөөхөн аж.

Түүнээс гадна, эд баялаг яг хэрэгтэй цагт танд төдийлөн тусалж чадахгүй байхын гачлан бий.

Баян хүн хичнээн найзтай вэ гэдгээ мэддэггүй. Энэ нь *“Ядуу хүнээс хөрш нь хүртэл зугтдаг бол Баян хүнд олон найз нөхөд байдаг”* хэмээн өгүүлдэг Сургаалт үгс 14:20-той зөрчилдөж байх мэт ажээ. Гэвч тэд жинхэнэ анд нөхөр мөн үү, эсвэл хувийн ашиг сонирхлоор найз болж тоглож байна уу?

Эд баялаг зүрх сэтгэлийг хэзээ ч бүрэн хангаж чаддаггүй ба харин илүү ихийг хүсэх ханашгүй их шунал хүслийг төрүүлдэг (Номлогчийн үгс 2:8, 4:8, 5:10).

Эцэст нь, эд баялаг хүний зан чанарт муугаар нөлөөлж бардам зан, ширүүн догшин авирыг бий болгодог (Сургаалт үгс 28:11). Жишээ нь алдартай Библи судлаач Мартин Хенри энэ талаар ийн бичжээ:

Эд баялаг хэмээн хөрвүүлэгдсэн еврей үг “хүнд хэцүү” гэсэн утгатай бөгөөд эд баялаг нь үнэндээ хүнд дарамт юм. Эд баялгийг олох нь хүнд дарамт, олсон хойноо айн эмээж хадгалах нь хүнд дарамт, буруу зүйлд татагдахын хүнд дарамт, гуниг зовлонгийн хүнд дарамт, эцэст нь хариуцлага хүлээхийн хүнд дарамт юм.

“Чи энэ үеийн ертөнцийн баячуудад хандан биеэ бүү тоо, эд хөрөнгөний тодорхойгүй байдалд найдвар бүү тавь, харин биднийг баясаж цэнгэх бүх зүйлсээр элбэг хангадаг Бурханд найд хэмээн тушаа. Сайныг үйлдэж, сайн үйлсээрээ баян болж, өглөгч бөгөөд хуваалцахад бэлэн бай хэмээн тэдэнд тушаа. Ингэхдээ тэд ирээдүйн төлөө өөрсдөдөө сайн үндэс суурийг тавин эрдэнэсийг хурааснаараа жинхэнэ аминд хүрэх юм” (1 Тимот 6:17-19).

Уг ишлэлд биднийг *“баячуудад хандан..... тушаа”* гэжээ. Бурханы зарц нараас хэд нь энэ даалгаврыг биелүүлдэг бол? Хичнээн хүн баячуудтай энэ талаар ярьсан бол? Ихэнх хүн энэ талаар ямар нэг номлол олж сонсоогүй байдаг. Агуу их хувьсгал өөрчлөлтийг авчирч чадах энэ ишлэлийн хэрэгцээ өнөөгийнхөөс илүү их байсан үе гэж байхгүй болов уу.

Уг ишлэлийг бусдад номлон заахын тулд бид өөрсдөө эхлээд түүнийг даган биелүүлэх ёстой. Хэрэв бид итгэлээр биш харин харагдаж байгаа зүйлээр амьдардаг бол газар дээр биш харин тэнгэрт эд баялаг хураа хэмээн бусдад хэлж чадахгүй. Амьдрал өөрөө бидний амыг таглах аж.

Бурхан, үр дагавараас үл хамааран Өөрийнх нь Үгийг аймшиггүйгээр ярих зөнчдийн удам угсааны хүмүүсийг хайж байгаа. Үүний нэг жишээ бол Амос юм:

“Самарийн уулан дээрх Башаны үнээнүүд ээ, энэ үгийг сонс. Та нар ядуу хүмүүсийг дарлаж, гачигдсан хүмүүсийг няц дардаг. Та нар өөрсдийн эзэддээ “Одоо авчир, бид ууя” гэж хэлдэг. Эзэн БУРХАН Өөрийн ариун байдлаар тангарагласан. “Харагтун, тэд та нарыг

дэгээгээр болон та нарын сүүлчийн хүмүүсийг загасны дэгээгээр авч явах өдөр та нар дээр ирж байна. Та нар хэрмийн цөмөрхийгөөр гарч, нэг нэгээр чирэгдэн, Хармон уруу хаягдах болно" гэж ЭЗЭН тунхаглаж байна" (Амос 4:1-3).

Бас Хаггай “Энэ өргөө эзгүйрэн хоосроод байхад гоёмсог гэртээ суух нь та нарын хувьд цаг нь мөн гэж үү?” (Хаггай 1:4) хэмээн нижигнэтэл хэлж байсан.

Зөнчид ер нь хэзээ ч олон түмэнд алдартай байгаагүй. Тэд байгаа гарынхаа хүмүүсийг ичиж зовоход хүргэдэг байсан. Тэд санхүүгийн тал дээр дарамтлуулж, нийгэмдээ гадуурхагддаг байсан. Заримдаа тэднийг хавчин гадуурхдаг байсан ба хэрэв тэдний ярихыг юу ч болиулж чадахгүй бол алагдахад хүрдэг байв. Гэвч тэд үүнийг тоодоггүй байсан. Тэд амьд байж худал ярьснаас үнэнийг хэлээд үхэхийг илүүд үздэг байжээ.

Материализм ба эд баялаг өнөө үед Чуулганы сүнслэг хүчний урсгалыг саатуулж байна. Итгэгч хүмүүс хаан шиг амьдарч байгаа цагт сэргэн мандалт хэзээ ч болохгүй. Бурханы хүмүүсийг итгэлийн болон золиосын амьдрал руу дуудах хүн хаана байна?

Жинхэнэ амьдралаар (1 Тимот 6:19) яаж амьдрахыг хүмүүст харуулах хүн хаана байна? Ч. Х Макинтош ийн бичсэн байдаг: “Цорын ганц жинхэнэ амьдрал бол өнө мөнхийн гэрэл дотор амьдардаг, байгаа бүхнээ Бурханы алдрыг мандуулахад ашигладаг, харцаа өнө мөнхийн баялаг дээр тогтоодог амьдрал юм. Энэ бол цорын ганц, хүсүүштэй амьдрал”.

“Баян хүн өөрийн басамжлал дотроо сайрхаг. Яагаад гэвэл тэр өвсний цэцэг мэт өнгөрнө. Учир нь нар төөнөж, халуун салхи өвсийг гандаахад цэцэг нь унаж гоё сайхан байдал нь устдаг. Үүний адил баян хүн ч замдаа тийнхүү үрэгдэх болно” (Иаков 1:10-11).

Баян хүн эд баялагдаа биш харин өөрийг нь дорд болгогч бүхнээр сайрхах ёстой ажээ. Яагаад? Яагаад гэвэл эд баялаг гэдэг өвстэй адил гандан мууддаг бол сүнслэг амьдралын туршилга, ба сургамж өнө мөнхийн ач холбогдолтой юм.

“Баян хүмүүс та нар, нааш ирэгтүн. Өөрсөд дээр чинь ирж буй зовлонгийнхоо төлөө гашуудан уйл. Эд баялаг чинь ялзарч, дээлийг чинь эрвээхий иджээ. Алт, мөнгө чинь зэвэрч, зэв нь та нарын эсрэг гэрч болж, махан биеийг чинь гал мэт шатаана. Та нар эцсийн өдрүүдэд эрдэнэсээ хураажээ. Харагтун, тариаланг чинь хураасан ажилчдын хөлс, та нарын саатуулаад байгаа тэр хөлс та нарын эсрэг хашхирч байна. Ургацыг чинь хураасан хүмүүсийн хашхираан Түмэн цэргийн Эзэний сонорт хүрчээ. Та нар дэлхий дээр баян тансаг амьдарч, дураараа авирлах амьдралд хөтлөгдөв. Нядалгааны өдөр та нар зүрхээ бордсон байна. Та нар зөвт хүнийг яллаж, алав. Тэр та нарыг эсэргүүцдэггүй” (Иаков 5:1-6).

Уг ишлэлүүдэд Бурханы Сүнс эд баялаг хураахын эсрэг (3-р ишлэл), шударга хөдөлмөрийн хөлсөнд өгөх мөнгийг шударга бусаар олохын эсрэг (4-р ишлэл), баян тансаг амьдралын эсрэг (5-р ишлэл), эсэргүүцэл үзүүлж

чадахгүй гэм зэмгүй хүмүүсийг буруугаар ашиглахгүй байхын эсрэг (6-р ишлэл) хаширчээ. Эдгээр ишлэлүүд итгэгч болон итгэгч биш хүмүүсийн алинд зориулагдсан талаар маргаад ч нэмэргүй.

“Яагаад гэвэл чи ”Би баян. Баяжсан тул дутах зүйл ер байхгүй” гэдэг. Чи өөрийнхөө хөөрхийлөлтэй, өрөвдмөөр, ядуу, сохор, нүцгэн байгааг мэдэхгүй байна. Баян болохын тулд галд цэвэршүүлсэн алт, өөрийгөө хувцаслахын тулд болон нүцгэн байдлын чинь ичгүүр ил болчихгүйн тулд цагаан хувцас, харахын тулд нүдээ тослох нүдний тосыг Надаас худалдан ав гэж Би чамд зөвлөө. Би хайрладаг хүмүүсээ зэмлэдэг, сахилгажуулдаг юм. Тиймээс зүтгэлтэй бай, гэмш” (Илчлэлт 3:17-19).

Лаодикийн чуулганд хандаж хэлсэн энэ ширүүн үгс чуулгануудад хандсан Эзэний үгсийн төгсгөлийнх юм. Үүнд ямар нэгэн тайлбар хэрэггүй биз ээ. Ямар утгатай үгс болохыг бид мэднэ. Бас бидэнд хамаатай гэдгийг ч мэднэ. Бид зөвхөн үүнийг дуулгавартай дагах л хэрэгтэй.

ЗАЛХУУРЛЫН ЭСРЭГ СЭРЭМЖЛҮҮЛЭГ!

Энэ мэт номыг ажил хөдөлмөр эрхлэхгүй байх шалтаг болгон ашиглах аюул их гардаг. Хөдөлмөрлөх дургүй хүн үүнийг уншаад “Би үргэлж л ингэж боддог байсан” гэж хэлэх байх.

Тэгвэл энд бичигдсэн үгс залхуу хойрго буюу энэ дэлхий (эсвэл сүм чуулган) тэднийг тэжээх ёстой гэж боддог хүмүүст зориулагдаагүй юм шүү. “Залхуу минь чи хэдий болтол хэвтэх вэ?” (2 Тессалоник 3:6-12-ыг үз) гэх мэт ийм хүмүүст зориулж хэлэх өөр үг Бурханд олон бий:

Энэ ном ажилч хичээнүй, ул суурьтай, хөдөлмөрч хүмүүст зориулагдсан. Гэр бүлийнхээ өнөөгийн хэрэгцээг хичээнгүйлэн хангадаг, Эзэн Есүсийн ашиг сонирхлыг эн тэргүүнд тавьж түүний төлөө амьдардаг хүмүүс ирээдүйгээ Бурханд итгэн даатгаж чаддаг.

БУСДЫГ ШҮҮХИЙН ЭСРЭГ СЭРЭМЖЛҮҮЛЭГ!

Зайлсхийвэл зохих өөр бас нэг аюул бий. Энэ бол материаллаг эд хөрөнгөтэй хүмүүсийг яллан буруутгах аюул юм. Бид бусдыг шүүмжлэх буюу Эзэнд хир үнэнч байгааг шүүн хэлэлцэх ёсгүй.

Эд баялагийн тухай Бурханы Үгэнд заасан зарчмыг зарлан тунхаглах нэг хэрэг. Харин итгэгч хүмүүсийн гэр орноор явж эд хогшлыг нь оюун ухаандаа бүртгэж аваад гараараа чичлэх өөр хэрэг. Итгэгч бид бүгдээрээ Бурханы хэлэх үгийг сонсоод амьдралдаа хэрэгжүүлэх үүрэгтэй. Өнөр өтгөн гэр бүлийн өнөөгийн хэрэгцээ ганц бие хүнийхээс их байх нь мэдээж.

Бид нэг нэгэндээ Эзэний тушаалыг ямар үнээр яаж дагахыг хэлэх ёсгүй. Бурханы нярвын хувьд итгэгч хүн бүр бусдын төлөө биш харин өөрсдийнхөө төлөө Бурханы өмнө хариуцлага хүлээдэг. Тиймээс Эзэн биднийг бусдад хатуу ширүүн, шүүмжлэлтэй, буруушаасан байдлаар хандах хадлагаас чөлөөлөх болтугай!

ДУГНЭЛТ

Итгэгч хүмүүс идэх хоол, өмсөх хувцас, амьдрах орон байрандаа сэтгэл хангалуун байж, гэр бүлийнхээ өнөөгийн хэрэгцээг хангахын тулд хичээнгүй хөдөлмөрлөж, хэрэгцээнээс илүү гарсан бүхнээ Бурханы үйлсэд зориулдаг байх ёстой гэдэг нь Бурханы Үгнээс тод харагдаж байх мэт. Итгэгч хүмүүс ирээдүйнхээ аюулгүй байдлыг хангах гэж хичээлгүй Эзэнд найдах ёстой. Эзэн Есүс Христэд үйлчлэх нь тэдний амьдралын гол зорилго бөгөөд өөр бусад бүх зүйл үүнд захирагдах ёстой.

Энэ бол Сайн мэдээний номуудад заасан, Үйлс номд хэрэгжсэн, захидлын номуудад нарийн тайлбарлагдсан амьдрал юм. Үүний гол үлгэр дуурайл нь Эзэн Есүс Христ Өөрөө билээ. Тэгвэл “Би үүнийг яаж өөрийн амьдралд хэрэгжүүлэх вэ?” гэсэн асуулт гарч ирнэ.

Эхлээд өөрийгөө Эзэнд өргө (2 Коринт 8:5). Хэрэв бид Эзэнийх болбол эд хөрөнгө маань ч Түүнийх болно.

Дараа нь Эзэн бидний амьдралын өөр бусад хэсгүүдийг авахыг хүсэх болно. Тэр үед нь бид даруй хариулах ёстой Үнэтэй ресторанд хоол идэх үед, эсвэл спортын үнэтэй хэрэглэлүүдэд мөнгө зарах авах үед сэтгэл тавгүйрхэх байдлыг бий болгож болно. Өндөр үнэтэй, сүүлийн үеийн загвартай машин авахаар хайх үед Эзэн арай хямд үнээр даруухан машин олж авах боломжийг харуулж зөрүү мөнгийг сайн мэдээ тараахад зориулах хүслийг төрүүлж бас болно. Олон хүнийг Бурханы зөвт байдлаар хувцаслуулахын тулд хувцасны шүүгээндээ өөрчлөлт хийхийг ч сануулж болох юм. Бас Эзэнд үйлчлэх цаг гаргуулахын тулд арай бага цагаар ажиллах ажлаар ажлаа солих хэрэгтэй ч болж болно. Үнэ өртөг ихтэй байшинд дурлахаа больж түүнийг жижгэвтэр даруухан байраар сольж болно.

Бурхан энэ талаар бидэнтэй ярьж эхлэх үед бид юу хүсэж байгааг нь тодорхой мэдэх ба үүнээс татгалзах нь дуулгаваргүй байгаагийн шинж гэдгийг бид өөрсдөө сайн ойлгож мэдэх болно.

Гуравдугаарт, “*Тэр та нарт юу гэж айлдана, түүнийг нь хий*” (Иохан 2:5). Найз нөхөд тань таныг буруугаар ойлгож, хамаатнууд тань зэмлэж мэднэ. Бас хүчтэй эсэрүүцэлтэй ч тулгарч болно. Харин та зөвхөн Есүсийг дагаж үр дагаврыг нь Түүнд үлдээгээрэй.

Хэрэгцээнээс илүү гарсан бүхнээ Бурханы үйлсэд зориул. Бурханаас удирдан чиглүүлж өгөхийг, хаашаа хэн рүү илгээх ёстойг харуулж өгөхийг гуй. Тэр харуулж өгөх болно. Итгэгч хүмүүсийн ийм үнэнч зүтгэл эргээд бидний болон энэ үеийн хүмүүсийн амьдралд хэрхэн нөлөөлөхийг Эзэн бидэнд харуулах болтугай. Жон Уэсли ийн залбирдаг байсан:

Эзэн Бурхан минь, миний чин сэтгэлийн их хүслийг Та биелүүлж өгөөч! Энэ дэлхийгээс явж Тан дээр очихын өмнө Бурхан Танд өөрсдийгөө үнэнчээр бүрэн зориулсан, газар дэлхийн хувьд үхмэл, газар дэлхий ч тэдний хувьд үхмэл, Бурхан Танд өөрийн бие сэтгэл байгаа бүхнээ өгсөн тийм хүмүүсийг аль болох олныг харахыг хүсэж байна! Тэгвэл би хичнээн их баяр хөөртэйгөөр “Таны өчүүхэн зарц би одоо л амар тайвнаар эндээс салан одож чадахаар боллоо” хэмээн хэлэх болно.

Хорьдугаар бүлэг

БУРХАН НОМХОРСОН ЗҮРХИЙГ ИЛҮҮ ҮНЭЛДЭГ

Эцэгийн гарыг эсэргүүцэн тэмцдэггүй, номхорсон сүнс бол үр бүтээлтэй ажиллаж хувиргаж болох сайн материал юм. Эзэн биднээс хүч чадлыг биш харин номхон даруу байдлыг, Өөрийг нь эсэргүүцэх их хүчийг биш харин бууж өгөх байдлыг хайдаг. Бүх хүч чадал Түүнийх. Түүний хүч сул дорой байдалд төгс болдог – нэр нь үл мэдэгдэх зохиолч.

Андрью Маррэй “Христийн дотор бай” гарчигтай номоо бичсэнээс хойш гучин жилийн дараа “Бурханы үйлчлэгч буюу итгэгч зохиолч нар өөрийн амсаж мэдсэн зүйлээс илүү ихийг бичих хандлагатай байдгийг та бүхэн мэдээсэй гэж би хүсэж байна. Би “Христийн дотор бай” гэсэн номоо бичиж байхдаа тэнд бичигдсэн бүхнийг өөрөө амсаж туулаагүй бөгөөд одоо ч гэсэн бүгдийг бүрэн өөрийн биеэр амсаж туулсан гэж хэлж чадахгүй” гэж байжээ.

Элч Паул мөн ийм сэтгэглээр *“Би хэдийн хүлээн авсан юм уу, эсвэл хэдийн төгс болчихсондоо биш, харин би бас Христ Есүст юуны төлөө баригдсан, түүнийг барьж авахын тулд урагшилдаг”* (филиппой 3:12) хэмээн бичсэн байдаг..

Энэхүү номын “Эзэн минь намайг номхоруулаач” гэсэн гарчигтай дараагийн бүлгийн тухайд би бас ингэж хэлэх байна. Уг бүлэгт бичигдсэн бүхнийг Эзэн намайг шахаж бичүүлсэн. Тэнд бичигдсэн зүйлсийг би өөрийн биеэр амсаагүй гээд орхиж үл болох дэндүү чухал, дэндүү агуу дээд зүйл юм.

Хорин нэгдүгээр бүлэг

БУРХАН БИДНИЙГ НОМХОРСОН ЗҮРХТЭЙ БАЙХЫГ ХҮСДЭГ

Ер нь бол ямар нэг зүйл эвдэрч хэмхрэхэд үнэ цэнээ алдах буюу хаягдаж алга болдог. Аяга таваг, лонх толь зэрэг бүтээгдэхүүнүүд хагарах үед олон хэсэг болон бутардаг. Тэр ч бүү хэл зурагдсан тавилга, урагдаж цоорсон хувцсыг зарж борлуулахад үнэ нь хэд дахин буурдаг. Харин сүнслэг ертөнц үүнээс өөр ажээ. Бурхан эвдэрч хэмхэрсэн зүйлийг буюу нэн ялангуяа номхорч зөөлөрсөн хүмүүсийг илүү үнэлж эн тэргүүнд тавьдаг. Тиймээс *“ЭЗЭН эмтэрсэн зүрхтэй хүнд ойртон байдаг бөгөөд Сүнсээрээ гэмшигчдийг авардаг”* (Дуулал 34:18). *“Бурханд өргөх тахил бол эмтэрсэн сүнс юм. Бурхан, эмтэрсэн, гэмшдэг зүрхийг Та жигшихгүй”* (Дуулал 51:17) гэсэн ишлэлүүд Библид олон байдаг ажээ. Бардам зантай, ихэмсэг хүмүүсийг яаж сөрөхөө Бурхан мэддэг боловч төлөв даруу, гэмшсэн хүмүүсийг сөрж чадахгүй (Иаков 4:6). Бурханы энэрэх сэтгэл ба хүч чадлыг хөдөлгөдөг ямар нэг зүйл номхорсон сэтгэлд байдаг аж. Тиймээс Бурхан биднийг номхорсон зүрхтэй тэр ч байтугай эвдэрсэн биетэй байлгахыг хүсдэг нь бидний амьдралд зориулсан Түүний гайхамшигт зорилгуудын нэг юм. (2 Коринт 4:6-18).

Итгэгч болох: Номхорсон сэтгэлийн нэг хэлбэр

Бид итгэгч болохоосоо өмнө буюу Ариун Сүнс бидэнд гэм нүглийг маань ойлгуулж эхлэх тэр үед номхорсон сэтгэлийн эхний үйл явцтай танилцаж эхэлдэг. Ариун Сүнс биднийг өөрсдийгөө төөрч будилсан, ашиг тусгүй, зөвхөн тамд очих зохистой хүн мөн гэдийг хүлээн зөвшөөрөх байдалд хүргэх аж. Бид алхам тутамдаа эсэргүүцэн тэмцдэг боловч Тэрээр бардам зан маань дарагдаж, онгиороо хэл яриа маань намдаж, эсэргүүцэх хүч тэнхээгүй болох хүртэл бидэнтэй тэмцэлдсээр байх ажээ. Эцэст нь Эзэний хөлд сөгдөн унасан бид *“Эзэн Есүс минь намайг авраач”* хэмээн шивнэдэг. Ингэж зэрлэг адуу номхордог

Зэрлэг адуу гэдэг Байгалаасаа юунд ч захирагдахгүй догшин омголон амьтан. Түүнд эмээл хазаар ойртуулахад л үргэж, үсэрч цовхчин, тангаран өшиглөж зугтан одно. Зэрлэг адуу үзэсгэлэнтэй, хангал сайхан биетэй боловч номхруулахаас нааш эдэлж хэрэглэж болохгүй ашиг тусгүй амьтан юм. Түүнийг эмээл хазааранд дуулгавартай захирагддаг болгохын тулд омголон занг нь дарах урт удаан хугацааны зовиур ихтэй номхруулах үйл явц үргэлжилнэ. Эцэст нь номхорч, өөрийн биш өндөр дээд хүсэлд захирагддаг болох үедээ оршин буйн жинхэнэ утга учраа олдог аж.

Үүнтэй холбогдуулан Эзэн Есүс Назар хотын мужаан байсан гэдгийг санах нь чухал бөгөөд мужаан байсан Тэрээр модон буулга хийдэг байсан болов уу гэж боддог. Хэрэв Түүний урлангийн хаалган дээр хаяг бичих хэрэгтэй болбол *“Миний буулга юунд ч сайн таарна”* гэсэн хаягтай байх байсан биз ээ гэж нэг хүн яруу сайхнаар хэлсэн байдаг. Гэвч үүнээс бид Эзэн Өөрөө бидний буулга болсоор байгаа гэдгийг ойлгох нь чухал. Тэрээр

“Буулгыг минь өөр дээрээ авч, Надаас суралц. Учир нь Би зүрх сэтгэлдээ дөлгөөн, даруу билээ. Тэгээд та нар сэтгэлдээ амралтыг олох болно. Миний буулга амархан, Миний ачаа хөнгөн” (Матай 11:29-30) гэсэн

Буулга гэдэг зөвхөн номхон, дуулгавартай амьтанд зориулагдсан зүйл. Тиймээс бид Түүний буулганд орохоос өмнө өөрийн хүслийг орхиж сурах ёстой. Есүс зүрх сэтгэлдээ номхон даруу байсан. Бид Түүн шиг болох ёстой. Ингэснээр зүрх сэтгэлдээ амар тайвныг олох болно.

Номхорсон байдлын гол элемент

Гэвч “Жинхэнэ ёсоор номхорсон зүрх сэтгэл ямар байх вэ?”, “Итгэгч хүний амьдралаас яаж харагдах вэ?”, “Үндсэн ямар элементээс бүрддэг вэ?” гэсэн асуултууд гарч ирнэ.

Гэмших, хэргээ хүлээх, уучлал гуйх: Бурханы өмнө болон гомдоосон хүмүүсийнхээ өмнө гэм буруугаа гэмшин хүлээхэд бэлэн байх нь хамгийн эхлээд хийх ёстой зүйл болов уу. Номхорсон зүрх сэтгэлтэй хүн гэмшихдээ хурдан байх агаад гэм нүглээ далдлах гэж хичээдэггүй. “Цаг хугацаа бүхнийг эмчилнэ” гэсэн шалтгаанаар бүхнийг мартаж орхихыг хичээхгүй. Харин Бурханы өмнө яаран очиж “Би гэм нүгэл хийчихлээ” хэмээн дуу алдаж өөрийнх нь хийсэн үйлдлийн улмаас гомдож эмзэглэсэн хүмүүс дээр очиж “Миний буруу. Би үнэхээр харамсаж байна. Намайг уучлаарай” гэж хэлдэг. Ийм хүн нэг талаас уучлал гуйхын ичгэвтэр байдал ямар байдгийг мэддэг ч нөгөө талаас сэтгэлийн сэвээ арилгаж гэрэл дотор амьдрахын сайхныг мэдэрдэг.

Хийсэн гэм нүглээ чин сэтгэлээсээ гэмшин хүлээх нь тухайн хэргийн чанарыг өөрчилж, учруулах хохирлыг багасгахгүй. Энэ бол өөрийгөө бүх тал дээр зөв гэж боддог ихэмсэг эмэгтэйн “Хэрэв би ямар нэг буруу зүйл хийсэн бол уучлуулахад бэлэн байна” гэж хэлэхтэй адилгүй юм. Харин жинхэнэ гэмшил “Би буруу зүйл хийжээ. Тийм болохоор уучлал гуйхаар ирлээ” гэдэг.

Давид хааны амьдрал гэм нүгэл, уналт бууралтаар булингартаж байсан ч чин сэтгэлийнх нь гэмшил түүнийг Бурханы хайрыг татсан хүн болгосон юм. Дуулал 32, 51-р бүлгүүдээс түүний алдаа дутагдал, гэм нүгэл, хууль бус явдлуудыг харж болно. Түүнийг гэм нүгэлдээ гэмшихээс татгалзах үед махан бие, оюун ухаан, сүнс сэтгэлээрээ хэрхэн зовж амьдрал нь хичнээн зовиуртай хэцүү болж байсныг бид Дуулал номын эдгээр бүлгүүдээс хардаг. Зөв юм гэж ганц ч байхгүй, бүх зүйл буруугаар эргэж байх мэт ажээ. Эцэст нь тэр номхорч гэм нүглээ гэмшин хүлээхэд Бурхан түүнийг уучилж байна. Энэ үед бүх юм хэвэндээ орж Давид дуугаа дахин дуулж чадахаар болсон байдаг.

Шинэ Гэрээнд элч Паул номхон зөөлөн байдлын жишээг харуулдаг. Энэ явдал түүнийг Иерусалим хотод тахилчид болон Зөвлөлийн өмнө байцаагдахаар очих үед болжээ. Тэрээр өөрийгөө үргэлж цэвэр мөс чанартай амьдарч ирсэн тухай ярьж эхлэхэд ихэд уурласан ахлах тахилч хоригдол Паулын ам руу алгадахыг тушаажээ.

Паул хариуд нь *“Цагаанаар будагдсан хана чамайг Бурхан цохино*

доо! Чи намайг Хуулийн дагуу шүүх гэж сууж буй атлаа намайг занчихыг тушааснаараа Хуулийг зөрчиж байгаа хэрэг биш үү?” (Үйлс 23:3) хэмээн гэнэт хатуу хэлэв.

Түүний энэ хорон зэмлэлийг сонссон хүмүүс гайхан балмагдав. Паул ахлах тахилчтай ярьж байна гэдгээ мэдээгүй юм болов уу? Ер нь бол мэдээгүй аж. Ананиас албаны хувцсаа өмсөөгүй эсвэл зохих суудалдаа суугаагүй байсан байх. Эсвэл дахиад л түүний нүд муу хардгаас болсон байж болно. Юутай ч тэрээр албан ёсоор томилогдсон удирдагчийн эсрэг муу зүйлийг санаатай хэлээгүй ажээ. Тиймээс хэлсэн үгнийхээ төлөө даруй уучлал эрээд Египетээс гарсан нь номын 22:28 –ийг иш татан “Бурханыг бүү хараа. Өөрийн ард түмний захирагчийг бүү хараа” гэжээ. Элч Паул “Уучлаарай, миний буруу” гэж хэлэхэд бэлэн байгаа байдлаараа сүнсээр хэрхэн өсөж төлөвшсөнөө харуулсан юм.

Нөхөн төлбөр: Номхорсон зүрх сэтгэлийн эхний энэ талтай нягт холбоотой дараагийн зүйл бол шаардлагатай үед даруй барагдуулах нөхөн төлбөр юм. Хэрэв би муу зан авир гаргаж ямар нэг зүйл хулгайлсан, сүйтгэсэн эсвэл гэмтээсэн бол зүгээр нэг уучлал гуйх нь хангалтгүй. Хохирлыг барагдуулах нь шударга ёсонд нийцнэ. Иймэрхүү явдал надад итгэгч болохоос минь өмнө мөн дараа нь ч тохиолдож байсан.

Татвар хураагч байсан Захкай Эзэн Есүсийг хүлээн авсныхаа дараа татвар хураагчийн хувьд хийж байсан зарим нэг буруу үйлдлүүдээ эргэн санажээ. Үйлдсэн буруу хэргээ даруй засаж залруулахыг түүнд зөвлөсөн зүйл бол тэнгэрлэг зөн билэг байсан юм. Тиймээс тэр Эзэнд хандан “Хэрэв би хэн нэгнээс залилан авсан байвал, түүнийгээ дөрөв дахин нугалж эргүүлэн өгнө” (Лук 19:7-9) гэжээ. Энд хэрэглэгдсэн хэрэв гэдэг үг эргэлзээ юм уу шийдмэг бус байдлыг илэрхийлээгүй ажээ. Харин “хэн нэгнийг ямар нэгэн байдлаар хуурч мэхэлсэн болгоноо дөрөв нугалж төлөх болно” гэсэн санаа юм. Тэрээр Есүст итгэсэн итгэлийнхээ улмаас хохирлыг тийнхүү нөхөн төлөх болсон байлаа. “Дөрөв нугалсан төлбөр” бол түүний шинэ амьдралын эрч хүч байсан юм.

Хохирлыг барагдуулах боломжгүй нөхцөл байдал гэж бас бий. Цагийн явцад мартагдсан эсвэл тодорхой тоо хэмжээ нь мэдэгдэхгүй байж болно. Бурхан энэ бүхнийг нарийн сайн мэдэж байгаа бөгөөд чадахынхаа хирээр өрөө буцаан төлөхийг биднээс хүсдэг.

Үүнийг бид үргэлж Эзэн Есүсийн нэрээр хийх ёстой. Хэрэв бид “Би үүнийг сэм авчихсан юм. Уучлаарай. Одоо харин буцаан төлж байна” гэж хэлбэл Бурхан огт алдаршихгүй. Иймэрхүү үйлдлүүд “Би саяхнаас Эзэн Есүс Христэд итгэх итгэлээр дамжуулан итгэгч болсон юм. Танайхаас таван жилийн өмнө миний сэм авсан зүйлийг Эзэн надад сануулсаар байсан. Тиймээс уучлал гуйгаад авсан зүйлээ буцаан өгөхөөр ирлээ” гэх мэт Христийг гэрчлэх гэрчлэлтэй нягт холбогдох ёстой. Итгэгч хүн өөрийгөө биш харин Эзэн Есүсийг алдаршуулахын тулд өөрийн хийсэн зөв буюу сайхан сэтгэлийн үйлдэл бүрийг Аврагчийг гэрчлэх гэрчлэлтэй холбох хэрэгтэй байдаг.

Уучлах сэтгэл: Номхорсон зүрх сэтгэлийн гурав дахь элемент бол хэн нэгэн бидний эсрэг буруу зүйл хийхэд түүнийг уучлахад бэлэн байх сэтгэл юм. Ихэнх тохиолдолд энэ нь уучлал гуйх, нөхөн төлбөр хийхтэй адил их хэмжээний нигүүслийг шаарддаг. Шинэ Гэрээнд бусдыг уучлахтай холбоотой заавар зөвлөгөөг гайхалтай тодорхой гарган тавьсан аж.

Юуны өмнө, хэн нэг нь бидний эсрэг буруу зүйл хийх үед бид түүнийг зүрх сэтгэлдээ тэр даруй уучлах ёстой (Эфэс 4:32). Бид мэдээж тухайн хүн дээр очиж чамайг уучиллаа хэмээн хэлэхгүй ч зүрх сэтгэлдээ түүнийг уучилдаг.

Хэн нэг нь миний эсрэг буруу зүйл хийх тэр үед би түүнийг уучлах ёстой. Тэгвэл сэтгэл маань чөлөөлөгдөнө. Харин түүний эсрэг муу санасаар байвал энэ нь Бурханы эсрэг болон түүний эсрэг хийх гэм нүгэл болж уучлалын тал дээр Бурханы өмнө хэцүү байдалд ороход хүргэнэ. Тухайн хүн хийсэн зүйлдээ гэмшиж, засаж залруулан уучлал гуйх эсэх нь хамаагүй. Би түүнийг даруй уучлах ёстой. Тэр хүн хийсэн буруу зүйлийнхээ төлөө өөрөө Бурхантай нүүр тулах ба энэ бол минийх биш Бурхан тэр хоёрын хэрэг юм. Түүнд харин Матай 18:15-д бичигдсэний дагуу хандах ёстой. Энэ нь амжилт олсон ч эс олсон ч үүнийг хийхээсээ өмнө би түүнийг уучилсан байх ёстой.

Даруй уучилж, амархан мартагддаг жижиг буруу хэргүүд олон байдаг. Ингэж чадвал бид жинхэнэ ялалт байгуулж чадна. *“Хайр...бүгдийг далдалдаг, бүгдэд итгэдэг, бүгдэд найддаг, бүгдийг тэсвэрлэдэг.”* (1 Коринт 13:7). Америкийн улаан загалмай нийгэмлэгийг үүсгэн байгуулагч Клара Бартоноос нэг удаа “Тэр нэг эмэгтэйн танд хэлсэн тэр хачин үгийг та санахгүй байна уу?” хэмээн асуухад тэрээр “Зүгээр нэг санахгүй байгаа ч юм биш санахгүй байхаар шийдсэнээ сайн санаж байна” гэсэн гэдэг.

Хэрэв таны эсрэг хэн нэгний хийсэн буруу зүйл үнэхээр ноцтой бөгөөд зүгээр өнгөрөөх нь зүйд нийцэхгүй гэж үзвэл тухайн хүн дээр очоод энэ тухай ярих хэрэгтэй (Матай 18:15). Хэрэв тэр хийсэн зүйлдээ харамсан гэмшвэл түүнийг уучил. *“Хэрэв тэр чиний эсрэг өдөрт долоон удаа нүгэл үйлдчихээд, чам уруу долоон удаа эргэж ирж, “Би гэмшиж байна” гэвэл, түүнийг уучил”* (Лук 17:4). Бид нэг мөсөн уучлахад бэлэн байх нь зөвөөр зогсохгүй чухал зүйл юм. Тэгээд ч бид өөрсдөө тоолохын аргагүй олон удаа уучлуулж байсан, байгаа билээ.

Буруу зүйл хийсэн хүний тухай хаа сайгүй ярьж явах ёсгүй гэдгийг анхаарах нь чухал (бид заавал ингэх хандлагатай байдаг). *“Түүн дээр очоод хийсэн буруу хэрийнх нь талаар зөвхөн өөр хоорондоо ярилц”*. Энэ хоёр ялгааг аль болох хязгаарлан барих хэрэгтэй.

Буруу зүйл хийсэн хүн хэргээ гэмшин хүлээмэгц уучилсан гэдгээ хэлэх нь зүйтэй. Та түүнийг зүрх сэтгэлдээ хэдийнээ уучилсан боловч одоо уучилсан гэдгээ дамжуулан хэлж байгаа нь энэ.

Гэвч тэр буруу хэргээ гэмшин хүлээхээс татгалзлаа гэж бодъё. Тэгвэл Матай 18:16-д заасны дагуу *“өөртэйгөө хамт нэг юмуу хоёр ах дүүгээ дагуул. Тэгвэл хоёр буюу гурван гэрчийн амаар хэрэг нь бүрэн нотлогдох болно”*.

Хэрэв тэр хоёр ба гурван гэрчийн үгийг сонсохоос татгалзвал хэргийг

өөрийн сүм чуулганы нөхөрлөлд аваачих ёстой. Үүний гол зорилго нь бурууг үйлдсэн хүнийг залхаан шийтгэхэд биш харин ухааруулан ойлгуулж сэргээн босгоход оршино.

Хэрэв эцсийн энэ оролдлого бүтэлгүйтвэл түүнийг харь үндэстэн буюу татвар хураагчийн ёсоор үзэх ёстой. Өөрөөр хэлбэл түүнд өөрийн сүм чуулганы итгэгч нөхрийн ёсоор хандахаа болино гэсэн үг. Нэгэнт итгэгч хүний хийх ёстой зүйлийг хийхгүй байгаа учир тэр янзаар нь хүлээн авч хандах учиртай ажээ. Түүнийг итгэгч биш хүн хэмээн тооцож болно. Гэвч түүнийг гэмшсэн даруй уучилж нөхөрлөлийг сэргээх ёстой.

Бурхан үл уучлах сэтгэл, үхэн үхтлээ өш санах, өнгөрснийг өнгөрсөнд нь орхихгүй байх явдлуудыг үл тэвчдэг ажээ. Энэ санааг авлагатай зарцын тухай сургаалт зүйрлэлд (Матай 18:23-35) нэн хүчтэй гарган тавьсан байдаг. Дампууралд орсон түүний мянган долларын өрийг хаан уучлан хэлтрүүлсэн байлаа. Гэсэн атал тэрээр зарц анд нөхрийнхөө цөөхөн хэдэн долларын өрийг уучлах хүсэлгүй байв. Үүнээс сурах зүйл зүйл тодорхой аж. Бурхан биднийг толгой давсан их өрнөөс минь чөлөөлж уучилсан тул бид өөрсдөд маань жижиг өртэй хүмүүсийг хэлтрүүлж уучлах ёстой ажээ.

Бурууг хариу авалгүй уучлан өнгөрөөх: Гэвч номхорсон зүрх сэтгэлд өөр талууд гэж бас бий. Үүний нэг нь зөв зүйл хийснийхээ төлөө хариу авалгүй зовох номхон даруу сэтгэл юм. Үүний гол үлгэр дуурайл мэдээж бидний Эзэн Өөрөө билээ: *“Тэр зүхээгдэж байхдаа, хариуд нь зүхээгүй. Тэр зовон тарчилж байхдаа заналхийлээгүй, харин шударгаар шүүдэг Нэгэнд Өөрийгөө даатгасаар байлаа”* (1 Петр 2:23). Итгэгч бид бүгд ийм маягаар амьдрахаар дуудагдсан хүмүүс.

“Боолчууд аа, бүхий л хүндлэлээр зөвхөн сайн, дөлгөөн төдийгүй, бас шударга бус авирлагч эздэдээ ч захирагд. Учир нь хэрэв хүн шударга бусаар зовохдоо Бурханд ханддаг мөс чанараасаа болж тэвчвэл энэ нь тааллыг олдог. Хэрэв та нар нүгэл үйлдээд ширүүн нударгад өртөхдөө тэвчлээ ч, үүнд ямар гавъяа байх билээ? Харин хэрэв та нар зөвийг үйлдээд зовохдоо, үүнийг хүлцэн тэвчвэл, энэ нь Бурханы тааллыг олдог” (1 Петр 2:19-20).

Мердок Кэмбелл өөрийн бичсэн *“Нигүүлсээс суу алдар хүртэл”* номонд Жон Уисли амьдралыг нь гал мэт сорьсон эхнэртэй байсан тухай өгүүлсэн байдаг. Эхнэр нь түүний үснээс зулгааж хэдэн цагаар өрөөн дундуур чирж байсан удаатай. Гэвч Методист чуулганыг үндэслэгч маань эхнэртээ ганц ч ширүүн үг хэлээгүй гэдэг. Кэмбелл цааш нь ийн бичжээ.

Хайландийн бурханлаг энэ итгэгч нутгийнхаа эмэгтэйтэй гэрлэсэн байлаа. Нэг өдөр тэрээр өрөөндөө суугаад Библээ уншиж байв. Гэтэл хаалга онгойж эхнэр нь орж ирээд гараас нь Библийг нь угз татан авч гал руу шиджээ. Уисли эхнэрийнхээ нүүр рүү хараад намуун дуугаар *“Ийм их илчтэй галын дэргэд сууж байгаагүй юм байна”* гэв. Түүний энэ үг эхнэрийнх нь уурыг эргүүлж нигүүлсээр дүүрэн шинэ амьдралынх нь эхийг тавьсан юм. Ингэж түүний Изебел Лидиа болж өргөс сараана цэцэг болсон юм.

Бурханы нэг агуу итгэгч хүн ийн хэлсэн байдаг:

Ямар ч шалтгаангүйгээр буруутгагдавч чимээгүй байх нь дээд зэргийн, жинхэнэ даруу төлөв байдлын шинж. Доромжлогдон гутаагдсан ч чимээгүй байна гэдэг Эзэний үлгэр жишээг даган дуурайж буйн агуу дээд илрэл юм. “Өө Эзэн минь Та зовлон үүрэх зохисгүй боловч хичнээн их зовсныг тань би мэддэг боловч өөрийгөө яаран өмгөөлж шалтаг тоочихдоо энэ бүхнийг мартаж орхих юм. Таны эсрэг хүмүүс олон муу юм бодож, олон муу юм хийдэг байхад би өөрийгөө сайнаар яриулж, сайнаар бодуулахыг хүсэж болно гэж үү?”

Мууг сайнаар хариулах: Номхорсон зүрх сэтгэлтэй амьдралын бас нэг чанар бол өөрийнх нь эсрэг үйлдэгдэж буй буруу зүйлийг зүгээр л тэвчих биш харин мууг сайнаар харуулах явдал юм.

“Хэнд ч хэзээ ч бузар мууг бузар муугаар бүү хариул. Бүх хүний өмнө юу нь зөв болохыг л харгалзан үзэж бай.... Хэрэв дайсан чинь өлссөн бол түүнийг хоолло. Хэрэв тэр цангасан бол түүнд уух юм өг. Учир нь чи ингэснээрээ түүний толгой дээр галтай нүүрс овоолж байгаа хэрэг».Бузар муугаар бүү дийл, харин бузар мууг сайнаар дийлэгтүн” (Ром 12:17,20-21).

Энэ талаар бодох бүрдээ би нэг удаа Энэтхэгт хотын гудамжаар нэг хүн заан унаад гудамж уруудан явж байсныг үргэлж эргэн санадаг. Хурц үзүүртэй ган саваа барьсан хүн том биетэй энэ араатныг хатган урагш хөдөлгөж байв. Гэтэл зааны эзэн савааныхаа бариулыг алдаж саваа газар хангинан унав. Зовлон их амссан нөгөө заан эргэж газар унасан савааг хушуугаараа өргөн аваад эзэндээ өглөө. Хэрэв заанууд итгэгч болдог байсан бол энэ заан итгэгч заан байх байсан биз ээ.

Бусдыг өөрөөсөө дээр тавьж хүндлэх: Бусдыг өөрөөсөө дээр хэмээн үзэж үнэлэх нь номхорсон зүрх сэтгэлийн бас нэг хэлбэр юм (Филиппой 2:3). Үүнийг Абрамын амьдралд хэрхэн дүрслэн харуулсныг Эхлэл номын 13:1-13-р ишлэлүүдээс үзэж болно. Лот, Абрам хоёр бүх эд хөрөнгөө аваад гэр бүлийнхэнтэйгээ хамт эхлээд Негер дараа нь Бетел орохоор Египетийн нутгаас гарчээ. Хоёр эр хоёулаа олон тооны мал сүрэгтэй байсан ба удалгүй тэр хоёрын хөлсний малчид бэлчээрээс болж муудалцах болов. Чухам энэ үед Абрам урагш гарч: “Лот, цөөхөн хэдэн өвсөн бухлаас болж би чамтай өстөн дайсан болохыг хүсэхгүй байна. Чи хүссэн бэлчээрээ ав. Би харин малаа өөр газар аваачиж бэлчээ” гэжээ. Тиймээс Лот ёртой юм шиг Содомын ойролцоо Иордон голын хөндийд хамгийн үржил шимтэй өвс ногоо өтгөн ургасан бэлчээрийг сонгов. Харин сайхан сэтгэлтэй Абрам цаашаа Канаан руу нүүжээ. Тиймээс Хуучин Гэрээний ариун хүмүүс “Ах дүүсийн хайраар бие биеэ хайрла. Бие биеэ өөрсдөөсөө дээгүүр дээдлэн хүндэл” (Ром 12:10) хэмээн Паулын хэлсэн үгийн утга санааны бодит илрэл болж байна.

Дуулгавартай байх: Үүгээр ч зогсохгүй Бурхан биднээс Түүний

хүслийг хүлээн авч дуулгавартай дагах тал дээр номхон зөөлөн байхыг хүсдэг. Дуулал номыг бичсэн хүн энэ тухай “Ухаангүй адуу эсвэл луус шиг бүү бол. Тэднийг хазаар ногтоор оосорлон барихгүй бол Та нарт ойртон ирэхгүй” (Дуулал 32:9) гэсэн байдаг.

Омголон морь үргэлж яаран урагш ухасхийдэг бол луус зөрүүд, гөжүүд байдлыг бэлэгддэг. Үүнтэй адилаар Бурханы хүслийг дагах тал дээр итгэгчид хоёр гол алдаа гаргаж болох ба нэг нь тодорхой чиглэл авалгүйгээр яаран хөдлөх нөгөө нь Эзэний удирдлагыг зориуд эсэргүүцэж болзошгүй аж.

Жишээлбэл Иона байна. Бурхан түүгээр юу хийлгэх гэж байсан нь тодорхой байсан. Тэрээр Ниневе хотын хүмүүс дээр очиж гэмшихийг уриалах ёстой байлаа. Гэвч зүрх сэтгэл нь номхорч зөөлрөхгүй л байв. Тиймээс эсрэг чиглэлд явж буй усан онгоцонд суужээ. Түүний хүсэл зориг аварга загасны гэдсэнд аймшигт өдрүүдийг өнгөрүүлсний дараа л нугарч номхорсон юм. Үүний дараа тэрээр Бурханы сайн, тааламжит, төгс төгөлдөр (Ром 12:2) хүсэл юу болохыг батлан тунхаглахаар явсан билээ.

Номхон зөөлөн байдлын гайхалтай дүр зургийг Иерусалим орохдоо Есүсийн унасан илжигний дудрангаас харж болно (Лук 19:29-35). Тэр илжигний дудранг өмнө нь хэн ч унаж байгаагүй тул мордох гэж оролдсон тохиолдолд хүчтэй эсэргүүцэж болох байв. Гэвч Эзэн Есүсийг дөхөн очиход гэнэт гайхалтайгаар номхорчээ. Дудрангийн өөрийнх нь хүсэл Бүтээгч Эзэнийхээ хүсэлд тийнхүү бүрэн захирагдсан аж.

Номхон зөөлөн байдлын тухай энэ яриандаа шаврыг ашиглах нь тийм ч тохиромжгүй мэт санагдаж болно. Ваарчин эзнийхээ гарын аяар дуулгавартай хөдөлж байгаа шавар бол Эзэнийхээ гар хурууны даралтад уян зөөлөн хандан гарынх нь аяар хөдөлж буй номхон зөөлөн хүний сайхан дүр зураг юм.

Номхон даруу итгэгч хүний өдөр тутмын залбирлыг нэг магтан дуунд ийн буулгажээ:

?????? – хуудас 158 – энэ магтан дууг орчуулах уу эсвэл өөр төстэй монгол хэл дээрх магтан дуу олж тавих уу? – орч.

Олон нийтийн санаа бодолд үхмэл мэт байх: Номхон зөөлөн байдалд бас өөр олон талууд бий. Жишээлбэл бид дэлхий ертөнцийн магтаал ба зэмлэлд үхмэл мэт байж чаддаг байх ёстой. У. П. Никольсон Есүст итгэж аврагдсаныхаа дараа Аврах ангийн офицерын удирдлага доор очжээ. Нэг өдөр офицер түүнд “Хэрэв чи Бурханы төлөө ажилладаг бол энэ пайзыг зүүгээд төв талбай дээр хэдэн цаг зогс” гэв. Тэр пайз дээр “ОЛНЫ САНАА БОДОЛД ҮХМЭЛ МЭТ БАЙНА” хэмээн бичсэн байлаа. Энэ явдал Христэд насан турш ямар ч айх айдасгүй үйлчлэхэд түүнд ихээр нөлөөлсөн юм.

Бусдын гэм нүгэлд өөрийнх мэт хандаж гэмших: Бид Бурханы бусад хүмүүсийн гэм нүглийг өөрийнх мэт үзэж гэмшиж чадахаар номхон зөөлөн байх ёстой. Даниел ингэж чаддаг байсан (Даниел 9:3-16). Тэрээр өөрийнхөө жагсаасан гэм нүглүүдийн ихэнхэд нь буруугүй байв. Гэвч Израил

үндэстэнтэй өөрийгөө нягт холбосон тул тэдний гэм нүгэл өөрийнх нь болж байжээ. Түүний энэ жишээ “бидний гэм нүгэл уйтгар гунигийг авч Өөрийнх болгосон” тэр Нэгэнийг сануулж байна. Тиймээс бид итгэгч нөхдөө шүүмжлэн хуруугаараа чичлэхийн оронд тэдний гэм нүглийг өөрийн мэт үзэж гэмших ёстой ажээ.

Аливаа хямралын үед тайван байдлаа хадгалах: Эцэст нь, амьдралын аливаа хямралд хөл алдалгүй тайван байж чадах нь номхон зөөлөн байдлын бас нэг тал юм. Хүлээж байсан зүйл маань аргагүй байдлаар хойшлоход бид өөрийн эрхгүй уурлаж бухимддаг. Тогтсон дэг журам тасалдахад дургүйцдэг. Машин техникийн гэмтэл осол зэрэг нь биднийг амархан гонсойлгож тэр ч байтугай дүрс хийтэл уурлуулдаг. Цагийн хуваарь өөрчлөгдөхөд бид гонсойн гутарсандаа дотор байгаа хамаг муу бүхнээ ил гаргадаг.

Бурхан амьдралын бүх нөхцөл байдлыг Өөрийн зорилгод нийцүүлэн удирдаж чадна гэдгийг мэдсэнээр аливаа хямралын үед тайван байдлаа хадгалж чадах нь номхон зөөлөн байдлын илрэл юм. Машины дугуй хагарах нь замд гарч болох байсан ослоос аварсан их ивээлийн нэг өөр хэлбэр байж болно. Эзэнд үйлчлэх үйлчлэлийг тань тасалдуулсан урилгагүй зочин одоо хийж байгаа зүйлээс тань илүү чухал үйлчлэлийг өгч болно. Гуниг зовлон, эвгүй байдал, их зардал зэргийг дагуулсан осол сайн мэдээг хүлээн авахад Ариун Сүнсний бэлтгэсэн хүмүүстэй уулзуулах завшаан болж болно. Амьдралын энэ бүх нөхцөл байдал дунд Эзэн биднийг тэсвэргүй хандахын оронд тайван байхыг, дургүйцэн сөрөхийн оронд хүлээцтэй байхыг хүсдэг.

Номхон зөөлөн байдал буюу эмтэрсэн зүрх сэтгэлтэй байхын хэд хэдэн жишээг бид үзлээ. Үүн дээр нэмж болох өөр жишээнүүд олон бий. Биднийг Эзэнтэй тогтмол нөхөрлөн харьцах үед амьдралынхаа аль тал дээр Христийн өмнө номхон зөөлрөх ёстойг Тэр харуулж өгөх болно. Ингэж харуулах болгондоо бидэнд шаардагдах нигүүслийг хамт өгөх аж.

“Учир нь Өөрийн сайн тааллын дагуух зүйлсийг үйлдүүлж, хүсүүлэхийн тулд та нарын дотор ажиллаж буй нь Бурхан юм.” (Филиппой 2:13).

Номхон зөөлөн байна гэдэг ямар утгатай БИШ вэ

Ингээд бид номхон зөөлөн байдлын зарим элементийг үзлээ. Харин одоо ямар утгатай биш болохыг товч тайлбарлая. Номхон зөөлөн байна гэдэг сээр нуруугүй, нялцгар, зөөлөн биет амьтан мэт хулчгар байна гэсэн үг биш ээ. Энэ бол ойр орчныхоо хүмүүст ямар ч нөлөөгүй, хүчин мөхөс өчүүхэн хүн болно гэсэн үг биш харин эсрэгээрээ байдаг аж. Номхон зөөлөн байдал бол хүчирхэг зан чанарыг бүрдүүлэгч элементүүдийн хамгийн сайхан нь юм. Номхон зөөлөн биш байхын тулд сахилга баттай байх шаардлагагүй. Хүний төрөлх зан бүхэн эсэргүүцэн тэмцэж байхад Христтэй адил болно гэдэг хичнээн их тэсвэр хатуужил шаардсан хэрэг билээ!

Уйгагүй зан чанартай ихэнх хүмүүс номхон зөөлөн зүрх сэтгэлтэй байдаг. Тэд эсэргүүцэж үл болох их хүчээр сүнслэг ертөнцийн үлгэр жишээг

чимээгүйхэн харуулж, бусдад нөлөөлж байдаг. “Таны дөлгөөн байдал намайг агуу болгодог” (Дуулал 18:35). Номхон зөөлөн зүрх сэтгэлтэй хүмүүс шаардлага гарвал уурлаж чадна. Үүний жишээг Эзэн Есүсийн амьдралаас харж болно. Тэрээр жижиг ташуураар шилбүүрдэн байж мөнгө хүүлэгчдийг сүмээс хөөн гаргаж байсан. Гэвч Түүний уур хилэн өөрийнх нь эрэг хийсэн муу зүйлийн улмаас биш харин Эцэгийнх нь өргөөг гутаасан учир тийнхүү ассан юм. Тэрээр “Бурханы хэрэгт арслан мэт Өөрийн хэрэгт хурга мэт” байсан ажээ. Есүсийн төлөө тамлагдсан, өөрчлөн байгуулагч олон хүн номхон зөөлөн байсан боловч тэднийг сул дорой, нөлөөгүй хүмүүс байсан гэж хэлэхийн аргагүй.

Үе хоорондын ангал

Номхон зөөлөн байдлыг хэрэгжүүлэхэд хамгийн төвөгтэй байдаг зүйл бол эцэг эх хүүхдүүдийн хоорондын харилцаа билээ. Бид хамгийн ойр байгаа хүмүүсээ хайрладаггүй нь хүний мөн чанарын хачирхалтай гэмээр нэгэн зуршил юм. Эхдээ өширхөж хорсдог олон итгэгч охид өөр хоорондоо байнга муудалцдаг агаад эцэгтээ ихэнх тохиолдолд эелдэг хандаж чаддаггүй хөвгүүд олон бий. Үе үеийнхний хооронд оршин байдаг энэ ангалыг хэн ч үгүйсгэдэггүй бөгөөд үнэндээ бол энэ ангал том хэмжээний хавцал болсон байдаг. Залуус эцэг эх нь тэднийг ойлгодоггүй, дарангуйлдаг, хоцрогдсон үзэл бодолтой хэмээн гомдоллох атал өөрсдөө эцэг эхийнхээ ийм хандлагуудаас дээш гарч чадахгүй, итгэгч хүний зан байдлыг тэдэнд харуулж чадахгүй байгаадаа өөрсдийгөө буруутгаж түүнээсээ ичдэг. Тэд үе тэнгийхэндээ тэр ч бүү хэл бусад том хүмүүст эелдэг хандаж сайхан ааш гаргадаг ч гэртээ хүйтэн хөндий, дуугаа хураах нь маш том ялагдал гэдгийг ойлгодог. Тэд хааяа эцэг эхээ үхээсэй гэж боддогтоо дургүй нь хүрдэг ч номхорч, гэм буруугаа хүлээнэ гэдэг тэдний хувьд залгихад бэрх гашуун эм мэт байх аж. .

Бурхан анх Израиль үндэстэнд арван хуулийг өгөхдөө хүн төрөлхтний харьцаа холбооны энэ нарийн, төвөгтэй талд нэгийг нь зориулсан. “Эцэг эхээ хүндэл. Тэгвэл чиний Бурхан ЭЗЭНий чамд өгсөн газар дээр чи урт наслах болно” (Египетээс гарсан нь 20:12)

Паул энэ тушаалыг Шинэ Гэрээнд дахин давтаж “¹Хүүхдүүд ээ, [Эзэн дотор] эцэг эхээ дага. Учир нь энэ бол зөв юм. Эцэг эхээ хүндэл”. Энэ нь амлалт бүхий эхний тушаал бөгөөд Энэ нь чамд сайн бөгөөд чи дэлхий дээр урт наслах болно” гэжээ. Эцгүүд ээ, та нар хүүхдүүдээ бүү уурлуул. Харин тэднийг Эзэний дэг журам болон сургамж дотор хүмүүжүүл” (Ефес 6:1-3) гэжээ.

Эцэг эхээ хүндэлж дуулгавартай байна гэдэг зөвхөн хэлснийг нь хийх биш бас тэднийг хүндэтгэж, эелдэг хандаж, шаардлагатай үед асран халамжлахыг хэлдэг. Ингэх нь дөрвөн учир шалтгаантай бөгөөд Паул ингэх нь нэгд зөв, хоёрт залуусын өөрсдийнх нь сайн сайханд тустай, гуравт Библийн дагуу үйлдэл бөгөөд эцэст нь урт удаан амьдралыг өгнө гэжээ.

Гэвч олон охид хөвгүүд энэ бүхнийг өөр хүмүүс хэрэгжүүлж болох ч өөрсдийнх нь хувьд боломжгүй, яагаад гэвэл эцэг эх нь тэсэхийн аргагүй,,

дэндүү хоцрогдсон хүмүүс гэж өөрсдөдөө итгүүлсэн байдаг.

Энэ бүхэнд номхон зөөлөн байдал шаардагдана. Эцэг эх дээрээ очоод “Та хоёртой харьцах харьцаандаа бодлогогүй хандаж байсандаа харамсаж байна. Миний төлөө хийсэн бүхэнд тань хэзээ ч баярлан талархаж байгаагүй ч одооноос эхлэн талархаж байхыг хүсэж байна. Өөрсдийнхөө хооронд хана хэрэм босгосныг минь уучлаарай. Бурханы тусламжтайгаар цаашдаа энэ бүхнийг өөрчлөхийг хүсэж байна” хэмээн хэлэхэд болохгүй юм үгүй.

Үе үеийнхний хооронд оршин байдаг энэ англыг хэрхэн холбохыг харуулсан нэгэн дүр зураг бий. Энэ бол үрэлгэн хүүгийн тухай түүх юм. Эхлээд, эцгийнхээ үхэхийг хүлээж эс чадсан ачлалгүй энэ хүү өв хөрөнгөө авахыг хүсжээ. Тэгээд хүссэнээ авч түүнийгээ үрэхээр явав.

Үүнийг шөнийн зугаа цэнгэл, архидалт, хөлчүүрэл, садар наргиан дагалдав. Эцэст нь мөнгө дуусаж, найз нөхөдгүй ч болжээ. Үрэлгэн хүү маань амин зуулгагүй үлдэв.

Гэрт нь өөрөөс нь хавьгүй сайн нөхцөлд амьдарч байгаа зарц нарын тухай бодох болов. Ямар мунхаг байгаа вэ! Гэрээсээ өвөр дүүрэн мөнгөтэй гарсан бол одоо гар хоосон буцаж байлаа. Шударга ёсыг шаардсаар гэрээ орхин явсан бол одоо хайр өршөөлийг гуйн буцан иржээ. Орон гэрээ толгой дээгүүр орхиж явсан бол одоо гэр лүүгээ номхорч зөөлөрсөн хүн мөлхөн очиж байв.

Тэрээр “Эцэг минь, Би гэм нүгэл хийжээ. Бурханы эсрэг, таны эсрэг гэм хийжээ. Таны хүү байх зохисгүй хүн” гэв. Өөр олон зүйл хэлж, зарцаар ажилд авахыг гуйхаар зэхэж байсан ч энэ үед эцэг нь гэрийхэндээ хэдийнээ тушаал заавар өгч эхэлсэн байлаа. Ингээд тун удалгүй хүү шинэ хувцас өмсөж, үнэт бөгж зүүж, шинэ гутал өмсөж, тугалын шарсан мах болон өөр олон сайхан амттанаар чимэглэсэн зоогийн тансаг ширээнд суусан байв. Эцэг хүүгийн хооронд үүссэн том англыг номхон зөөлөн байдал тийнхүү холбосон аж. Хэрэв тэр хүү гэмшиж, гэм буруугаа хүлээн зөвшөөрөөгүй бол эцгийнхээ энэ үнсэлтийг хэзээ ч амсахгүй байсан.

Ийм маягаар уучлал гуйж чадах даруу төлөв байдлаас өөр өшөө хорслыг арилгаж чадах зүйл ганц ч байхгүй. Дараагийн удаа эцэгтээ ачлалгүй хандах бүрдээ ичгэвтэрээр номхорч зөөлрөхийн зовлонг эргэн санах ба энэ нь түүнийг тийнхүү үйлдэхээс сэргийлэх хүчин зүйл болон үйлчлэх болно.

Гэрлэлт дэх ангал

Жинхэнэ номхон зөөлөн байдлыг харуулахад төвөгтэй байдаг хоёр дахь зүйл бол эхнэр нөхрийн харьцаа юм. Энд дахиад л бараг танихгүй хүмүүст эелдэг ааш гарган сайхан ханддаг атал ойр байгаа хүндээ эелдэг бус хандах байдал харагддаг. Бид ихэнх тохиолдолд орон гэртээ адсага шиг ааштай гэрээс гадуур ариун гэгээнтэн шиг байдгаа хүлээн зөвшөөрөхөөс өөр аргагүй.

Гэр бүлийн харьцаанд үүсэж болох хурцадмал байдалд Библи бодитоор хандаж Колоссай номын 3:19-д *“Нөхрүүд ээ, эхнэрээ хайрлагтун.*

Тэдэнд бүү хатуу ханд" гэсэн байдаг.

Эхнэртээ гомдсон эр нөхрийн хорсол гомдол заримдаа гүн ул мөр үлдээж цөхрөлд хүргэх агаад ихэнх тохиолдолд эр нөхрүүд зүгээр л шантарч салалтаар асуудлыг шийдэхийг хичээдэг. Үүнийг Жано, Жинкс хоёрын жишээнээс харж болно. Тэд анх нүүр тулан уулзаад л хоёр биедээ зориулагдсанаа мэджээ. Дараагийн саруудад боломж гарах бүрд уулзаж учран цагийг хамт өнгөрөөдөг байв. Ингэж зургаан сар болсны дараа сүй тавиад дахиад зургаан сарын дараа хуримлахаар тогтов. Гэвч сүй тавьснаас хойш дөрвөн сарын дараа гэрлэх хэрэгтэй болжээ.

Хурим хэмээх энэ нэг жижигхэн тоглоомд хүн бүр үүргээ сайн биелүүлж хурим сайхан болж өнгөрөв. Эхний жил амьдрал дажгүй сайхан байлаа. Гэтэл нэг өдөр тэр хоёр маш хүчтэй муудалцжээ. Жинкс гэрлэлтээс өмнө хийсэн зүйлийнх нь төлөө Жаног үл хүндэтгэх болсноо хэлээд дотроо хадгалж байсан бүхнээ ил гаргажээ. Жано ч мөн адил хариу барьж тэд цонх доргитол хэрэлдэн муудалцав. Үүний дараа тэдний гэрлэлт эргэлт буцалтгүй сүйрэх шиг болжээ. Жано гэнэт эхнэртээ хорсох хорсол нь түүнийг хайрлаж байсан хайраас нь илүү хүчтэй байгааг мэдрэв (2 Самуел 13:15).

Найз нөхөд нь тэдэнд гэр бүлийн зөвлөгөө өгөх газарт хандахыг зөвлөхөд тэд ёсоор үйлдэв. Гэвч тэдний сэтгэл нэгэнт хатуурсан байлаа.

Эцэст нь Жано салах өргөдлөө өгчээ. Гэвч тэдний хэргийг шүүхэд дуудахаас өмнө Жаногийн итгэгч нэг найз түүнээс номхон зөөлөн байх арга замыг туршаад үзэхийг гуйжээ. Тэр үед түүний эхнэр ч бас Жинкст энэ аргыг хэрэглэж үзэхийг ятгасан байв. Эзэний өмнө, хоёр биенийхээ өмнө номхон зөөлөрч яагаад болохгүй гэж? Өнгөрсөн бүхнийг Христийн цусаар угааж бүхнийг шинээр эхэлж яагаад болохгүй гэж?

Нөгөө хоёр хэлснээр нь хийв. Энэ нь тэдний хувьд урьд өмнө хийж байгаагүй хамгийн хэцүү зүйл байлаа. Гэвч хос хоёр уулзан ярилцаж хоёр биенийхээ өмнө гэм буруунуудаа гэмшин хүлээжээ. Ямар нэг саад тотгор, өөрийгөө өмгөөлж зөвтгөх байдлууд гарсангүй. Нэг нэгнийхээ өмнө илэн далангүй байж гэмшицгээжээ. Гэрлэхийн өмнө өөр өөрсдийн хийсэн гэм нүглүүдээ хоёул хариуцав. Ингээд Эзэний өмнө нулимс унаган гэм нүглүүдээ гэмшин хүлээгээд дахин тэдгээрийг нэг нэгнийхээ эсрэг сөхөн ярихгүй байхаар тангараглажээ. Тэднийг уучилсан тухай Бурханы амлалтыг (1 Иохан 1:9) тэд хамтдаа нэхэмжиллээ. Хоёр биенийхээ хийсэн бүхнийг баяртайгаар уучлаад бас өөрөө өөрсдийгөө уучлахаар шийдэв. Сөхрөн суусан тэр хоёр энэ бүхний дараа хөл дээрээ өндийн босоход нуруунаас хүнд ачаа авагдах мэт болжээ. Тэр хоёр амьдралд янз бүрийн зохицуулалтууд хийх шаардлага гарсаар байх болно гэдгийг мэдэж байсан ч хорсол ба хэрүүлийн хар үүл сарнин арилсныг ухаарав. Хойшид гэр бүл дотор ямар нэгэн асуудал гарах бүрд байнга номхон зөөлөн байдлаар хандаж байх ёстойг хос хоёр ухаарсан юм.

Үүнээс хойш хэдэн сарын дараа нэг удаа Жано уншиж байсан үдшийн мэдээгээ доош тавингаа номхон зөөлөн байх арга замыг огт туршиж үзэхгүй байж гэрлэлтийн зөвлөгөө өгөх газар сэтгэл зүйч болон өөр бусад өртөг өндөртэй "эмчилгээ"-нд цаг зав, мөнгө төгрөгөө үрдэг хүмүүсийг гайхан

байлаа. Номхон зөөлөн байдалгүйгээр энэ бүгд ч үр дүнгээ өгөхгүй.

Эзэн бидний зөвхөн гэрлэлтэд төдийгүй амьдралын өөр бусад бүх харьцаа холбоонуудад номхон зөөлөн байхыг хүсдэг. Тэрээр Пениел хэмээх газар Иаковтой тэмцэлдсэн шигээ бидэнтэй бас тэмцэлдэх болно. Бидний бардам, дураараа зангууд, үл уучлах сэтгэл, зөрүүд, хов жив ярих, хүний араар муулах зангууд, дэлхийд дурлах байдал, ёс бус зан, түргэн уур болон махан биеийн аливаа үйлсийг нугалан номхоруулахыг хичээдэг. Бидний нэрийг Иаковаас Израиль болгож, хууран мэхлэгчээс хун тайж болгож, хорон мууг сэдэгчээс Бурханы хүчийг олсон хүн болгон өөрчлөхийг хүсдэг. Бурхан нар урган гарах хүртэл бидэнтэй тэмцэж түнхний ясыг маань мултлах болно (Эхлэл 32:31). Үүний дараа бид насан турш Бурханд ашиглагдаж болох номхон зөөлөн зүрх сэтгэлтэй болох аж.

Бурхан биднийг гэм зэмгүй байхыг хүсдэг. Гэм нүгэлгүй хүн гэж ганц ч байхгүй боловч бид гэм зэмгүй байж чадна. Гэм зэмгүй хүн гэж буруу зүйл үйлдмэгц түүнийгээ даруй засаж залруулдаг хүнийг хэлдэг. Ийм хүн уурласан ч нар жаргахаас өмнө уураа арилгадаг агаад гэм нүглээ гэмшин хүлээх, уучлал гуйх замаар Бурхантай болон бусадтай тогтоосон харьцаагаа хадгалж чаддаг. Орон нутгийн чуулганы ахлагчид ийм гэм зэмгүй хүмүүс байх ёстой ч (1 Тимот 3:2) итгэгч хүн бүр бас ийм байх ёстой.

Гарах үр дүн

Хэрэв итгэгч хүн бүр зохих ёсоор номхон зөөлөн байж чадвал энэ нь хувь хүний амьдралд, гэр бүлд, нутгийн чуулганд болон бизнесийн ертөнцөд ямар үр дүн авчрах талаар нэг бодож үзэцгээе.

Хувь хүний амьдралд энэ нь илүү их хүч, илүү их аз жаргал, илүү их эрүүл энхийг авчрах болно. Бусдад сүнслэг байдлаар илүү сайн нөлөөлж чаддаг хүмүүс номхон дөлгөөн, даруу төлөв байдлаар Христтэй хамт нэг буулганд орсон хүмүүс юм. Ийм хүмүүс Түүнд үйлчлэх үйлчлэлээсээ бүрэн дүүрэн байдал ба амар тайвныг олдог. Бидний сүнслэг амьдралд сайн зүйл махан биеийн эрүүл мэндэд ч бас сайн байх аж. Их Британийн Анагаах Ухааны Сэтгүүлд “Сүнснээс ангид оршдог эд эс гэж хүний биед нэг ч байхгүй” гэж бичжээ. Доктор Паул Тоурнэр олон сарын турш цус багадаа өвчнөөр өвчилсөн нэгэн өвчтөний тухай бичсэн байдаг. Гэтэл түүний өвчин гайхалтайгаар эдгэрч цус нь хэвийн болсон байлаа. Судалгаа хийж үзтэл тэр эмэгтэй сүнсний хямралд орсон байсан буюу тухайлбал тэрээр удаан хадгалагдсан хорсол зэвүүцлээ тайлж уучлан өршөөсөн байв. Тийм ээ. номхон зөөлөн байдал эрүүл мэндэд тустай аж.

Нэг нэгнийхээ өмнө буруугаа хурдан хүлээдэг гэр бүл ямар байх талаар бодоцгооё. Бүх юм үргэлж хэвийн байхгүй нь мэдээж. Гэвч ийм гэр бүлийн хүмүүс уур уцаарыг удаан даран хадгалдаггүй ажээ. Тэд нэг нэгнээ үнсэж, алдаагаа засаж залруулах урлагт суралцсан байдаг. Есүс чухам ийм гэр бүл дотор байх дуртай.

Нутгийн чуулганы тухайд номхон зөөлөн байдал бол сэргэн мандалтанд хүргэх зам юм. Номхорч зөөлөрсөн сэтгэлийн нулимс асгаран буух ивээл хайрын эхлэл байдаг нь сүнслэг ертөнцийн тогтсон хууль юм.

Бид шинэ байшин барих, шинэ үйл ажил эхлүүлэх, шинэ арга барил турших зэрэг ямар нэгэн зүйл хийхийг эхлээд хичээдэг боловч Бурхан гэмшихийг, даруу төлөв болохыг хүлээдэг. Биднийг гэмшиж эхлэх үед ивээл хайр урсан ирэх болно.

“Миний нэрээр дуудагдсан Миний хүмүүс өөрсдийгөө даруу байлган, залбирч, Миний нүүрийг эрэлхийлж, бузар муу замуудаасаа эргэх аваас, Би тэнгэрээс сонсож, тэдний нүглийг уучлан, тэдний газар нутгийг эдгээнэ” (Шастирын дэд 7:14).

Итгэгч хүмүүс номхон зөөлөн байдлыг харуулбал энэ нь бизнесийн ертөнцөд ямар нөлөө үзүүлэх талаар бодоцгооё. Дэлхийн хүмүүс номхон зөөлөн биш байдаг ба өөрсдийн хүч чадлыг бусдынхаа эсрэг ашиглах дуртай. Гэвч тэд уурыг нь уураар хариулдаггүй, буруугаа хүлээж уучлал гуйдаг, Эзэн Есүсийн хайр ба нигүүслийг харуулдаг хүн рүү дайрах үедээ гайхан балмагддаг. Энэ бол өнөөгийн хатуу ширүүн наймааны ертөнцөд Христийг тодоор харуулж чаддаг ер бусын амьдрал юм.

Эзэн минь, намайг номхруулаач!

Хэдэн жилийн өмнө сайн мэдээ дэлгэрүүлэгчдийн чуулга уулзалт дээр би нэгэн чин үнэнч залуу итгэгчийн “Эзэн минь намайг номхруулаач” хэмээн залбирахыг сонсож билээ. Энэ гуйлт намайг эвгүйцүүлсэн юм. Тэр үеийг хүртэл би амьдралдаа хэзээ ч ингэж залбирч байгаагүй бөгөөд тэгж залбирахад ч бэлэн биш байсан. Гэвч залуу дагалдагчийн сэтгэлээс урсан гарч байгаа тэр гал халуун үгс амьдралд маань номхон зөөлөн байдал хичнээн их хэрэгтэй байгааг ойлгуулж ухааруулсан юм. Номхон зөөлөн байдал нь сүнслэг ертөнцийн нэг амин чухал хэсэг болохыг надад ойлгуулсан. Харин одоо энэ залбирал хүсэл эрмэлзлэлээр дүүрэн зүрх сэтгэлийн байнгын залбирал болсон билээ: **“ЭЗЭН МИНЬ, НАМАЙГ НОМХОРУУЛААЧ”**

ЖИНХЭНЭ ДАГАЛДАЧ НОМЫН ГАРЫН АВАЛГА

Өмнөх үг

Энэхүү гарын авлага нь Жинхэнэ дагалдагч номтой хамт хэрэглэх зориулалттай арван хоёр хичээлээс бүрдэх бөгөөд итгэгч нөхөддөө Шинэ Гэрээнд гарган тавьсан дагалдагчийн зарим зарчмыг олж нээхэд туслах зорилгоор бичив.

Уг гарын авалгы дараах байдлуудад үр дүнтэй ашиглаж болно:

1. **ХУВИЙН БИБЛИ СУДЛАЛД:** Суралцагч нь хичээл тус бүрийг зааврын дагуу хийж гүйцээнэ. Хичээл бүр Жинхэнэ дагалдагч номын аль хэсгээс хэзээ уншихыг хэлж өгөх ба хичээл тус бүрийг хийж дуусгахад нэг цаг орчим шаардагдана.
2. **ГАНЦААРЧЛАН ДАГАЛДАГЧ БЭЛТГЭХЭД:** Бусдыг итгэлээр өсгөхөд туслах ажил эрхэлдэг хүмүүс дагалдагч болгохоор сургаж байгаа хүндээ уг хичээлүүдийг даалган өгөөд дараа нь сурсан зарчмуудынх нь талаар ярилцаж болно.
3. **БИБЛИ СУДЛАЛЫН БҮЛЭГТ:** Уг гарын авлага нь 12-13 долоо хоногийн хичээлд тохирно. Сурагч бүр эхлээд хичээлийг бие даан үзээд олж мэдсэн зүйлийнхээ талаар ярих бэлтгэлтэйгээр ирнэ. Нэг цагийн хичээлийг ярилцах маягаар явуулах нь илүү тохиромжтой. Ярилцлага гучин минутад явагдаж дуусх тохиолдолд үлдсэн цагийг өөр зүйлд зориулж болно. Жишээ нь, бүлгийн ахлагч тухайн хичээлийн агуулгыг нарийвчлан талбарлах, эсвэл бүлгээрээ сурагчдын хэрэгцээнүүдийн төлөө, чуулганы төлөө, аврагдаагүй хүмүүс төлөө гэх мэтээр залбирч болно.

Агуулга

1. Дагалдагч байхын утга учир
2. Байгаа бүхнээсээ татгалз
3. Дагалдагч болоход учирдаг саад бэрхшээлүүд
4. Дагалдагч бол итгэмжит нярав юм
5. Хичээл зүтгэл
6. Итгэл
7. Залбирал
8. Сүнслэг тулаан
9. Дэлхийг эзэгнэх эрх мэдэл
10. Дагалдагч ба гэрлэлт
11. Төлөх үнээ тооц
12. Тарчлал зовлонгийн хар сүүдэр
13. Дагалдагч байхын хариу шагнал

14. Таны эд баялаг хаана байдаг вэ?
15. Таны эд баялаг хаана байдаг вэ?
16. Ажил хэрэгт хичээнгүй бай
17. Олж болно харин бүү зуур
18. Ямар хор хохиролтой вэ?
19. Үл хөдлөх эд хөрөнгө
20. Энэ талаар Библид юу гэж заадаг вэ?

21. ЭЗЭН МИНЬ, НАМАЙГ НОМХОРУУЛААЧ!
22. Эзэн номхорсон зүрхийг илүү үнэлдэг
23. Бурхан биднийг номхорсон зүрхтэй байхыг хүсдэг

Нэгдүгээр хичээл
ДАГАЛДАГЧ БАЙХЫН УТГА УЧИР

1. Лук 14:26-дээрх үгээр Есүс ямар санааг илэрхийлсэн бэ?

Яагаад Есүсийн хэлсэн энэ үгэнд захирагдахгүйгээр Түүний дагалдагч байх боломжгүй вэ?

2. Матай 16:24-т Есүсийн дагалдагч болох хүсэлтэй хүнд тавигдах гурван шаардлагыг бичжээ. Шаардлага тус бүрийг олж тогтоон товч тайлбарлана уу. Дараа нь шаардлага тус бүрийг итгэгч хүн ямар байдлаар зөрчиж болохыг харуулсан жишээг олно уу.

Шаардлага

Тодорхойлолт

Зөрчил

3. Иохан 13:35-д Есүс дагалдагч хүний ямар онцлог шинжүүдийг өгсөн бэ?

Таны бодлоор эдгээр онцлог шинжүүд биднийг Есүсийн дагалдагч мөн гэдгийг бусдад яаж харуулдаг вэ?

4. Жинхэнэ дагалдагч хүний амьдралд Библи ямар ач холбогдолтой болохыг тайлбарлана уу. (Иохан 8:31)

Дагалдагч хүн Бурханы Үгэнд ямар хандлагаар ханддаг болох вэ?

5. Лук 14:33-т өгүүлснээр бол Эзэн Есүсийн дагалдагч хүн яах ёстой вэ?

Хэрэв үүнийг хийж чадвал амьдралд тань ямар тодорхой өөрчлөлтүүд гарах вэ?

Энэ тал дээр Есүст дуулгавартай байх үед ямар ашиг тус гарах вэ?

6-7-р асуултуудад хариулахын өмнө *Жинхэнэ дагалдагч* номын ДАГАЛДАГЧ БАЙХЫН УТГА УЧИР бүлгийг уншина уу.

6. Уг бүлгээс авсан доорх мэдэгдлүүдийг хүлээн зөвшөөрч байгаа эсэхээ хэлж учир шалтгаанаа тайлбарлана уу.

“Жинхэнэ Христэд итгэл гэдэг Эзэн Есүс Христэд өөрийгөө бүхэлд нь зориулах итгэл юм.”

“Галготын толгой дээр Эзэн Есүсийн өргөсөн золиосны хариуд Түүнд үг дуугүй захирагдахаас өөр зохистой зүйл гэж үгүй”

“.....өөрсдийгөө энэ насны амьдралын сайн сайхан бүхнийг эдлэх эрхтэй гэж боддог”

7. 1-5-р асуултуудаар гаргаж тавьсан дагалдагч байхын долоон утга учрыг нэрлэн бичнэ үү.

Хоёрдугаар хичээл

БАЙГАА БҮХНЭЭСЭЭ ТАТГАЛЗ

1. Эзэн Есүс Лук номын 14:33-т дагалдагч хүний ямар байдлыг гаргаж тавьсан бэ?

Түүний хэлсэн энэ үг ямар утгатай вэ?

2. Матай 6:19-21 ба Лук 12:33-34-ийг уншиж судална уу. Эзэн Есүс дагалдагчдадаа юу гэж тушаасан бэ?

Эд баялаг хураах газар болон өөрийгөө Бурханд үнэнчээр зориулах хоёр хоорондоо ямар холбоотой вэ?

3. Эртний чуулганы итгэгчид Есүсийн тушаалуудыг яаж даган биелүүлдэг байсан бэ? (Үйлс 2:44-45)

4-5-р асуултуудыг хийхээс өмнө *Жинхэнэ дагалдагч* номын БАЙГАА БҮХНЭЭСЭЭ ТАТГАЛЗ бүлгийг уншина уу.

4. Эзэний үгийг шууд утгаар нь ойлгохын эсрэг хэрэглэдэг дараах маргаануудыг уншина уу. Маргаан тус бүрийг өөрийн үгээр няцааж үүнийг дэмжих Библийн ишлэлүүдээс иш татна уу.

“Хэрэв бид байгаа бүхнээсээ татгалзвал өлсөж үхэх болно”

“Би ар гэрийнхээ ирээдүйн хэрэгцээг хангах ёстой.”

“Хэрэв итгэгч хүн бүр байгаа бүхнээсээ татгалзвал Эзэний үйлсийг хэн санхүүжүүлэх вэ?”

“Хэрэв баян чинээлэг итгэгч хүн гэж байхгүй бол дээд зиндааны хүмүүст сайн мэдээг хэн хүргэх вэ?”

5. Байгаа бүхнээсээ татгалзсан хүний дөрөн онцлог шинжийг уншиж судална уу (Жинхэнэ дагалдагч номд нэрлэгдсэн)
6. Таны хувьд Христийг дагахын тулд байгаа бүхнээсээ татгалзана гэдэг ямар утгатай вэ? Өөрийн үгээр хариулна уу.

7. Лук 14:33-ыг шууд утгаар нь ойлгож хэрэгжүүлбэл энэ нь амьдралын дараах хүрээ тус бүрд яаж нөлөөлөх вэ? Тодорхой бичнэ үү.

Ажил ба боловсрол

Гэр бүлийн амьдрал

Сүм чуулган

Дэлхий ертөнц

Гуравдугаар хичээл

ДАГАЛДАГЧ БОЛОХОД УЧИРДАГ СААД БЭРХШЭЭЛҮҮД

1. Лук 9:57-62-ыг уншиж судлаад Есүсийн дагалдагч болж болох байсан гурван хүнийг олно уу. Эхний хүн юу хийхэд бэлэн гэсэн бэ? (57-р ишлэл)
Эзэн юу гэж хариулсан бэ? (58-р ишлэл). Яагаад ингэж хариулсан бэ?
2. Эзэн хоёр дахь хүнд юу гэж тушаасан бэ? (59-р ишлэл). Тэр хүн хариуд нь юу хүссэн бэ?
Есүс “Үхэгсдийг үхэгсдээр нь оршуулуул” гэж ямар утгаар хэлсэн бэ?
Есүс юуг эн тэргүүнд тавих ёстой гэсэн бэ?
3. Гурав дахь хүн Есүсийг дагахын өмнө ямар болзол тавьсан бэ?
4. Энэ гурван хүн юугаараа хоорондоо адил юугаараа өөр байна вэ?
Сүүлчийн хоёр хүн хоёулаа “Эзэн минь.....эхлээд би...” гэсэн. Энэ үг тэдний тухай танд юуг өгүүлж байна вэ? Өөрсдийнх нь хэлсэн үг хэрхэн зөрчилдөж байна вэ?

5. *Жинхэнэ дагалдагч* номын **ДАГАЛДАГЧ БОЛОХОД УЧИРДАГ СААД БЭРХШЭЭЛҮҮД** бүлгийг уншиж хүмүүст ямар нэр өгснийг олж тогтооно уу. Нэр тус бүр тухайн хүндээ яагаад зөв тохирсон бэ?

6. Дээр дурьдсан гурван хүнийг жинхэнэ дагалдагч болоход юу голлож саад болсон бэ?

Энэ гурван төрлийн саад таны амьдралд яаж тохиолдож болохыг жишээгээр хэлнэ үү.

7. Есүс Христэд өөрийгөө зориулах таны үнэнч зориулалтад юу саад болдог вэ?

Үүнийг зайлуулахын тулд та юу хийх вэ?

Дөрөвдүгээр хичээл

ДАГАЛДАГЧ БОЛ ИТГЭМЖИТ НЯРАВ ЮМ

Лук 16:1-13-ыг анхааралтай уншиж судлаад дараах асуултуудад хариулна уу.

1. Эзэн Есүс хэнд хандан ярьж байна вэ?

Түүний ярьсан сургаалт зүйрлэлийг өөрийн үгээр товлон дүгнэнэ үү.

2. Шударга бус нярвын үйлдлийг юу өдөөсөн бэ? (3-4-р ишлэлүүд)

Тэр баян хүн өөрийн нярвын үйлдлийг яагаад ухаалаг үйлдэл гэж бодсоныг өөрийн бодлоор хэлнэ үү.

3. 8-р ишлэлийн б хэсэгт бичсэн Эзэний хэлсэн үгийг уншиж тунгаан бодно уу. “энэ үеийн хөвгүүд”, “гэрлийн хөвгүүд” гэж хэн бэ? Ирээдүйн тухай тэдний үзэл бодлыг харьцуулна уу.

Эзэн Есүс яагаад энэ үеийн хөвгүүдийг гэрлийн хөвгүүдээс ухаалаг гэсэн бэ?

4. Өнөөгийн хүмүүс ирээдүйдээ яаж бэлтгэдгийг нэрлэн бичнэ үү.

Эзэний хэлсэн ёсоор бол дагалдагч хүмүүс ирээдүйдээ яаж бэлтгэх ёстой вэ? (9-р ишлэл)

“зөвт бус байдлын эд баялаг” гэж юу вэ?

Үүнийг “найз нөхөдтэй” болоход яаж ашиглах вэ? Тодорхой бичнэ үү.

5. Өмч хөрөнгөд хандах хандлага бидний зан чанарыг ямар байдлаар сорьдог вэ? (10-р ишлэл)

Итгэгч хүн “жижиг хэрэгт” итгэмжит байна, жижиг хэрэгт “шударга бус” байна гэдэг ямар утгатай вэ?

6. “Жинхэнэ эд баялаг” гэж юу вэ? (11-р ишлэл). Түүнийг хариуцахын тулд тавигдах шаардлага юу вэ?

Таны бодлоор итгэгч хүнд үнэндээ юу харъяалагддаг вэ? (12-р ишлэл). Түүнийг хүлээн авахад юу шаардагдах вэ?

Үйлчиллийн талаар Эзэн ямар зарчмыг гарган тавьсан бэ? (13-р ишлэл). Энэ нь нярав байхтай ямар холбоотой вэ?

Жинхэнэ дагалдагч номын **ДАГАЛДАГЧ БОЛОХОД УЧИРДАГ СААД БЭРХШЭЭЛҮҮД** бүлгийг уншиж нэмэлт ойлголтуудаа 1-6-р асуултууд дээр бичнэ үү.

7. Христийн дагалдагч хүн яагаад нярав байдгийг үүнийг яаж хэрэгжүүлэх ёстойг үзсэн хичээл дээрээ үндэслэн тайлбарлаж бичнэ үү.

Та газар дээр Бурханы ашиг сонирхлыг хамгаалах тал дээр ямар өөрчлөлт хийх хэрэгтэй байгаа вэ? Үүнээс өнө мөнхийн болон сүнслэг ямар үр дүн гарах вэ?

Тавдугаар хичээл

ХИЧЭЭЛ ЗҮТГЭЛ БА ИТГЭЛ

1. Хичээл зүтгэл гэдэг үгийг тайлбар толиос хараад өөрийн үгээр тодорхойлон бичнэ үү.

Таны бодлоор энэ үгийг Эзэн Есүс Христийн дагалдагч яаж хэрэгжүүлэх ёстой вэ?

2. Эзэн Есүсийн газар дээрх амьдрал хичээл зүтгэлийг хэрхэн харуулж байсан бэ? (Лук 12:50, Иохан 2:17, 9:4).

3. Жинхэнэ дагалдагч номын **ХИЧЭЭЛ ЗҮТГЭЛ** бүлгийг уншаад дараах өгүүлбэр тус бүрийг тайлбарлана уу.

“Өнөө үед шашны амиа золиослогчдын бүлэг болон хэт улайрагсад хичээл зүтгэлийг Есүст итгэгчдээс илүү их хэмжээгээр харуулж байгаа нь хорин нэгдүгээр зууны сүм чуулганы нэг ичгүүр юм”

“Хэрэв Эзэн Есүс бидэнд жоохон ч атугай үнэ цэнэтэй юм бол бидний хувьд бүх зүйл маань байх ёстой”

Жинхэнэн дагалдагч номын ИТГЭЛ бүлгийг уншаад итгэлийн амьдралд хамаатай зарчмуудаас доод тал нь тавыг олж бичнэ үү.

4. “Итгэлээр амьдрах”, “харж байгаа зүйлээр амьдрах”-ын ялгааг энгийн үгээр тайлбарлана уу.

5. Дагалдагч хүн итгэлээ яаж нэмэгдүүлэх вэ?

6. Таны амьдралын ямар зүйлс Христийн төлөөх хичээл зүтгэлийг тань бууруулдаг вэ?

Хичээл зүтгэлээ нэмэгдүүлэхийн тулд ямар зохицуулалтууд хийх хэрэгтэй байгаа вэ?

Та өөрийгөө ямар хэмжээгээр “харж байгаа зүйлээр биш харин итгэлээр амьдардаг” гэж хэлж чадах вэ?

Илүү их итгэлээр амьдрахын тулд ямар өөрчлөлтүүд хийх хэрэгтэй байгаа вэ?

Зуравдугаар хичээл

ЗАЛБИРАЛ

Жинхэнэ дагалдагч номын ЗАЛБИРАЛ бүлгийг уншаад залбирлын зарчмуудыг анхааралтай судална уу. Дараа нь доорх асуултуудад өөрийн үгээр хариулаарай.

1. Яагаад хамгийн шилдэг залбирал дотоод сэтгэлийн хэрэгцээнээс урган гардаг вэ?

Бидний “залбирлын амьдрал” гүехэн байх хандлагатай байдгийн учир шалтгаануудыг нэрлэнэ үү.

2. “...үнэн зүрхээр ойртон очих” (Еврей 10:22) гэдэг ямар утгатай вэ?

Бид ямар байдлуудаар залбиралд хоёр нүүр гаргах хандлагатай байдаг вэ?

3. Залбирал зарим ямар байдлуудаар бидэнд үнэтэй тусдаг вэ? Таны бодлоор Бурхан яагаад ийм залбирлыг илүү үнэлж хүндэлдэг вэ?

Мацаг барилт нь залбиралтай ямар холбоотой вэ?

4. Залбирлыг яаж буруу ашиглаж болох вэ? (Иаков 4:3) Таны залбирлын гол санаа юу байх ёстой вэ?

Бид залбирлаар дамжуулан Бурханыг яаж хүндлэн дээдлэх вэ?

5. “Эзэн Есүсийн нэр”-ээр залбирна гэдэг ямар утгатай вэ?

6. Доор бичигдсэн зүйлс тус бүр залбиралд яагаад чухал вэ?

“Бурханы өмнө гэм буруугаа дор дор нь хүлээх”

“Христ дотор байх”

“Тодорхой зүйлийн талаар залбирах”

7. Христийн дагалдагчийн хувьд залбирал таны амьдралд ямар байр эзэлдгийг дүрслэн бичнэ үү.

Дээр дурьдагдсан залбирлын зарчмуудын алийг нь та хамгийн их орхигдуулдаг вэ?

Илүү үр нөлөөтэй залбирахын тулд ямар алхмууд хийх вэ?

Долдугаар хичээл

СҮНСЛЭГ ТУЛААН

1. Эзэн Есүсийн дагалдагчид ямар зөрчил тэмцэлд оролцдог вэ? (Ефес 6:11-12)

Дайснууд ямар бодлого ашигладаг вэ? (2 Коринт 11:14-15)

Таны бодлоор дайснаа болон түүний бодлогыг мэдэх нь яагаад чухал вэ?

2. Итгэгч хүн сүнслэг тулааны ямар зэвсэгтэй вэ? (Ефес 6:13-20)

Эдгээр зэвсгүүд ямар үр нөлөөтэй вэ? (2 Коринт 10:3-5)

Та эдгээр зэвсгийн үр нөлөөг өдөр тутмынхаа амьдралд яаж батлан харуулж байгаа вэ?

3. 2 Тимот 2:3-4-ийг уншиж судална уу. Паул Тимотыг юу гэж ятгасан бэ? Цэргийн алба хааж байгаа цэрэг хүний онцлог шинжүүд юу вэ? (4-р ишлэл)

Христийн цэрэг итгэгч хүнийг “урхидаж” болох зүйлсийг нэрлэнэ үү. Эдгээрийн аль нь танд хамгийн ихээр заналхийлж байгаа вэ?

4. Цэрэг эрс эв нэгдэлгүй байх тохиолдолд армид ямар асуудлууд үүсдэг вэ?

Яагаад эв нэгдэлгүй байдал итгэгчдийн сүнслэг тулаанд ноцтой асуудал үүсгэдэг вэ?

Филиппой номын 2-р бүлгийг уншаад эв нэгдэлд хүргэх гол зарчмыг олж тогтооно уу. Эдгээрийг яаж хэрэгжүүлэх болох жишээ хэлнэ үү.

5. Дайн тулааны үед өөрийгөө золиосолсон амьдрал яагаад шаардагддаг вэ?

Энэ нь итгэгч хүмүүсийн сүнслэг тулаанд яагаад мөн адил шаардагддаг вэ?

Христийн цэргүүд ямар золиоснууд хийж амьдрахаар дуудагдсан бэ?

6. Жинхэнэ дагалдагч номын СҮНСЛЭГ ТУЛААН бүлгийг уншиж 1-5-р асуултуудтай холбоотой нэмэлт ойлголтуудаа бичнэ үү. Дайн тулаанд шаардагддаг найман зүйлийг олж тогтоогоод зүйл тус бүр яагаад итгэгчдийн сүнслэг тулаанд бас шаардагддагийг товч дүгнэн бичнэ үү.

7. Таны амьдралын ямар зүйл итгэгчдийн сүнслэг тулаанд нухацтай ханддагийг харуулдаг вэ?

Есүс Христийн илүү сайн цэрэг болохын тулд та ямар бодлого барьдаг вэ?

Наймдугаар хичээл

ДЭЛХИЙГ ЭЗЭГНЭХ ЭРХ МЭДЭЛ

1. Матай 28:18-20, Марк 16:15, 2 Коринт 5:18-20-ийг уншиж судална уу. Есүс Өөрийн дагалдагчдыг ямар утгаар дэлхийг эзэгнэх эрх мэдэлтэй гэсэн бэ?

2. Дэлхий ертөнцөд Христийг мэдүүлэхийн тулд бид ямар хүсэл эрмэлзлэлтэй байх ёстой вэ? (Матай 22:37,39, 1 Коринт 13:1-3, 2 Коринт 5:14-15).

Энэ хүсэл эрмэлзлэл яагаад цорын ганц зөв тохирох хүсэл эрмэлзлэл вэ?

Элч Паул энэ хүсэл эрмэлзлэлийг яаж тусган харуулсан бэ? (Үйлс 20:24, 2 Коринт 12:15)

3. Эртний дагалдагчид ямар арга барилаар хүмүүст сайн мэдээг хүргэдэг байсан бэ? (Марк 16:15,20, Үйлс 8:4).

Тэд хаана сайн мэдээг тунхаглах байсан бэ?

4-7-р асуултуудад хариулахын өмнө 1 Коринт номын 7-р бүлгийг уншина уу.

4. Христэд итгэлийг өөр ямар арга замаар сурталчилж болох вэ? (Марк 3:14, 2 Тимот 2:2).

Таны бодлоор энэ арга зам сайн мэдээг олон түмэнд тунхаглан зарлахтай яагаад адил хэмжээгээр чухал вэ?

5-6-р дасгалыг хийхийн өмнө Жинхэнэ дагалдагч номын ДЭЛХИЙГ ЭЗЭГНЭХ ЭРХ МЭДЭЛ бүлгийг уншина уу.

5. Дараах өгүүлбэрүүдийн утгыг тайлбарлана уу.

“Хүн бид хүн биеийг олж төрөөд дараа нь өт хорхой болж дуусах нь хэзээ ч Түүний (Бурханы) хүсэл байгаагүй”

“Христэд итгэгч хүний дуудлага бол бусад бүх дуудлагаас илүү эрхэм дээд дуудлага юм. Үүнийг ухааран ойлгох үед бидний амьдрал шинэ өндөрлөгт хүрэх болно”

6. Есүсийн дагалдагчид дэлхий ертөнцөд Христийг тунхаглахдаа зургаан зарчмыг баримтлах ёстойг Жинхэнэ дагалдагч номд иш татсан байгаа. Эдгээрийг олж тогтооно уу.

7. Бурхан бидэнд дэлхийг эзэгнүүлэхээр дуудсан. Та үүнийг яаж хүлээн авч хариулах вэ? (Энэ дуудлага таны амьдралд үнэндээ яаж нөлөөлдөг тухай товч бичнэ үү)

Дэлхий ертөнцөд сайн мэдээг тараах хоёр гол зарчимд та яаж биечлэн оролцдог вэ?

Есдүгээр хичээл

ДАГАЛДАГЧ БА ГЭРЛЭЛТ

1. Бурхан яагаад гэрлэлтийг хүн төрөлхтөнд зориулан үүсгэсэн бэ?

Эхлэл 1:28

Эхлэл 2:18

1 Коринт 7:2

2. Бурхан гэрлэлтийг юу гэж үздэг вэ?

Сургаалт үгс 18:22

Еврей 13:4а

Номлогчийн үгс номын 4:9-12-ыг уншина уу. Гэрлэлт нь Эзэнд үйлчлэх дагалдагчийн үйлчлэлд ямар ашиг тустай вэ?

Гэрлэлт нь Христэд үйлчлэх үйлчлэл, үнэнч зүтгэл, цэвэр ариун амьдралд яагаад харшилдаггүй болохыг уншиж судалсан зүйл дээрээ үндэслэн товч бичнэ үү.

3. Матай 19:10-12-ыг уншин судалж гэрлэхгүй байж болох гурван нөхцөл байдлыг тодорхойлно уу.

“..тэнгэрийн хаанчлалын төлөө өөрийгөө тайган болгох..” гэдэг ямар утгатай вэ?

4-7-р асуултуудад хариулахын өмнө 1 Коринт 7-г анхааралтай уншина уу.

4. Элч Паул хараахан гэрлээгүй байгаа хүмүүсийг өөртэй нь адил ганц бие хэвээр байхыг хүсэж байгаагаа илэрхийлжээ (1 Коринт 7:7а,8). 1 Коринт 7:26-35-д Паулын бичсэн ганц бие байхын учир шалтгаануудыг нэрлэн бичнэ үү.

Тиймээс Паул хэрэв итгэгч хүмүүс гэрлэвэл Бурханы хүслээс гадуур явах болно эсвэл арай бага хэмжээгээр “сүнслэг” байх болно гэсэн үү? (Өгөх хариултаа тайлбарлана уу)

5. Итгэгч хүн гэрлэхгүй байх эсэхийг юу шийдэх вэ? (1 Коринт 7:7б, Матай 19:12)

Аливаа хүн өөрийгөө ганц бие амьдралаар амьдарч чадна гэдгийг яаж мэдэх вэ? (1 Коринт 7:9).

6. Гэрлэсэн итгэгч хүн яаж амьдрах ёстой вэ? (1 Коринт 7:29-31). Энэ нь ямар утгатай болохыг энгийн үгээр бичнэ үү.

Жинхэнэ дагалдагч номын **ДАГАЛДАГЧ БА ГЭРЛЭЛТ** бүлгийг уншаад 1-6-р асуултуудтай холбоотой нэмэлт бодлуудаа бичнэ үү.

7. Гэрлэлт нь ямар тохиолдолд хувь хүнд зориулсан Бурханы зорилгын заналт дайсан болох вэ?

Ганц бие хүмүүс: Бурхан таныг гэрлүүлэхийг эсвэл ганц бие байлгахыг хүсэж байгаагийн аль нь болохыг олж тогтоохын тулд та ямар гол зарчмыг удирдлага болгох вэ?

Гэрлэсэн хүмүүс: Христ болон Түүний үйлсэд өөрийгөө үнэнчээр илүү их зориулахын тулд гэр бүлийнхээ амьдралд ямар өөрчлөлт хийх хэрэгтэй вэ?

Аравдугаар хичээл

ТӨЛӨХ ҮНИЙГ ТООЦ

Лук 14:25-35-ыг анхааралтай уншаад 1-4-р асуултуудад хариулна уу.

1. Есүс Өөрийнх нь дагалдагч байж болох бүх хүнээс юуг шаарддаг вэ?

26-р ишлэл

27-р ишлэл

2. 28-32-р ишлэлүүдэд Есүс ямар хоёр сургаалт зүйрлэлийг хэрэглэсэн бэ? Сургаалт зүйрлэл тус бүрийг товчлон бичнэ үү. Дараа нь сургаалт

зүйрлэл тус бүр итгэгч амьдралын аль талыг дүрслэн харуулсныг хэлээд эцэст нь сүнслэг гол сургамж юу байгааг товч дүгнэн бичнэ үү.

Товч дүгнэлт

Итгэгч амьдралтай төстэй байдал

Сургамж

28-30-р ишлэлүүд

31-32-р ишлэлүүд

Энэ хоёр сургаалт зүйрлэл ямар байдлаар 26-27-р ишлэлүүдэд шаардсан зүйлийг дүрсэлсэн байна вэ?

3. 26-32-р ишлэлүүдэд Есүсийн хэлсэн үгийг 33-р ишлэл хэрхэн дүгнэсэн байна вэ?
4. 34-35-р ишлэлүүдийг уншина уу. “Давс” гэдэг үг шилжсэн утгаараа юуг илэрхийлж байна вэ?

Есүс давсны дүрслэлээр дагалдагч байх талаар үнэндээ юу гэж хэлсэн бэ?

Итгэгч хүн ямар байдлаар “амтаа” алдаж болох вэ?

Жинхэнэ дагалдагч номын ТӨЛӨХ ҮНИЙГ ТООЦ бүлгийг уншаад нэмэлт ойлголтуудаа 1-4-р асуултууд дээр бичнэ үү.

5. Иохан 2:23-26-г унш. Есүс улаан буудайн үрээр үндсэн ямар зарчмыг дүрслэн харуулсан бэ?

Энэ зарчим Эзэн Есүс дээр хэрхэн хэрэгжсэн бэ?

Энэ зарчим Түүний дагалдагчид дээр яаж хэрэгжих ёстой вэ? Хариу шагнал нь юу байх вэ?

6. ТАРЧЛАЛ ЗОВЛОНГИЙН ХАР СҮҮДЭР ба ДАГАЛДАГЧ БАЙХЫН ХАРИУ ШАГНАЛ бүлгүүдийг уншина уу. Доор бичигдсэн өгүүлбэр тус бүртэй санал нийлж байгаа эсэхээ хэлж яагаад гэдгээ тайлбарлана уу.

“Есүс Христэд өөрийгөө бүрэн зориулсан хүнд амьд байх уу үхэх үү гэдэг тийм ч чухал биш болдог ажээ”

“Хүн бүр тамлагдан алагдах албагүй..... Гэвч итгэгч хүн бүр тамлагдагчийн сэтгэлтэй, тамлагдагчийн хичээл зүтгэлтэй, тамлагдагчийн үнэнч итгэлтэй байж чадах ёстой”

7. Эзэн Есүс Түүний дагалдагч байх үнийг тооцох тал дээр таныг хэрхэн уриалж байсан бэ?

Христэд өөрийгөө бүрэн зориулахад саад болдог ямар зүйлс таны амьдралд байдгийг нэрлээд эдгээр саадуудыг давж гарахын тулд хийх алхмуудаа бичнэ үү.

Арван нэгдүгээр хичээл

ТАНЫ ЭД БАЯЛАГ ХААНА БАЙДАГ ВЭ?

1. Матай 6:19-21-ийг унш. Эзэн Есүс дагалдагчдадаа юуг хориглосон бэ?

21-р ишлэлийн утга санааг энгийн үгээр тайлбарлана уу.

2. Ажил хэрэгт хичээнгүй байх тал дээр элч Паул ямар үлгэр жишээ үзүүлж юу гэж зөвлөсөн бэ? (Үйлс 18:1-3, 2 Тессалоник 3:8,10)

“Итгэгч хүн мөнгийг хичнээн ч хэмжээгээр олж болох ажээ” Энэ нь ямар нөхцөлд зөв байх вэ?

Сургаалт үгс 13:11

Сургаалт үгс 22:16

Дуулал 62:10

Матай 6:24

Матай 6:33

1 Тимот 5:8

3. Бурхан биднээс эд баялгаа яаж ашиглахыг хүсдэг вэ?

Матай 6:19-21

1 Коринт 4:1-2

1 Тимот 6:6-8

1 Тимот 6:17-19

Итгэгч хүн эд баялаг хураах нь яагаад буруу вэ?

Сургаалт үгс 3:27-28

Малахи 3:8

1 Иохан 3:17

ТАНЫ ЭД БАЯЛАГ ХААНА БАЙДАГ ВЭ? бүлгийг уншаад нэмэлт ойлголтуудаа 1-3-р асуултууд дээр бичнэ үү.

4. ҮЛ ХӨДЛӨХ ЭД ХӨРӨНГӨ бүлэгт ирээдүйдээ зориулж хөрөнгө мөнгө хураахыг зөвтгөхөд ашигладаг есөн маргааныг иш татан бичсэн. Эдгээрийн аль нэгийг сонгон авч товч дүгнээд өөрийн үгээр хариулна уу.

5. Эд баялгийн зарим аюулыг нэрлэнэ үү.

Сургаалт үгс 28:20,22

Матай 6:24

Матай 19:23-26

1 Тимот 6:9-10

Иаков 1:10-11

Иаков 5:1-6

6. ЗАЛХУУРЛЫН ЭСРЭГ СЭРЭМЖЛҮҮЛЭГ, БУСДЫГ ШҮҮХИЙН ЭСРЭГ СЭРЭММЖЛҮҮЛЭГ хэсгүүдийг дахин уншаад сэрэмжлүүлэг тус бүр танд ямар хамаатайг өгүүлнэ үү.

7. Та энэхүү хичээлийг яаж амьдралдаа хэрэгжүүлэх вэ? Хийхээр төлөвлөж байгаа алхмуудаа нэрлэнэ үү.

Арван хоёрдугаар хичээл

ЭЗЭН МИНЬ НАМАЙГ НОМХОРУУЛААЧ

1. Номхон хүн болон бардам хүнд хандах Бурханы хандлагуудыг хооронд нь харьцуулна уу. (Дуулал 34:18, 51:17, 138:6, Исаиа 57:15, Иаков 4:6)

2. Христэд итгэх итгэл яагаад номхорсон байдлаас эхэлдэг вэ?

Матай 11:28-30-ыг уншиж судална уу. Буулга гэж юу вэ? Буулга яагаад зөвхөн номхон амьтдад зориулагддаг вэ? Уг ишлэлд Эзэний хэлсэн үг ямар утгатай вэ?

3. Доорх хүмүүс номхон зөөлөн байдлыг амьдралаараа яаж харуулсан бэ?

Давид (Дуулал 32:3-5)

Даниел (Даниел 9:3-19)

Захкай (Лук 19-1-10)

Эзэн Есүс (1 Петр 2:23)

4. Доорх ишлэлүүд номхон зөөлөн байдлын зарим ямар элементийг гаргаж тавьсан бэ?

Матай 18:23-35, Ефес 4:32

Ром 12:17,20,21

Филиппой 2:3, Ром 12:10

Дуулал 32:8-9

5. ЭЗЭН МИНЬ НАМАЙГ НОМХОРУУЛААЧ бүлгийг уншаад номхон зөөлөн байдлын арван гол элементийг тодорхойлно уу. Филиппой 2:6-8-д дүрсэлсэн Христийн амьдралаас эдгээр элементийн аль нь харагдаж байна вэ?

Номхон зөөлөн байдлын
элемент

Христийн амьдралаас хэрхэн
харагдсан нь

6. Таны хувьд амьдралын аль хүрээнд номхон зөөлөн байдлыг харуулахад хамгийн хэцүү байдаг вэ?

Хариултаа тайлбарлана уу.

Гэртээ

Чуулган дээр

Ажил дээр

7. Өдөр тутмын амьдрал дээр ямар үед номхон зөөлөн байдлыг харуулж чаддаггүй вэ? Тийм чиг хандлага болон үйлдлүүдийг тодорхой нэрлэнэ үү.

Энэ тал дээр ямар арга хэмжээ авах вэ? Тодорхой бичнэ үү.